



CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION

ХҮНИЙ ЭРХ

/ЭМХЭТГЭЛ/

Улаанбаатар хот
2014 он

DDC
323.015
X-828

Энэхүү Хүний эрхийн эмхэтгэлийг нь Европын Холбоо, Чехийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилттэй, “Монголын хорих байгууллагуудад хүний эрх болон ардчиллыг хөгжүүлэх, иргэний нийгмийг дэмжих төсөл”-ийн хүрээнд боловсруулан, хэвлүүлэв.

Эх бэлтгэгч: “Тотал пресс” ХХК
Цаасны хэмжээ: А5
Хэвлэлийн хуудас: 6.375 хх
Хэвлэгдсэн тоо: 1000 ширхэг
ISBN: 978-99973-919-0-2

1. Хүний эрх гэж юу вэ?.....	5
2. Амьд явах эрх	10
3. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх	14
4. Өмчлөх эрх	20
5. Хөдөлмөрлөх эрх	25
6. Эд мөнгөний тусламж авах эрх	30
7. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	57
8. Сурч боловсрох эрх	66
9. Өвчтөний эрх	70
10. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх	77
11. Сонгох, сонгогдох эрх	82
12. Эвлэлдэн нэгдэх эрх	91
13. Эрүү шүүлтээс ангид байх эрх	97
14. Хохирол нөхөн төлүүлэх	104
15. Хууль зүйн туслалцаа авах эрх	117
16. Шударга шүүхээр шүүлгэх эрх	123
17. Шашин шүтэх, эс шүтэх эрх	129
18. Иргэдийн мэдэх эрх	134
19. Хүүхдийн эрх	141
20. Эмэгтэйчүүдийн эрх	146
21. Жендэрийн эрх тэгш байдал	151
22. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх	156
23. Үндэстний цөөнхийн эрх	164
24. Хохирогчийн эрх	167
25. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх	172
26. Хүн худалдаалах гэмт хэрэг ба Хүний эрх	179
27. Бизнес ба хүний эрх	187
28. Ажлын байран дахь бэлгийн дарамт	190
29. Хүний эрх ба төрийн үүрэг	193
30. Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах нь	198

ХҮНИЙ ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?



Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцах ёстой.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын нэгдүгээр зүйл

Хүний эрхийн үндсэн зарчмууд:

Тэгш байх

Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнэтэй байж, адил хүндэтгэлийг эдэлнэ.

Ялгаварлан гадуурхахгүй байх

Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдлаас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй.

Түгээмэл, салшгүй байх

Хүн оршин байгаа цагт эрхийг хүнээс тусгаарлах, салгах боломжгүй бөгөөд хүнээс салшгүй ойлголт юм. Хүний эрх нь ертөнцийн өнцөг, булан бүрт амьдарч байгаа хүн бүрт хамаатай. Иймд бүх хүн ялгаваргүйгээр тэгш хүртэх түгээмэл шинж чанартай.

Хүн үнэ цэнэ, нэр төртэй байх

Хүний үнэ цэнэ, нэр төр нь бүх хүмүүс хүн болж төрснийхөө хувьд ижил үнэлэгдэж, адил хүндлэл хүлээнэ. Бүх хүн нас, соёл, угсаа гарал, арьс өнгө, хүйс, хүйсийн чиг баримжаа, хэл, боломж чадвар, нийгэмд эзлэх байр суурь, иргэний харьяалал болон улс төрийн үзэл бодлоос үл хамааран ижил хүндлэлийг хүлээнэ.

Хуваагдашгүй байх

Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл, хуваагдашгүй байдаг.

Харилцан хамааралтай байх

Хүний эрх нь орон гэр, зах, сургууль, ажлын байр, зэрэг газар бүрт, амьдралын бүхий л хүрээг хамардаг. Өөрөөр хэлбэл аль нэг эрх нь зөрчигдөхөд бусад эрхүүдэд нөлөөлнө нөгөө талаар нэг төрлийн эрхийг хангах явдал сайжрахад өөр эрхийг эдлэх боломж илүү бүрддэг.

Хариуцлага тооцох:

Төртэй хариуцлага тооцох

Төр нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахаас татгалзах, эсхүл хэсэг хүмүүсийн эрхийг хүндэтгэж, хамгаалж, хангаад бусад хүмүүсийн эрхээс татгалзах ёсгүй. Бүх хүмүүст адил тэгш хандана.

Хувь хүнтэй хариуцлага тооцох

Хүн бүр хүний эрхийг хүндэтгэх болон хүний эрхийг зөрчдөг байгууллага, хүмүүстэй тэмцэх үүрэгтэй.

Бусад этгээдтэй хариуцлага тооцох

Корпорац, ТББ, сан, боловсролын байгууллага зэрэг үйл ажиллагаа явуулж буй бүх төрлийн байгууллага, нийгмийн бусад бүх хэсгүүд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүргийг хүлээнэ.

Хүний эрх бол таныг хүний зэрэгтэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа юм. Хүмүүс ихэнхдээ амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх зэрэг эрхийг л мэддэг. Гэтэл үнэндээ эдгээрээс гадна маш олон эрхийг хуулиар баталгаажуулсан.

Хүний эрхийг хэзээнээс баталгаажуулсан бэ?

Хүний эрх жам ёсны шинжтэй. Өөрөөр хэлбэл, хүний эдлэх эрхийг аль нэг төр эсвэл хэн нэгэн хүн өгдөггүй, бүтээдэггүй. Гэхдээ жам ёсны үнэт зүйлийг орчин үед хууль зүйн хэм хэмжээгээр баталгаажуулсан.

Хүний эрх хэнд хамаарах вэ?

Хүн бүрт хамааралтай. Өөрөөр хэлбэл, хүн бүр ямар ч ялгаваргүйгээр эрх, эрх чөлөөгөө эдлэх ёстой. Хүний эрх түгээмэл учраас дэлхийн хаана ч ижил дээдлэгдэх учиртай.

Эрхээ хаанаас мэдэж болох вэ?

Мэдээж, хуулиас. Хүний эрхийг Үндсэн хууль, олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулдаг. Дараах баримт бичгүүдтэй эн тэргүүнд танилцаарай.

- Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал (Дэлхий дээр хамгийн олон хэлээр орчуулагдсан энэ баримт бичгийг интернетийн дурын хайлтын системээс олж авах боломжтой. Хялбаршуулсан хувилбарыг мөн ХЭҮК-оос авч болно)
- Монгол Улс хүний эрхийн асуудлаар 30 гаруй олон улсын олон талт гэрээнд нэгдэж орсон. (Гэрээг Комиссын цахим хуудаснаас үзэх боломжтой)
- УИХ-аас хүний эрхийг хэрхэн баталгаатай эдлүүлэхтэй холбоотой олон асуудлыг нарийвчлан зохицуулсан хэдэн зуун хууль батлан гаргасан. Тухайлбал, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай гэх мэт. (Та сонирхвол www.legalinfo.mn цахим хуудаснаас мэдээллийг авч болно)

Эрхээ мэдэх ямар ач холбогдолтой вэ?

Эрхээ бүрэн дүүрэн эдлэх **боломжийг** олж авна. Эрхээ зөрчигдөж байна гэдгийг мэдэж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх арга хэмжээ авна. Үүгээр ч зогсохгүй эрхээ **зөрчигдөхөөс хамгаалж**, түүнд нийцсэн баталгаа бүрдүүлэхийг төрөөс шаардах болно.

Эрхээ бүрэн дүүрэн эдэлнэ гэдэг нийгмийн амьдралд идэвхтэй **оролцоно** гэсэн үг. Таны оролцоо, хяналт улс төрчдийг хариуцлагатай болгож, хууль, төрийн бодлогыг сайжруулж, ингэснээр эрүүл нийгмийг бүтээх боломжтой.

Эрүүл нийгэм биднийг энх тайван, амар амгалан амьдрал, **хөгжил, дэвшилд** хөтөлнө.

Хүний эрх хязгааргүй юу?

Хүний эрхийг хязгаарлаж болно. Хүний эрх, эрх чөлөөг үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийгмийн эрүүл мэнд, нийгмийн ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор хязгаарлаж болно. Хүний эрхийг хязгаарлах дээрх нөхцлүүдийн хил хязгаар, хэр хэмжээг олон улсын эрх зүйн баримт бичгүүдээр тодорхойлсон. Гэхдээ хүний эрхийг хязгаарлахад учир бий.

- Хүний эрхийг ямар нөхцөлд, хэрхэн хязгаарлахыг хуулиар урьдчилан зохицуулсан байх ёстой;
- Ийнхүү хязгаарлах нь шударга ёс, хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн байх ёстой;
- Хүний эрхийг хязгаарлах хэмжээ нь хязгаарлах болсон зорилготой тэнцүү чанартай байх ёстой. (Хязгаарлалт зорилгоос хэтэрсэн байж болохгүй)

Жишээлбэл, жагсаал цуглааныг албадан тараах журмыг хуульд нарийвчлан заагаагүй бөгөөд нийгмийн хэв журам,

нийтийн эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөнд хохирол учруулахааргүй илт тайван жагсаал, цуглааныг албадан тараах нь хүний эрхийн зөрчил болно.

Ямар ч нөхцөлд хязгаарлаж **үл болох** хүний эрх, эрх чөлөө гэж бий. Үүнд:

Амьд явах эрх;

- Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ял шийтгэлээс ангид байх эрх, эрх чөлөө
- Сайн дурын зөвшөөрөлгүйгээр эмнэлгийн, эсвэл шинжлэх ухааны туршилтаас ангид байх эрх чөлөө;
- Боолчлол, сайн дурын бус боолын байдлаас ангид байх эрх чөлөө;
- Хуулийн өмнө этгээд гэдгийг хүлээн зөвшөөрөх эрх;
- Үзэл бодол, итгэл үнэмшилтэй байх эрх, эрх чөлөө багтдаг.



АМЬД ЯВАХ ЭРХ

Хүн бүр амьд явах... эрхтэй.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹-ын 3 дугаар зүйл

Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт²-ын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстой бөгөөд хүний эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр баталгаатай эдлүүлэх ёстой.

Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно.

Монгол Улсын Үндсэн хууль³-ийн Арванзургадугаар зүйлийн 1 дэх хэсэг

Хүний хамгийн үнэ цэнэтэй чухал эрхийн нэг нь амьд явах эрх юм. Учир нь энэ эрх зөрчигдсөнөөр бусад бүх эрх зөрчигдөх, дуусгавар болох эрсдэлийг дагуулдаг. Тиймээс амьд явах эрх бол байгаль дэлхийгээс хүн гэгч оюун ухаант бодгальд

¹ НҮБ-аас 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

² Монгол улс 1968 онд гарын үсэг зурж, 1974 онд соёрхон баталсан.

³ УИХ-аас 1992 онд баталсан.

заяасан цорын ганц эрхэм дээд эрх мөн. Олон улсын түвшинд амьд явах эрхийн хамгаалалтыг явцуу, өргөн хоёр утгаар тайлбарладаг.

Явцуу утгаар: Хүний амь насыг дур зоргын халдлагаас хамгаалах, хүний амь насыг аврахын тулд хийж болох зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт бөгөөд хүний амь насны эсрэг аливаа халдлагаас төр хамгаалах үүрэгтэй юм.

Монгол Улсын Үндсэн хуульд амьд явах эрхийг баталгаажуулж, энэ эрхийг Монгол Улсын Эрүүгийн хуулиар хамгаалсан байдаг. Өөрөөр хэлбэл хүний амьд явах эрхэд халдсан үйлдлийг гэмт хэрэгт тооцож, гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх замаар амьд явах эрхийг хамгаалах хууль зүйн арга хэмжээг авсан юм. Гэхдээ ийнхүү хуульчилснаар амьд явах эрх бүрэн хамгаалагддаггүй учраас төрийн бодлого, төрийн байгууллагын үйл ажиллагаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх ба төрөөс амьд явах эрхийг хангахуйц хууль зүй, нийгэм, эдийн засгийн болон бусад үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдал юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн.

*Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль⁴-ийн
3 дугаар зүйлийн 3.1. дэх хэсэг*

Төрийн байгууллага, албан тушаалтнаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дараах үндсэн чиглэлээр зохион байгуулж хэрэгжүүлнэ.

1. Гэмт хэргийн талаарх мэдээллийг цуглуулж, судалгаа,

⁴ УИХ-аас 1997 онд баталсан.

дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох;

2. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;
3. Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоох;
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэр харгалзахгүй татан оролцуулах;
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах.

Өргөн утгаар: Хүний амьд явах, амьдрах наад захын хэрэгцээг хангахад чиглэсэн хоол хүнс, хувцас, орон байр, аюулгүй орчин зэргийг бүрдүүлэх нь төрийн үүрэг юм.

Тиймээс амьд явах эрхийг хангахтай холбоотой төрийн үүргийг зөвхөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээгээр хязгаарлахгүй бөгөөд хүний зарим эрхийг төрөөс хэрхэн хангаж байгаагаас хүний амьд явах эрхийн баталгааг үнэлдэг. Жишээ нь:

- Эрүү шүүлтээс ангид байх эрх;
- Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны тэнцэл хамгаалуулах эрх;
- Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх;
- Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрх;
- Халдашгүй, чөлөөтэй байх эрх.

Эдгээр эрхийг хангахад төрийн тогтолцоо, бодлого, үйл ажиллагаа нь чиглэсэн байх учиртай. Учир нь хүний эрх нь түгээмэл, салшгүй, хуваагдашгүй шинжтэй бөгөөд нэг эрхийн

зөрчил нь нөгөө эрхэд ямар нэгэн байдлаар нөлөөлж байдаг.

Амьд явах эрхийн талаарх онолын ойлголт.

Амьд явах эрх хувь хүний хувьд хэдийд эхэлж, хэдийд дуусгавар болох талаар онолын хэд хэдэн ойлголт байдаг.

Амьд явах эрх эхлэх талаар: Дэлхийн ихэнх улс орнуудын хууль тогтоомжоор хүүхэд эхийн умайгаас гарч, эхний амьсгал авснаар амьд явах эрх үүсэхээр хуульчилсан байдаг. Харин зарим судлаачид, хүний эрхийн төлөө тэмцэгчид эхийн хэвлийд ураг бүрэлдэн бий болсон үеэс амьд явах эрх үүснэ гэж үздэг. Энэ үзлийг дэвшүүлэгчид үр хөндөлтийг хүнийг санаатай алах гэмт хэрэгт тооцдог.

Амьд явах эрх дуусах талаар: Хүн үхсэнээр тухайн хүний амьд явах эрх нь дуусгавар болдог. Гэхдээ үхлийн талаар хоёр ойлголт байдаг учраас амьд явах эрхийн дуусахтай холбоотой онолын маргаан байдаг. Үхлийг 1-рт биологийн буюу бие махбодын, 2-рт клиник буюу эмнэлгийн гэж хоёр ангилдаг. Биологийн үхэл гэж хүний зүрх бүрэн зогсохыг хэлдэг. Клиник үхэл гэж хүний зүрх зогсоогүй боловч, тархи зогсож гадаад орчинтой харьцахгүй болохыг хэлдэг.

Эвтанази: Эмчилгээ авах найдваргүйгээр өвчилсөн буюу шархдаж гэмтсэн хүний зовлонг нь дуусгаж, энэрэл үзүүлэх зорилгоор шаналгаа багатай аргаар үхэхийг нь зөвшөөрөх буюу амийг нь таслах үйлдлийг Эвтанази⁵ гэдэг .

Хэрэв Таны амьд явах эрхэд эрсдэл тулгарвал та холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж тухайн асуудлыг шийдвэрлүүлэх эрхтэй. Амьд явах эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар Засгийн эрх барьж байгаа хүмүүс ямар бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, ямар үр дүнд хүрсэн эсэхээс хамааран үнэлэлт өгч, сонгох эрхээрээ дамжуулан эрх баригчтай хариуцлага тооцдог олон улсын жишиг байдаг.

⁵ Энэ талаар өвчтөний эрх хэсгээс дэлгэрүүлж харна уу.



ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Хүн амьд явах салшгүй эрхтэй. Мөн эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй. Харин эдгээр эрхээ зүй ёсоор эдлэхийн тулд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах зэргээр байгаль, нийгмийн элдэв сөрөг нөлөөллөөс ангид байх ёстой юм. Амьд явах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах үндсэн баталгаа нь эрүүл, аюулгүй орчин бөгөөд орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдах явдлаас төр иргэнээ хамгаалах үүрэг хүлээдэг.

Эрүүл, аюулгүй орчин гэж юу вэ?

Эрүүл, аюулгүй орчин нь дан ганц хүн бус, бусад амьд амьтан, ургамалд ч хамаарах өргөн хүрээтэй ойлголт. Энэ нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэнддээ халтай орчны аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломж юм.

Эрүүл орчин нь гол төлөв байгалийн тэнцэл, хүрээлэн буй орчны төлөв байдал дээр яригддаг. Үүнд: агаар, ус, газар болон үүнтэй холбоотой бусад өргөн хүрээний байгалийн болон хүний хүчин зүйлс багтдаг.

Харин аюулгүй орчин нь илүү нийгэм-улс төрийн шинжтэй ойлголт юм. Үүнд: нийгэм-улс төрийн шинжтэй хүчирхийллээс ангид байх, хүчирхийллийн үед төрийн онцгой бүрэн эрхийг хууль ёсны хүрээнд хэрэгжүүлэх, олон нийтийн хэв журмыг хангах, бие махбодын аюулгүй байдалд амьдрах зэргийг ойлгоно.

Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг бий болгох шаардлага

Үндсэн хуульт ёс тогтож, хүний улс төрийн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан явдлыг хүний эрхийн хөгжлийн эхний үе гэж үздэг бөгөөд эдгээр эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон дэлхийн улсуудын Үндсэн хуулиудад баталгаажуулсан билээ.

Хүний эрхийн хөгжлийн хоёр дах үед эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрлөх зэрэг эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад багтаасан хэдий ч Үндсэн хуулиудад улс төрийн эрхтэй адил өргөн хүрээнд баталгаажуулаагүй байна.

Харин эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь орчин үеийн нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилтэй уялдан хүний эрхийн хөгжлийн гурав дахь үед бий болсон хамтын эрхүүдийн нэг юм. Хамтын эрх гэдэг нь гишүүн тус бүрийн эрх ашгийн төлөө хамтаар эдлэх ёстой тэрхүү эрхүүд юм. Мөн нөгөөтэйгүүр гишүүн тус бүр эдлэх боловч үр ашгийг нь хамтдаа хүртдэг эрх ч гэж ойлгож болно. Түүнчлэн гурав дахь үеийн эрхийг цаг үеийн хэрэгцээн дээр суурилсан эрхүүд гэж нэрлэх нь ч бий.

Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зайлшгүй бий болох урьдчилсан нөхцөл нь аж үйлдвэржилтийн нөлөөлөл, шинжлэх ухаан, техникийн хөгжил, даяаршил бөгөөд энэ эрх нь аж үйлдвэржсэн нийгмийн хөгжил, соёл иргэншлийг дагалдан бий болсон хүн бүрийн амьдралын хэрэгцээ юм. Үйлдвэрлэлийн хог хаягдал, хөрсний эвдрэл, агаарын бохирдол, ногоон байгууламжийн хомсдол, усны бохирдол, ундны усны хомсдол, уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, цөлжилт, элсний нүүдэл зэрэг нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд шууд хамаарах асуудлууд нэгэнт болжээ.

Үндсэндээ хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг онцлон хамгаалах шаардлага нь дэлхий нийтийг хамарсан хүрээлэн буй орчны бохирдол, түүнээс үүдэлтэй хямралаас эхтэй юм. Жишээ нь, 1967 онд Английн өмнөд хэсэгт Торри Канион тээвэрлэгч хөлөг онгоц их хэмжээний газрын тос далайд асгаснаас болж далайн амьтад ихээр сүйдсэн төдийгүй 15 мянга гаруй шувуу үхсэн томоохон гамшиг тохиолдсон, 1969 онд АНУ-д болсон Куахога голын бохирдлоос үүдэлтэй гамшиг зэрэг нь дэлхийн нийтийн анхаарлыг татаж улмаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалт шаардлагатай болсныг хүлээн зөвшөөрсөн байна.


Эрх зүйн зохицуулалт бий болсон нь

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1966 онд баталсан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад "...орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах..." -ыг оролцогч улс бүрт үүрэг болгосон нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх бий болох анхдагч дохио гэж үздэг.

Улмаар 1972 оны 6 дугаар сард Хүний хүрээлэн буй орчны сэдвээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын чуулга уулзалт Шведийн нийслэл Стокольм хотноо болж, уг чуулга уулзалтаар Хүрээлэн буй орчны тухай Стокольмын тунхагийг баталсан юм. Энэхүү тунхагийг хүрээлэн буй орчны эрхийн үндэс суурийг тавьсан анхны баримт бичиг гэж үздэг. Тунхагийн суурь зарчмуудын 1 дүгээрт: "Хүн бүр эрхэмсэг, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлдэг дээд зэргийн орчинд эрх чөлөөтэй, эрх тэгш байх, амьдралын таатай нөхцөлөөр хангагдах үндсэн эрхтэй агаад одоо ба хойч үеийнхээ төлөө хүрээлэн буй орчноо хамгаалах, хөгжүүлэх журамт үүргийг хүлээнэ." гэж заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т "Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх"-ийн баталгааг хуульчилсан билээ.

Өнөөдөр Монгол Улсаас гадна дэлхийн 140 улсын Үндсэн хуульд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг тодорхойлж, хүрээлэн буй орчныг хамгаалах явдлыг төрийн үүрэг болгон хуульчилсан байна. Үүнийг он дарааллаар авч үзвэл:



Зөвхөн 1992 онд 18 улс хүрээлэн буй орчны эрхийг Үндсэн хуульдаа баталгаажуулсан нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд энэ нь Рио де Жанейро хотноо "Хүрээлэн буй орчин, хөгжил" сэдвээр НҮБ-ын чуулга уулзалт болж, уг уулзалтад улс орнуудын төрийн тэргүүн, удирдах албан тушаалтнууд өргөнөөр оролцсонтой холбоотой. Чуулга уулзалтаас Риогийн тунхаг хэмээх 27 зүйл, зарчим бүхий баримт бичгийг гаргасан ба Зарчим 1-т: "Хүн нь тогтвортой хөгжлийг хангах явдлын төвд нь байна. Тэд байгальтай нийцэж эрүүл, таатай амьдрах эрхтэй." хэмээн тунхагласан юм.

Мөн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг 86 улсын Үндсэн хуульд шууд утгаар нь баталгаажуулсан байна. Эдгээр улсууд гол төлөв "эрүүл орчин", "эрүүл мэндэд халгүй орчин"-д амьдрах эрх гэсэн ойлголтыг Үндсэн хуульдаа тусгасан байх бөгөөд тухайн заалтад цэвэр /7/, аюулгүй /6/, таатай /5/, бохирдоогүй /2/, бохирдлоос ангид /2/, тогтвортой /2/ зэрэг үгс давхар дурдагдсан байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомж

Хүний аливаа эрхийг амьдрал дээр хэрэгжүүлэх үйл явцыг энгийнээр тайлбарлавал эхлээд тодорхой эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулах, хоёрдугаарт, салбарын хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулах, гуравдугаарт, хууль хэрэгжүүлэх байгууллагууд дүрэм журам баталж мөрдүүлэх, дөрөвдүгээрт, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий байгууллагууд түүнийг хэрэгжүүлж ажиллах, тавдугаарт, хувь хүн, бизнес, иргэний нийгэм, төрийн бүх шатанд буюу нийгмийн төлөв байдалд өөрчлөлт илрэх, эцэст нь буюу зургадугаарт, амьдрал дээр үр дүн нь илэрч гарах явдал болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." **гэж заасан.**

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх ажлын хүрээнд Монгол Улс Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц /1996 онд нэгдэн орсон/, Биологийн төрөл зүйлийн тухай конвенц /1993 онд нэгдэн орсон/, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын ерөнхий конвенц /1993 онд нэгдэн орсон/ зэрэг хүрээлэн буй орчны асуудлаар гарсан нэр бүхий 18 олон улсын гэрээнд нэгдсэнээс гадна үндэсний хэмжээнд Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай, Газрын тухай, Агаарын тухай, Ашигт малтмалын тухай хууль зэрэг нийт 30 гаруй хуулийг баталж, эдгээрт эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаарх заалтыг тусгасан байдаг.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг баталснаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн үндэс тавигдсан юм.

Мөн Агаарын тухай, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Ойн тухай зэрэг хуулиуд батлагдаж хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгаа тодорхой хэмжээнд бүрдэж байна.

Иймд төр нь иргэнийхээ заавал эдлэх ёстой энэхүү үндсэн эрхийг хангах, баталгаажуулах зорилгоор олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн орох, дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгоод зогсохгүй эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авах үүргээ бүрэн биелүүлэх ёстой юм.

Иргэн та эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг тань зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгж, хувь хүний үйлдэл, үйл ажиллагааны талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст хандаж, гомдол, мэдээлэл гаргаж болно.



ӨМЧЛӨХ ЭРХ

Хүн бүр өөрийн гэсэн өмчтэй байдаг. Монгол Улсын иргэний хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах үндсэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан билээ. Өмчлөх эрх бол ууж идэх, өмсөх, амьсгалах хүний төрөлх хэрэгцээний нэгэн адил салгаж үл болох, жам ёсны эрх агаад эдийн болон эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахдаа түүнд бүрэн хяналтаа тогтоох тухай ойлголт юм.

Иймээс хүн бүр өмчлөх адил тэгш эрхтэй. Гэвч өмчтэй болох нөхцөл, өмчийг бий болгох чадвар нь тэдэнд адил тэгш заяадаггүй тул янз бүрийн хэмжээний өмч хөрөнгөтэй байдаг. Гэхдээ бүх хүнд өмч бий. Хамгийн ядуу хүнд ч түүний бие махбод, оюун санаа, авьяас, хөдөлмөрлөх чадвар гэх мэт өмч байдаг.

Өмчлөх эрх халдашгүй дархан байх ёстой

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т зааснаар хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглодог. Хэрэв төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн иргэний хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлөх тухай зохицуулж өгсөн байдаг.

Дайны буюу онц байдал зарласан, цэргийн цугларалт, хээрийн сургуулийн үед иргэдийн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авч болох хэдий ч өөр бусад ямар ч нөхцөлд хувийн өмчийг дайчлан авахыг хориглодог.

Хувийн өмчийн эд хөрөнгийг хуульд тусгайлан заасан тодорхой үндэслэлээр зөвхөн шүүхийн болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр хураан авч болно. Гэхдээ энэ шийдвэрийг дээд шатны байгууллага, шүүхээр дахин хянуулах, давж заалдах эрхтэй.

Хэдийгээр таны өмчийг гадны халдлага, аюул ослоос хамгаалах хуулийн хамгаалалт хангалттай байгаа ч гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас таны өмчлөлийн зүйл, түүний үр төл, үр шим устсан, гэмтсэн тохиолдолд эрсдлийг өмчлөгч та өөрөө хариуцна гэдгийг сануулахад илүүдэхгүй бизээ.

Монгол Улсад өмчийн харилцааг хуулиар зохицуулсан нь

Эд хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглах захиран зарцуулах ерөнхий журмыг иргэний болон салбарын хууль тогтоомжоор зохицуулж байна. Иргэний хуульд зааснаар Монгол Улсад нийтийн болон хувийн өмчийн хоёр төрөл бий. Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй бол хувийн өмч нь иргэний болон дундын гэсэн хэлбэртэй байна. Бас нийтийн болон хувийн өмч нь холимог хэлбэрээр ч байж болно.

Өмчлөгч өөрийн эд хөрөнгөө бусдын эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхийг Иргэний хуулиар давхар баталгаажуулсан ба та өөрийн өмчөө гадны аливаа халдлагаас хамгаалах эрхтэй.

Иргэн та өмчлөх эрхээ эдлэхдээ бусдад гэм хор учруулах замаар эрхээ урвуулан ашиглаж болохгүй. Жишээ нь, өөрийн өмчлөлийн орон сууцаа яаж ч өөрчилж болно гээд хана таазыг

нь нураана, хаалга, цонх гаргана гэвэл тухайн орон сууцанд амьдарч буй бусад өмчлөгч нарын эрх ашиг хөндөгдөж болзошгүй. Учир нь таны энэхүү үйлдлээс болж хөрш айлын хана туурга гэмтэх, чимээ шуугиан гарах гэх мэт гэм хор учрах магадлал өндөр юм.

Харин ашиг сонирхлоо хамгаалахын тулд зайлшгүй шаардлагаар хийсэн үйлдэл тань хууль ёсны болох нь тогтоогдсон бол өмчлөх эрхээ урвуулан ашигласан гэж үзэхгүй.

Эрхээ эдлэнэ гэдэг үүргээ биелүүлнэ гэсэн үг

Аливаа тохиолдолд хүний эрх гэсэн ойлголттой хамт үүрэг гэх зүйл дагалдаж явдаг. Жишээ нь та хувьдаа олон тооны малтай бол өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ мал, амьтан, байгаль орчныг хамгаалах, эрүүл ахуйн шаардлага, бусдын аюулгүй байдлыг хангах талаар тогтоосон хэм хэмжээг сахин биелүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.4 дэх хэсэгт "Өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ зохих ёсоор ашиглаж, арчлан хамгаалж, хадгалахгүй байгаа нь нийтийн ашиг сонирхолд харшлахаар бол өмчлөлийн зүйлээ зохих ёсоор ашиглах, арчлан хамгаалах, хадгалах үүргийг өөрт нь даалгах буюу бусдаар зохих хөлс, шан харамжтайгаар гүйцэтгүүлэх үүргийг шүүх өмчлөгчид хүлээлгэж болно." гэж заасан байдаг.

Шударгаар олж авсан зүйлс таны өмч гэж тооцогдоно

Эд хөрөнгийг олж авахдаа бусдын эрх ашигт хохирол учруулахгүйгээр хуульд тусгайлан заасан болзол, журмыг хангаж, шударгаар олж авах үүрэгтэй. Бусдын эд хөрөнгийг хулгайлах, хууран мэхлэх, айлган сүрдүүлэх, төөрөлдүүлэх

замаар олж авахыг хориглоно. Хэрэв та хэний өмчлөл, эзэмшилд байгаа нь тодорхойгүй ямар нэгэн эд зүйлсийг олж аваад түүнийгээ өөрийн өмчийн нэгэн адил тордон хамгаалж, эзэмшиж, ашиглаж байсан бол 5 жил өнгөрсний дараа тухайн эд зүйлсээ өөрийн хууль ёсны өмч болгох боломжтой.

Түүнчлэн та эзэнгүй үл хөдлөх эд хөрөнгө, жишээ нь, барилга байшинг олж авсан бол түүнийгээ улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 15 жилийн хугацаанд уг эд хөрөнгөө мөн л өмчлөгчийн нэгэн адил эзэмшиж байсан бол дээрх хугацаа дууссанаар уг эд хөрөнгийг өөрийн хууль ёсны өмч болгох боломжтой. Гэхдээ дээрх тохиолдлуудын алинд ч нь ганцхан шаардлага тавигдах бөгөөд энэ нь эд хөрөнгийг шударга арга замаар олж авсан байх явдал юм.

Тухайн эд хөрөнгийг бусдын өмчлөл, эзэмшилд байгааг мэдсээр байж мэдээгүй дүр эсгэх, эсвэл эзэнгүй эд хөрөнгийг нийтийн ашиг сонирхолд харшаар ашигласан гэх мэт үйлдэл гаргасан бол танд өмчлөх эрх үүсэхгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 17 дугаар зүйлд "Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй." гэж заасан. Гэхдээ өмчлөх эрхээ зүй ёсоор хэрэгжүүлэх үндсэн шаардлага бол эд хөрөнгийг шударгаар олж авах явдал юм. Иргэн таны хувьдаа өмчтэй болох олж үйл явц аливаа нөхцөлд зүй ёсны байх ёстой. Тодруулбал, зүй ёсны, шударга арга замаар эд хөрөнгийг авсан, эзэмшсэн тохиолдолд тэр нь тухайн этгээдийн өмч гэж тооцогдох тул Монгол Улсын Үндсэн хуульд өмчлөх эрхийн заалтыг баталгаажуулахдаа "...шударгаар олж авах, эзэмших..." гэж тодотгосон нь түүний урьдач нөхцөлийг тодорхойлсон чухал заалт болсон юм. Дээрх бүхнээс үзвэл хувь хүн хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн, зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүй

эдийн баялаг болох эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлсийг шударгаар олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах (худалдах, бэлэглэх, шилжүүлэх, өв залгамжлуулах) эрхийг өмчлөх эрх гэж үзэж болно.

ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ



Монгол Улсын Үндсэн хуулиас ...

"Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй", "Хөдөлмөрлөх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн."

Хөдөлмөрийн гэрээний болон түүнээс уламжилсан хөдөлмөрийн бусад харилцаанд оролцогч талууд:

Ажил олгогч:

- Төрийн байгууллага;
- Төрийн бус байгууллага;
- Аж ахуйн нэгж;
- Хувь хүн.

Ажилтан:

- Монгол Улсын иргэн;
- Гадаадын иргэн;
- Харьяалалгүй хүн.

Ажил олгогчийн эрх, үүрэг:

- Ажилтнаас хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй;
- Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх эрхтэй;
- Ажилтныг ажлаар хангах үүрэгтэй;
- Хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс олгох үүрэгтэй;

- Хууль, хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй.

Ажилтны эрх, үүрэг:

- Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах;
- Цалин хөлс авах;
- Ээлжийн амралт эдлэх;
- Эвлэлдэн нэгдэх;
- Тэтгэвэр, тэтгэмж авах;
- Хөдөлмөрийн хамтын гэрээ хэлэлцээрт заасан бусад эрх, хөнгөлөлт эдлэх эрхтэй;
- Хөдөлмөрлөх;
- Хуулиар тогтоосон нууцад хамаарах ажил үүрэгтэй холбоотой нууцыг хадгалах;
- Хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг сахин биелүүлэх үүрэгтэй.

Хөдөлмөрийн гэрээ: Нэг талаас ажилтан нь ажил олгогчоос хуульд нийцүүлэн тогтоосон хөдөлмөрийн дотоод журмын дагуу тодорхой ажил гүйцэтгэх, нөгөө талаас ажил олгогч нь ажилтны хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс олгох, хууль тогтоомж болон хамтын гэрээ хэлэлцээрт заасан хөдөлмөрийн нөхцөлөөр хангах тухай харилцан үүрэг хүлээсэн тохиролцоог хэлнэ.

Хөдөлмөрийн гэрээнд дараах нөхцөлийг заавал тусгана.

1. Ажлын байр, албан тушаалын нэр;
2. Гүйцэтгэх ажил, үүрэг;
3. Цалингийн хэмжээ;
4. Хөдөлмөрийн нөхцөлийг заавал тохирсон байна. Мөн гэрээний хугацаа, ээлжийн амралт хоорондын зай, хүлээх

хариуцлага зэргээс гадна ажил олгогчтой харилцан тохиролцсон өөр бусад онцлог нөхцөлийг гэрээнд заавал тусгах шаардлагатай. Гэрээг 2 хувь үйлдэж, ажилтанд гэрээний нэг хувийг заавал өгнө.

Контракт: Ажил олгогч нь иргэний гоц буюу ховор авьяас, өндөр ур чадварыг хөлслөн авч ашиглах зорилгоор иргэнтэй контракт байгуулахыг хэлнэ.

Хамтын гэрээ, хэлэлцээр: Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлийн дагуу ажил олгогч нарын төлөөлөл болон ажилтнуудын төлөөлөл хамтын гэрээ, хэлэлцээр байгуулж болно. Харин хамтын гэрээг 1 жил, хамтын хэлэлцээрийг 2 жилийн хугацаатай байгуулна.

Ажлын байранд:

- Үндэс, угсаа;
- Арьсны өнгө;
- Нас, хүйс;
- Нийгмийн гарал, байдал;
- Хөрөнгө чинээ;
- Эрхэлсэн ажил, албан тушаал;
- Боловсрол;
- Шашин шүтлэг;
- Үзэл бодол;
- Эрүүл мэндийн байдал нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно.

Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл:

- Ажилтны санаачилгаар;
- Ажил олгогчийн санаачилгаар.

Ажилтны санаачилгаар: Ажилтан хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай өргөдлөө ажил олгогчид өгсөн өдрөөс хойш 30 хоног өнгөрмөгц ажлын байраа орхих эрхтэй бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаантай, эсхүл ажлаас чөлөөлөх хугацааг ажил олгогчтой тохиролцсон бол хөдөлмөрийн гэрээг хугацаанаас өмнө цуцалж болно.

Ажил олгогчийн санаачилгаар:

- Аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар, нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн;
- Ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон;
- Ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн;
- Ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсхүл хөдөлмөрийн харилцааг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан ноцтой зөрчил гаргасан;
- Мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон;
- Сонгууль, томилолтоор өөр орон тооны ажил, албан тушаалд ажиллах болсон;
- Контрактад заасан үндэслэл буй болсон.

Ажил олгогч нь жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцгийг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан, хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсоноос бусад тохиолдолд ажлаас халахыг хориглоно.

Цэргийн жинхэнэ албанд татагдсан, аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар, нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн, ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон, ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тохиолдлуудад ажил олгогч танд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмжийг олгоно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт:

Ажил олгогч нь 25, түүнээс дээш ажилтантай бол албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд сар бүр төлбөр төлнө. Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой маргааныг Хөдөлмөрийн маргаан таслах комисс болон шүүхэд хандан шийдвэрлүүлнэ. Монгол Улс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 15 конвенцийг соёрхон баталсан бөгөөд үүнд суурь 8 конвенци багтаж байна.

- Тэгш шан хөлс олгох тухай 100 дугаар конвенц;
- Ялгаварлан гадуурхахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 111 дүгээр конвенц;
- Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц;
- Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенц;
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 182 дугаар конвенц;
- Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенц;
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 87 дугаар конвенц;
- Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай 98 дугаар конвенц.



ЭД, МӨНГӨНИЙ ТУСЛАМЖ АВАХ ЭРХ

Эд мөнгөний тусламж авах эрх нь хүний эрхийн тухай онолд түүхэн хөгжил талаасаа хоёрдугаар үеийн эрх хэмээн нэрийддэг бөгөөд 1950-1990-ээд он хүртэлх хугацаанд олон улсын түвшинд энэ эрхийг хангах баталгаа үндсэндээ бүрэлдэн төлөвшсөн гэж үздэг. Энэ үеэс эд мөнгөний тусламж авах эрхийн агуулга, хүрээг олон улсын хэмжээнд анхлан хуульчлан томьёолж эрх зүйн зохицуулалттай болгож олон улсын гэрээ конвенцоор баталгаажуулахын зэрэгцээ улс орон бүр өөрийн Үндсэн хуульдаа тусгаж хуульчилсан байдаг.

Эд мөнгөний тусламж авах эрх нь нийгэм, эдийн засгийн эрхийн бүлэгт хамаардаг бөгөөд зөвхөн хувь хүн төдийгүй, нийгэмд ч чухал ач холбогдолтой. Учир нь хүн өөрийн хөдөлмөрөөр амьжиргааны эх үүсвэрээ олж чадахаа байсан үед төрөөс тогтмол хугацаанд зохих хэмжээний эд мөнгөний тусламж авахыг хүсээд зогсохгүй баталгаатай хангуулахыг эрмэлзэнэ.

Харин төрөөс хүн амынхаа амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, хөтөлбөр, төслийн үр дүнгээр эд мөнгөний тусламж авах эрхийн хэрэгжилт илэрч байдаг. Энэ нь иргэдэд үзүүлж буй нийгмийн даатгал, халамжийн сангаас олгож буй тэтгэвэр тэтгэмж, мөнгөн тусламж, хөнгөлөлт зэрэг өргөн хүрээг хамардаг.

Эд мөнгөний тусламж хүртэх эрхийг хангах талаар төр олон төрлийн үйл ажиллагаа явуулж байдаг.

Тухайлбал:

- Амьжиргааны баталгаажих доод түвшинг тогтоох⁶ бөгөөд ингэхдээ хоол хүнс, хувцас хунар, орон гэр, боловсрол, эрүүл

⁶ Үндэсний статистикийн хорооны даргын 2013 оны 01/52 тоот тушаалаар 2013 онд мөрдөх Хүн амын амьжиргааны доод түвшин баруун бүсэд 132 000, хангайн бүсэд 130 900, төвийн бүсэд 132 400, зүүн бүсэд 130 500, нийслэлийнхэнд 149 900 төгрөгөөр тогтоосон байна”

мэндийн үйлчилгээтэй холбоотой наад захын хэрэгцээг харгалзан үзэх ба өнөөгийн үнэ ханшийг мөрдлөг болгох;

- Цалингийн доод хэмжээг эдийн засгийн эрхийн наад захын шаардлагыг хангах түвшинд хүрэлцээтэй байхаар тооцон тогтоож, цаашид эдийн засгийн өсөлттэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх;
- Санхүүгийн туслалцаа, үйлчилгээ нэн шаардлагатай байгаа гэр бүл, хувь хүмүүсийг татвараас чөлөөлөх, орлогын эх үүсвэр бий болгох, тэтгэвэр өгөх, сургалтын хөтөлбөрт хамруулах зэрэг наад захын тусламж үйлчилгээг үзүүлэх ба ийм тусламж үйлчилгээ үзүүлдэг хүмүүнлэгийн болоод хүний эрхийн төрийн бус байгууллагуудыг төрөөс дэмжиж туслах;
- Эдийн засгийн хөгжил, ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах, нийгмийн бусад асуудалд чиглэсэн эдийн засгийн тусламж дэмжлэг үзүүлэх олон улсын бүхий л гэрээнд нийгмийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийн амьжиргааны баталгаажих түвшинд амьдрах эрхийг хэрхэн хангах талаар оруулах;
- Ядуу хүмүүст бага өртөгтэй орон сууцны барилга барихад зориулан зээлийн хүүг бууруулах чиглэлээр эрх зүйн болон санхүүгийн зохицуулалт хийх;
- Нийгмийн даатгалын үйл ажиллагааг идэвхижүүлж малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжтэй уялдуулан нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, даатгуулагчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах механизмыг хөгжүүлэх зэргээр орлогыг нэмэгдүүлэх, дундаж тэтгэврийн хэмжээ түүний дотор бүрэн тэтгэврийн доод хэмжээ, хувь тэнцүүлсэн тэтгэвэр, ердийн өвчин, ахуйн ослын улмаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр, нийгмийн даатгал, халамжийн сангаас олгох жирэмсний болон амаржсаны, хүүхэд асарсны, халамжийн зэрэг тэтгэвэр тэтгэмжийн зөрүүг арилгах үүрэгтэй болно.

Эдгээр нь эдийн засгийн уналтын үед ард иргэдээ ядуу зүдүү байдалд орохоос хамгаалахын зэрэгцээ хүнд нөхцөлд байгаа хүмүүст хүний зэрэгтэй амьдрах баталгааг хангах, тулгарсан бэрхшээлээ шийдэж өөрөө амьдралаа авч явах боломжтой болтол нь түр хугацаанд дэмжих замаар тэгш боломжийг бүрдүүлэх зорилготой юм.

НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгал гэж даатгалын сан бүрдүүлж, уг сангаас даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болоход өөрт нь, даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд нь тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгч эрсдлээс хамгаалах арга хэмжээ юм.

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуульд зааснаар нийгмийн даатгал нь:

- Тэтгэврийн даатгал;
- Тэтгэмжийн даатгал;
- Эрүүл мэндийн даатгал;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал;
- ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс бүрддэг.

Нийгмийн даатгал нь заавал даатгуулах, сайн дураар даатгуулах гэсэн хоёр хэлбэртэй байна.

Нийгмийн даатгалд дор дурдсан ажилтан заавал даатгуулна:

- Аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр, эсхүл

ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

- Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа;
- Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;
- Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч;
- Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн.

Тэтгэвэр авагч /ажилгүйдлийн болон эрүүл мэндийн даатгалаас бусад төрлийн даатгалд/ тус тус даатгуулна.

Заавал даатгалд даатгуулснаас бусад тодорхой хөдөлмөр эрхлээгүй, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, газар тариалан эрхлэгч, лангуу түрээслэгч, хувийн журмаар гадаад улс оронд ажиллагсад зэрэг иргэд нийгмийн даатгалд сайн дураар даатгуулж болно.

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛ

Эд мөнгөний тусламж авах эрхийн зонхилох хэсгийг өндөр наслах үед авах тэтгэвэр бүрдүүлдэг. Тэтгэвэр гэдэг нь тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлж байсан иргэн хүн өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуу болох, эсвэл нас барж хөдөлмөрийн чадваргүй гишүүд нь тэжээгчээ алдахад тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгө юм.

Тэтгэврийн даатгалын сангаас:

- Өндөр насны тэтгэвэр;

- Тахир дутуугийн тэтгэвэр;
- Тэжээгчээ алдсаны тэтгэврийг олгодог.

Өндөр насны тэтгэвэр

Монгол Улсын Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар тэтгэвэр тогтоолгох насанд (эрэгтэй 60, эмэгтэй 55) хүрсэн байх; 20-иос доошгүй жил шимтгэл төлж ажилласан байх; Ажлаас чөлөөлөгдсөн (хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон) байх гэсэн нөхцөл, болзлыг хангасан тохиолдолд та өндөр насны тэтгэвэр авах эрхтэй.

Өндөр насны тэтгэврийг даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сарын дундаж хөдөлмөрийн хөлсний 45 хувиар тогтооно. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлсний 1.5 хувиар бодож нэмэгдэл олгодог.

Харин тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлэн олгодог.

Хэрэв та тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-20 хүртэлх жил төлсөн бол нийт шимтгэл төлсөн хугацаандаа ногдох өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож болно.

Өндөр насны тэтгэвэрт гарах өргөдлөө тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, хэрэв тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэнээс хойш гаргасан бол таны өргөдлийг даатгалын байгууллага хүлээн авсан өдрөөс эхлэн, нас барсны дараагийн сар дуустал олгоно.

Тахир дутуугийн тэтгэвэр

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20 ба түүнээс дээш жил төлсөн эсвэл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь төлсөн даатгуулагч нь ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар алдаж тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн бүрэн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Дээрх болзлыг хангаагүй ч нийтдээ 3 ба түүнээс дээш жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчид шимтгэл төлсөн хугацаанд ногдох тахир дутуугийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтооно.

Тиймээс даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, түүний хугацааг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор тогтооно. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалт 70 ба түүнээс дээш хувиар тогтоогдсон бол хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсанд, 50-69 хувиар тогтоогдсон бол хөдөлмөрийн чадвараа хагас алдсанд тус тус тооцдог.

Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан даатгуулагчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс орлогын 45 хувиар тогтоож, 20-иос илүү ажилласан жил тутамд сарын дундаж хөдөлмөрийн хөлс орлогын 1.5 хувиар бодож нэмэгдэлийг хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, хэрэв тэтгэвэр авагч нь нас барвал нас барсны дараагийн сар дуусах хүртэлх хугацаанд олгоно.

Тахир дутуугийн бүрэн тэтгэврийн доод хэмжээ нь өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээтэй, тахир дутуугийн хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ нь өндөр насны хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээтэй тус тус адил байхаар зохицуулсан байдаг.

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

Ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан даатгуулагч нийтдээ 20 ба түүнээс дээш жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, эсвэл нас барахын өмнөх 5 жилийн 3 жилд нь тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүд тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Тахир дутуугийн тэтгэвэр авч байсан тэжээгч нас барсан бол тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1,0 хувиар бодож нэмэгдүүлнэ.

Тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэврийн доод хэмжээг хөдөлмөрийн чадваргүй 1 хүнд хөдөлмөрийн баталгаат хөлсний 50 хувиар, 2 хүнд 75 хувиар, 3 ба түүнээс дээш хүнд 100 хувиар тус тус тогтооно. Харин тэжээгчээ алдсаны хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ нь мөн хөдөлмөрийн хөлсний 50 хувиас багагүй байна.

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын тухай хуульд заасан болзол, журмын дагуу тэтгэмжийн даатгалд шимтгэл төлж даатгуулсан бол уг сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, оршуулгын тэтгэмжийг авах эрхтэй.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж

Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3 сар буюу түүнээс дээш хугацаагаар тэтгэмжийн даатгалын шимтгэлээ төлж ажилласан даатгуулагч, мөн хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн эмэгтэйчүүд /даатгуулагч/ уг тэтгэмжийг авах эрхтэй.

Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан түүний сүүлийн бүтэн ажилласан 3 сарын хөдөлмөрийн хөлснөөс хувь хэмжээгээр бодож олгоно. Жишээлбэл, та 5 жил хүртэл шимтгэл төлж ажилласан бол таны сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хөлсний 50 хувиар, 5-14 жил шимтгэл төлсөн бол 55 хувиар, 15 болон түүнээс дээш жил шимтгэл төлж ажилласан бол 75 хувиар бодож олгоно. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцож олгодог.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж

Заавал болон сайн дураар даатгуулагч эх дараах 2 болзлыг хангасан тохиолдолд тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.

- Заавал болон сайн дураар даатгуулагч эх тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд төлсөн, үүнээс сүүлийн 6 сар нь тасралтгүй төлсөн байх.

Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх дээрх хугацааг хангасан даатгуулагч эх 196 хоног тээгээд дутуу төрүүлсэн болон үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол.

Дээрх нөхцөлийг хангаагүй даатгуулагч эхэд жирэмсний, амаржсаны тэтгэмж авах эрх үүсэхгүй гэж ойлгоно.

Заавал даатгуулагч эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 100 хувиар тооцож тэтгэмжийн даатгалын сангаас 4 сарын хугацаанд олгоно.

Харин сайн дурын даатгуулагч эхийн хувьд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн сүүлийн 12

сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 70 хувиар тооцон мөн 4 сарын хугацаанд тэтгэмжийн даатгалын сангаас олгоно.

Оршуулгын тэтгэмж

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан тохиолдолд оршуулгын тэтгэмжийг олгоно. Тэтгэмжийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс⁷ тогтоодог. Харин даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол оршуулгын тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацааг харгалзахгүйгээр олгоно.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан даатгуулагч нь тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр авах эрхтэй. Үүнд:

- Тахир дутуугийн тэтгэвэр;
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
- Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах

⁷ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2009 оны 05 сарын 26-ны өдрийн 18 тоот тогтоолоор оршуулгын тэтгэмжийн хэмжээг 300.000 төгрөгөөр тогтоосон

сувиллын газрын даатгуулагчийг сувилахад ногдох тусламж, үйлчилгээний хувьсах зардал;

- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал орно.

Даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн хүчин зүйлийн үйлчлэлд өртөж эрүүл мэндээр хохирох, амь насаа алдахыг **үйлдвэрлэлийн осол**, харин хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчнийг "**мэргэжлээс шалтгаалсан өвчин**" гэнэ.

Даатгуулагч нь ажлын байрандаа болон бусад газарт ажил үүргээ гүйцэтгэх явцад, ажил эхлэхийн өмнө ажилд бэлтгэх буюу дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх үед, ажилдаа ирэх, буцах замд осолд өртсөн тохиолдолд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно.

Тахир дутуугийн тэтгэвэр нь даатгуулагчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлснөөс хөдөлмөрийн чадвараа 10 хүртэл хувь алдсан бол 10 хувиар, 10-аас дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тогтоох, хөдөлмөрийн чадвараа 30, түүнээс дээш хувиар алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний⁸ 75 хувиас багагүй байна.

Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан даатгуулагчийн авч байсан хөдөлмөрийн хөлснөөс дараах хэмжээгээр тогтооно. Үүнд: Хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 3 ба түүнээс дээш бол 100 хувь, хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 2 бол 75 хувь, хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 1 бол 50 хувь байна.

⁸ Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 07 тоот тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2013 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн нэг цагт 1142 төгрөг 85 мөнгө, сард 192000 төгрөг байхаар тогтоов.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажилласан хугацаа харгалзахгүйгээр хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 100 хувиар бодож ажлын өдрөөр тооцож олгоно. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж олгох хугацааны дээд хязгаар нь дараалсан 12 сарын дотор 180 хоногоос хэтрэхгүй байна.

Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөрийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 ба түүнээс дээш хувиар алдсан даатгуулагч хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/ хийлгэх, тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх рашаан сувилалд эмчлүүлэхэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр авах эрхтэй.

Зайлшгүй шаардлагаар мэргэжлийн /гэмтлийн/ эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу засал эмчилгээ /протез, ортопед/-г гадаад оронд хийлгэхэд түүний нэг удаагийн үнийг Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийг баримтлан олгож болно⁹. Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийн жагсаалтыг эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална¹⁰.

Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас рашаан сувилалд эмчлүүлж сувилуулбал рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилалд ирэх, очих унааны зардлыг галт тэрэг, автомашины

⁹ “Жишиг үнийн жагсаалт шинэчлэн батлах тухай” Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2003 оны 5 дугаар сарын 12-ний өдрийн 74/116 тушаал “Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/-ийн төлбөр олгох журам”.

¹⁰ “Жишиг үнийн жагсаалт шинэчлэн батлах тухай” Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 168/457 тушаал.

тухайн үед мөрдөж буй тарифыг үндэслэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас жилд нэг удаа төлбөр гаргуулж болно.

Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдвал түүнд энэ даатгалд шимтгэл төлж ажилласан хугацааг үл харгалзан тэтгэвэр, тэтгэмж олгоно.

Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь, хэмжээ, хугацааг Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛ

Даатгуулагч нь ажилгүйдлийн даатгалд даатгуулснаар ажилгүйдлийн тэтгэмж, сургалтын зардал авах боломжтой. Ингэхдээ та ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд төлсөн, түүний дотор сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд ажилгүйдлийн тэтгэмж авах, мэргэжлийн сургалтад хамрагдах эрхтэй.

Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан сүүлийн 3 сарын орлогын дунджаас 5 хүртэл жил ажилласан бол 45 хувь, 5-10 хүртэл жил 50 хувь, 10-15 хүртэл жил 60 хувь, 15 ба түүнээс дээш жил 70 хувиар бодож олгодог.

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг оршин суугаа газрынхаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс эсвэл нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн ажлын 76 өдөр дуустал хугацаанд олгоно.

Ажилгүйдлийн тэтгэмжийг ажлын 76 өдрөөр бодож олгох боловч тэтгэмжээс ажлын 36 өдрийг хасаж олгох дараах нөхцөл байдаг. Үүнд:

- Та өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээ цуцалсан;
- Хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмжийг ажлын 40 өдрөөр олгож бодно гэсэн үг;
- Даатгуулагч ажлаас халагдсанаас хойш 14 хоногийн дотор өөрийн оршин суугаа аймаг, сум, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгүүлэх үүрэгтэй. Хэрэв ажлаас халагдсаны дараа хүндэтгэх шалтгаангүйгээр 14 хоногийн дотор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний албанд бүртгүүлээгүй тохиолдолд олговол зохих тэтгэмжээс 14 хоногоос дээш хожимдсон хугацааны ажлын өдрүүдэд ногдох тэтгэмжийг хасч олгоно.

Тухайлбал, даатгуулагч ажлаас халагдсан тушаал гарснаас хойш 24 хоногийн дараа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний албанд бүртгүүлбэл түүнд ажлын 76 хоногийн бус ажлын 66 хоногийн тэтгэмж олгоно.

Хөдөлмөр эрхлэлтийн алба нь ажилгүйдлийн тэтгэмж авах болзол хангасан даатгуулагчийн хүсэлтээр түүнийг ажилгүй болсноос нь хойших 6 сарын дотор мэргэжил олгох болон давтан сургалтад хамруулж, сургалтын зардлыг ажилгүйдлийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

САЙН ДУРЫН ДААТГАЛ

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагч **Та тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын** төрөл тус бүрд даатгуулах эрхтэй.

Сайн дураар даатгуулагч нь гэрээнд зааснаар¹¹ шимтгэл төлөхөөр тохирсон сарын орлогын дүнгээс тэтгэврийн даатгалд-10.0 хувь, тэтгэмжийн даатгалд -1.0 хувь, үйлдвэрлэлийн осол,

¹¹ Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах иргэд оршин суугаа аймаг, сум, дүүргийнхээ нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/-тай гэрээ байгуулна. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж 1 хувийг даатгуулагч /иргэн/, нөгөө хувийг нийгмийн даатгалын хэлтэс / байцаагч / -т хадгална.

мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд-1.0 хувиар тооцож шимтгэлээ төлнө.

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах иргэд нийгмийн даатгалын байгууллагатай тохиролцон хоёр талын гэрээнд шимтгэл тооцох сарын орлого, шимтгэл төлөх хугацаагаа тодорхой тусгаж өгнө.

- Шимтгэл тооцох сарын орлогын доод хэмжээ нь Засгийн газрын баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.
- Шимтгэл тооцох сарын орлогын дээд хэмжээ тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг¹² 10 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.

Сайн дураар даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлээ нөхөн төлж болохгүй. Зөвхөн нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан өдрөөс эхлэн гэрээнд тохиролцсон хугацаанд шимтгэлээ төлнө.

Сайн дураар даатгуулагч нь аж ахуйн нэгж, байгууллагад ажилд орох, тэтгэвэр тогтоолгох, нас барах зэрэг тохиолдолд шимтгэлийн тооцоог дуусгаж, аймаг, сум, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /ажилтан/ сайн дураар даатгуулагчийн гэрээг цуцалсан тухай шалтгааныг түүний нийгмийн даатгалын дэвтэрт бичиж баталгаажуулж өгнө.

Сайн дураар даатгуулагч хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан тохиолдолд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэрийг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, оршуулгын тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тахир

¹² Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 07 тоот тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2013 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн нэг цагт 1142 төгрөг 85 мөнгө, сард 192000 төгрөг байхаар тогтоов.

дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, тэтгэврийн даатгалын шимтгэл, рашаан сувилалд эмчлүүлсний зардал авах эрхтэй.

Гэхдээ дээрх эрхүүдийг эдлэхийн тулд нийгмийн даатгалын шимтгэл төлөх талаар дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод оногдох нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тооцон түүний гэрээнд заасан хугацаанд оршин суугаа аймаг, сум, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын сангийн дансанд төлөх;
- Шимтгэл төлсөн тухай орлогын мэдүүлэг /баримт /-ийг хариуцсан нийгмийн даатгалын байцаагчид аваачиж, төлсөн шимтгэлээ нийгмийн даатгалын дэвтэрт бичүүлж, баталгаажуулж авах;
- Өөр аймаг, нийслэл, сум дүүрэгт шилжин суурьших тохиолдолд төлсөн шимтгэлийн тооцоог нийгмийн даатгалын байцаагчтай хийж дуусган, гэрээг цуцлуулж, энэ тухай нийгмийн даатгалын дэвтэрт бичиж баталгаажуулсан байх үүрэгтэй.

Сайн дураар даатгуулагч нь сард төлбөл зохих шимтгэлээ нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд дутуу төлөгдсөн буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувиар тооцож алданги ногдуулан төлүүлнэ. Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих алдангийн 50 хувиас хэтрэхгүй байна.

Сайн дураар даатгуулагч нь үйлдвэрлэлийн осолд орсон тохиолдолд осолд өртсөн тухайгаа оршин суугаа аймаг, сум, дүүргийнхээ нийгмийн даатгалын хэлтэс /ажилтан /-т мэдэгдэнэ. Ослын актыг аймаг сум, дүүргийн Засаг даргын томилсон байнгын комисс судлан тогтооно.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн тухай хуулиар эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг хангах зорилгоор улсаас тэтгэвэр тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэдэг.

Энэ үйл ажиллагаанд Нийгмийн халамжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан болзол, шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамрагдах эрхтэй.

Нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь нийгмийн халамжийн тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэсэн төрлүүдтэй байдаг.

Нийгмийн халамжийн тэтгэврийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй, 16 насанд хүрсэн одой иргэн, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэгт сар бүр олгодог¹³.

¹³ Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн сард 103.600 Засгийн Газрын 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 81 дүгээр тогтоол

Нийгмийн халамжийн тэтгэмж нь:

- Асаргааны тэтгэмж;
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж;
- Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж;
- Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж гэсэн төрлүүдтэй байдаг.

Асаргаа шаардлагатай иргэнийг асарч байгаа иргэнд асаргааны тэтгэмж¹⁴ сар бүр олгодог. Энэ тэтгэмжийг дараах иргэд авах эрхтэй. Үүнд:

- Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа;
- Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа;
- Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;
- Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа хүмүүс асаргааны болон нөхцөлт мөнгөн тэтгэмжийг авах эрхтэй.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дор дурдсан өрх, иргэнд олгохоор хуульчилсан. Үүнд:

¹⁴ Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн сард 48,000, Засгийн Газрын 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 81 дүгээр тогтоол

- Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх;
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн;
- Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн;
- Гэр оронгүй тэнэмэл өрх, иргэн;
- Улсын зардлаар төрөлжсөн асрамжийн газар асрамжлан өсгөхийг эцэг, эх нь зөвшөөрсөн дөрөв хүртэлх насны гурав ба түүнээс дээш ихэр хүүхдээс бусад хоёр ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрхөд онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг нэг удаа;
- Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдэд сард нэг удаа, байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн улиралд нэг удаа;
- Гурав ба түүнээс дээш тооны 14 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/; "Эхийн алдар" нэгдүгээр зэргийн одон, эсхүл "Эхийн алдар" хоёрдугаар зэргийн одонтой эхэд мөнгөн тусламж давхардуулахгүйгээр жилд нэг удаа авах эрхтэй.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 14 хүртэл насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-эд жилд нэг удаа¹⁵, 2012 оны 7 сарын 1-ний өдрөөс хойш шинээр төрсөн болон 4 хүртэлх насны 2 ихэр хүүхэд¹⁶ тус бүрт нэг удаа, 3 болон түүнээс дээш ихэр хүүхэд¹⁷ тус бүрт нэг удаа, 16 хүртэлх насны байнгын асаргаатай хүүхдэд¹⁸ сард нэг удаа 16-аас дээш насны байнгын асаргаа шаардлагатай иргэнд¹⁹ улиралд нэг удаа олгоно.

¹⁵ 120,0 мянган төгрөг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

¹⁶ 1,0 сая төгрөг, мөн тэнд

¹⁷ 5,0 сая төгрөг, мөн тэнд

¹⁸ 60,000 төгрөг, мөн тэнд

¹⁹ 60,000 төгрөг, мөн тэнд

Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийг эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар бүр олгоно²⁰. Тухайн эх хүүхдээ төрүүлсний дараа нас барсан бол уг хүүхдийн эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, үрчилж авсан эх /эцэг/ нь тэтгэмжийг үргэлжлүүлэн авах эрхтэй.

Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон, 2012 оны 7 сарын 1-ний өдрөөс хойш хорих газраас суллагдсан өөрийн гэсэн орон гэргүй иргэн, гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэн болон 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны залууст²¹ нэг удаа мөнгөн тусламж олгоно.

Нийгмийн халамжийн тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авахыг хүссэн иргэн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах хүсэлтээ холбогдох бичиг баримтын²² хамт сум, хорооны нийгмийн ажилтанд гаргаж өгөх үүрэгтэй.

Нийгмийн халамжийн үйлчилгээ нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ; төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэсэн төрөлтэй байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настан, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хүчирхийлэлд өртсөн иргэн, өрх тойлгойлсон эх /эцэг/, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнийг сэргээн засах үйлчилгээ, гэрийн үйлчилгээ, өдрийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх, сургах үйлчилгээ, явуулын үйлчилгээ гэх мэт олон төрлийн үйлчилгээг үзүүлдэг.

²⁰ 40.000 төгрөг, мөн тэнд

²¹ 1 сая 500 мянган төгрөг, мөн тэнд

²² Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам"

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нь ахмад настны асрамжийн үйлчилгээ; хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээ; хүнд нөхцөлд байгаа 18 хүртэлх насны хүүхдийн асрамжийн үйлчилгээ; гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн үйлчилгээ гэсэн төрөлтэй байна:

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дараах хөнгөлөлт, тусламжууд үзүүлж байна. Үүнд:

Ахмад настаны хувьд магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд сувилуулбал 1 талын унааны зардал болон эрхийн бичгийн үнийн 50 хувийг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд мөн ижил хөнгөлөлттэй бөгөөд сувилуулах рашаан сувилал нь заавал магадлан итгэмжлэгдсэн байх шаардлагагүй.

Хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд рашаан сувилалд 50 хувийн хөнгөлөлт үзүүлэхийн зэрэгцээ түүний асран хамгаалагчид мөн 50 хувийн хөнгөлөлт үзүүлдэг. Мөн ахмад настны зориулалттай амралт сувилалд ахмадууд амрахаар бол төрөөс үзүүлэх хөнгөлөлтийг хоногт 15000 төгрөгөөр, хугацааг 10 хоногоор тогтоосон. Тухайн ахмадын зориулалттай амралт, сувилалд мөнгийг шилжүүлдэг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зусланд амрахад 50 хувийн хөнгөлөлт үзүүлэхийн зэрэгцээ орон нутгаас ирэх буцах зардлыг жилд нэг удаа асран хамгаалагчийн хамт олгохоос гадна хотод тусгай сургуульд сурахдаа дотуур байрнаас гадуур байвал унааны зардлыг жилд нэг удаа²³ олгодог. Түлээ нүүрсний хөнгөлөлт²⁴ жилд нэг удаа дараах иргэдэд олгож байна. Үүнд:

- Ганц бие харж хандах хүнгүй ахмад настан;
- Үр хүүхэд нь тэжээн тэтгэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настан;
- Бүрэн хараагүй, хэлгүй дүлий хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- Байнгын асаргаа шаардлагатай бөгөөд хөдөлмөрийн

²³ 200 мянган төгрөг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

²⁴ 200,0 мянган төгрөг, мөн тэнд

чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд протез, ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлтийг 3 жилд нэг удаа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд протезийн үнийн хөнгөлөлтийг 2 жилд нэг удаа хөнгөлөхөөр хуульд заасан.

Алдар цолтой ахмад настууд болох Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын цолтон ахмад настанд сар бүр²⁵, Монгол Улсын гавьяат цолтон ахмад настанд сар бүр²⁶ нэмэгдэл, Ахмад дайчинд сар бүр²⁷ өгч байна. Мөн эдгээр ахмадуудад нэмэгдлээс гадна ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу жилд нэг удаа орон нутагт ирж, буцах замын зардал, түлээ нүүрс, орон сууцны үнийн хөнгөлөлт үзүүлдэг.

Монгол Улсын ударник, төрийн соёрхолт, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн ахмад настуудад сард нэг удаа болон түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт өгч байна.

Боловсролыг дэмжих үйлчилгээнд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний²⁸ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд; бүтэн ба хагас өнчин хүүхэд; гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэний хүүхэд; төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэд; хорих ангиас суллагдсан хүүхдийг хамруулж сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт зэрэг тусламж, дэмжлэгийг үзүүлдэг.

²⁵ 200,0 мянган төгрөг, мөн тэнд

²⁶ 150,0 мянган төгрөг, мөн тэнд

²⁷ 200,0 мянган төгрөг, мөн тэнд

²⁸ Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн” гэж өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэний хүүхэд, хорих ангиас суллагдсан хүүхэд албан бус сургалтад хамрагдаж байгаа бол түүнд хүүхэд сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлтийг бүрэн буюу хэсэгчлэн олгоно.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэд асрамжийн газраасаа боловсролын зардал авч байгаа бол энэ хуулийн тусламж, дэмжлэгийг давхардуулан олгохгүй.

Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээний хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн төлөх; нийгмийн халамжид хамрагдагсдад үзүүлэх эрүүл мэндийн бусад үйлчилгээг үзүүлэх бөгөөд Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээн

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэдийн дотроос нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлсон хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн; гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн хамрагдана. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг олгох, халуун хоол, цайгаар үйлчлэх хэлбэртэй байна.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хөтөлбөр, журам, хэмжээг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталдаг.

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд зааснаар цэргийн тэтгэвэр нь **цэргийн алба хаасны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр** гэсэн төрөлтэй.

Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, галын болон хорих ял эдлүүлэх байгууллагад 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй, 20-иос доошгүй жил алба хаасан эмэгтэй, байлдааны нисдэг тэрэгний нисгэгчээр 23-аас доошгүй жил, байлдааны тийрэлтэт сөнөөгч онгоцны жинхэнэ нисгэгчээр 20-оос доошгүй жил алба хаасан генерал, офицер, ахлагч, байлдагч нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Мөн 10-аас доошгүй жил цэргийн жинхэнэ алба болон тагнуул, цагдаа, галын болон хорих ял эдлүүлэх байгууллагад алба хаасан цэргийн албан хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндийн байдал, цэргийн алба хаах нас хэтэрсэн шалтгаанаар халагдсан бол цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрээд **цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн** тогтоолгон авах эрхтэй.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиар цэргийн алба хаах насны дээд хязгаарыг ахлагчийн албыг 45 нас хүртэл, офицерын албыг дунд офицер 45 нас хүртэл, ахлах офицер 50 нас хүртэл, дээд офицер 55 нас хүртэл тус тус хааж болно. Харин эмэгтэйчүүд ахлагч, офицерын албыг цэргийн цол харгалзахгүй 45 нас хүртэл хааж болно. Цэргийн алба хаасны тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин, хөлсний 60 хувиар тогтооно. Хуульд заасан хугацаанаас илүү алба хаасан жил тутамд тэтгэвэр тогтоолгосон дундаж цалин, хөлснөөс 1.0 хувиар бодож нэмэгдэл олгоно.

Цэргийн албан хаагч нь дараах шалтгааны улмаас тахир дутуу болсон бол цэргийн **албан хаагч тахир дутуугийн тэтгэвэр** авах эрхтэй. Үүнд:

- Байлдааны болон энхийг сахиулах үүрэг гүйцэтгэх, байлдааны онгоцоор нислэг үйлдэх, байлдааны галт хэрэгслээр буудлага хийх, тэсэрч, дэлбэрэх хорт бодистой үүргийнхээ дагуу харьцах үед гарсан ослын, түүнчлэн улсын хил хамгаалах, тагнуул, цагдаа, галын болон хорих ял эдлүүлэх байгууллагын албан үүрэг гүйцэтгэж яваад гэмт халдлагад өртсөний болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас;
- Бусад албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас;
- Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдолгүй осол, ердийн өвчний улмаас цэргийн үүрэгтэн дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байхдаа, мөн цэргийн жинхэнэ албанаас халагдсан байлдагч, түрүүч орон нутагтаа хүргэгдэх үед тахир дутуу болсон бол.

Цэргийн албан хаагч, мөн түүнчлэн дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барахад түүний асрамжид байсан **гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр** авах эрхтэй.

Цэргийн албан хаагчийн тэтгэмж дараах төрөлтэй байна. Үүнд:

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж;
- Оршуулгын тэтгэмж;
- Нэг удаагийн тэтгэмж.

Цэргийн албан хаагч өвчилсөн, осолд өртсөний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан тохиолдолд, мөн цэргийн албан хаагч эмэгтэй хүүхдээ 196 хоног хүртэл

тээгээгүй дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн бол **хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж** авах эрхтэй.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл тахир дутуу болсон нь тогтоогдох хүртэлх хугацаанд ажлын өдрөөр тооцож олгоно.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар 13 долоо хоногоос хэтрэхгүй байна. Хорт хавдар болон сүрьеэгээр анх өвчлөхөд 26 долоо хоногийн тэтгэмж олгоно. Цэргийн албан хаагч хуанлийн жилд удаа дараа өвчилсөн тохиолдолд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг нийтдээ 26 долоо хоногоос илүүгүй хугацаанд олгоно.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 5 хүртэл жил ажилласан бол 50 хувь, 5-14 жил ажилласан бол 60 хувь, 15 ба түүнээс дээш жил ажилласан бол 80 хувиар бодож олгоно. Цэргийн албан хаагч, түүнчлэн дайчилгааны сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барахад түүний оршуулгад зориулан **оршуулгын тэтгэмж** олгоно.

Цэргийн албан хаагч нас барах, тэтгэвэрт гарах, орон тоо зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр болон цэргийн алба хаах нас хэтэрч халагдах тохиолдолд **нэг удаагийн тэтгэмж** олгох бөгөөд Цэргийн албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журмаар²⁹ зохицуулна.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсөнд дараах цалин хөлс, нэмэгдлийг оруулна. Үүнд:

²⁹ “Журам батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 38 дугаар тогтоол

- Эрх бүхий байгууллагаас тогтоож олгосон цалин хөлс;
- Цэргийн цолны мөнгө;
- Мэргэжлийн зэргийн нэмэгдэл;
- Хилийн нэмэгдэл;
- Цэргийн албыг удаан жил хаасны нэмэгдэл;
- Цэргийн байгууллагаас цэргийн албан хаагчид олгож буй хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого;
- Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын дундаж цалин, хөлсийг тэдний цэргийн алба хаасан сүүлийн 20 жил доторх аль дуртай дараалсан 5 жилийн цалин, хөлсний нийлбэрийг 60-д, 5 хүртэл жил алба хаасан бол ажилласан хугацаанд авсан цалин, хөлсний нийлбэрийг ажилласан сарын тоонд тус тус хуваан тодорхойлно;
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг тухайн цэргийн албан хаагчийн сүүлийн бүтэн ажилласан 3 сарын цалин, хөлсний сарын дунджаас тооцно.

Цэргийн албан хаагчийн тэтгэврийг тогтоох, олгох ажлыг тухайн тэтгэвэр авагчийн алба хааж байсан Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, галын болон хорих ял эдлүүлэх байгууллага буюу тэдгээрээс гэрээ байгуулсан этгээд эрхлэн гүйцэтгэнэ. Цэргийн албан хаагчийн нэг удаагийн тэтгэмжийг төрийн захиргааны холбогдох төв байгууллага, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмжийг тухайн анги, байгууллага нь олгоно.

Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацаанд цэргийн жинхэнэ алба болон тагнуул, цагдаа, галын болон хорих ял эдлүүлэх байгууллагад алба хаасан нийт хугацааг тооцно.

Генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагчаар 10-аас доош жил алба хаасан бол уг хугацааны шимтгэлийг³⁰ улсын төсвөөс нийгмийн даатгалын санд нэг удаа төлсөн тохиолдолд тухайн иргэний цэргийн албан хаагчаар ажилласныг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно.

³⁰ Засгийн газрын 2008 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 26 дугаар тогтоол.



ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг дараах Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан байдаг.

Хүн бүр өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл байх зайлшгүй шаардлагатай хоол хүнс, хувцас, орон байртай байх, эмнэлгийн тусламж болон нийгмийн хамгааллыг хүртэх эрхтэй.

(Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 25 дугаар зүйл)

Оролцогч улсуудын хүн бүрийн бие бялдрын болон сэтгэл санааны хувьд хүрч болох дээд түвшинд эрүүл байх хүн бүрийн эрхийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Нялхсын эндэгдлийг багасгах, хүүхдийн эрүүл чийрэг өсөлтийг хангах;
- Гадаад орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах;
- Халдварт өвчин, тухайн нутгийн өвчин, мэргэжлийн болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх тийм өвчинтэй тэмцэх;
- Эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, сувилах нөхцөлийг бүгдэд бий болгох.

(Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн олон улсын пактын 12 дугаар зүйл)

- Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;
- Монгол Улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно.

(Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 2, 6 дахь хэсэг)

Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хүрээнд:

- Эрүүл мэндийн зохистой үйлчилгээгээр цаг хугацаанд нь үйлчлүүлэх;
- Эрүүл, аюулгүй орчинд амьдрах;
- Цэвэр усаар хангагдах;
- Зохистой хоол хүнсээр хангагдах;
- Орон байраар хангагдах;
- Хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангагдах эрх;
- Мэдээлэл авах эрх;
- Нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн боловсрол зэрэг асуудлуудыг хамааруулдаг.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн асуудлаар төр хүлээх үүрэг:

- **Хүндэтгэх:** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээхэд тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын дагуу саад учруулахгүй байх үүрэгтэй. Түүнчлэн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны бохирдлыг бий болгож болохуйц үйл ажиллагаа гэх мэт хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх үйлдлийг зогсоох үүрэгтэй;
- **Хамгаалах:** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн бүрт тэгш эрхтэйгээр хүртээх боломжийг хангах, хохирохоос урьдчилан сэргийлсэн хууль, бодлого хэрэгжүүлэх, хохирлыг барагдуулах шударга механизм бүрдүүлэх, бусад арга хэмжээг авах үүрэгтэй;
- **Хангах:** Үндэсний эрүүл мэндийн бодлогыг хүлээн зөвшөөрөх, төсвөөс хангалттай хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулах, шаардлагатай үйлчилгээгээр хангах буюу хувь хүн шаардлага хангасан, хангалттай эмнэлгийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Үүнд эрүүл мэндийн асрамж, сувилгааны үйлчилгээ, ундны цэвэр ус гэх мэт.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тавигдах шаардлага

- **Хүрэлцээтэй байх:** Нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм тариа, үйлчилгээ, эмч, эмнэлгийн ажилтнууд, хөтөлбөр зэрэг нь хүн бүрт хүрэлцэхүйц хэмжээнд байх ёстой;
- **Хүртээмжтэй байх:** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй, бодит, эдийн засгийн болон мэдээлэл авах боломжит хэлбэрээр хүртээмжтэй байх ёстой;
- **Нийцтэй байх:** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь анагаах ухааны ёс зүй болон уламжлалт ёс заншилд тохирсон буюу өөрөөр хэлбэл, хувь хүн, цөөнх, ард иргэд болон хэсэг бүлэг хүмүүсийн зан үйл, ёс заншлыг хүндэтгэсэн, хүйсийн болон насны онцлогт нийцсэн, эмчлүүлэгчийн нууцыг хадгалж, эмчилгээ, үйлчилгээ хийх чадавхитай байх ёстой;
- **Чанартай байх:** Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эм тариа, эмчилгээ, үйлчилгээ нь шинжлэх ухаан, анагаах ухаан, эрүүл ахуйн шаардлагад тохирсон сайн чанартай байх ёстой.

Иргэний эрүүл мэндийн даатгал

Иргэний эрүүл мэндийн даатгал нь даатгуулагч эрүүл мэндийн эрсдэлд орох үед санхүүгийн дэмжлэг авах зорилгоор өөрөө болон ажил олгогч, төрөөс хуульд заасан журмын дагуу даатгалын шимтгэл төлж, даатгалын санг бүрдүүлэх, эрсдэлд өртсөн даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг уг сангаас төлөх нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм.

Эрүүл мэндийн даатгалын хэлбэрүүд

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар эрүүл мэндийн даатгал нь заавал, сайн дурын гэсэн хоёр

хэлбэртэй. Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулна. Иймээс иргэн та эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, шимтгэлээ хуульд заасан хувь хэмжээ, хугацаанд төлөх үүрэгтэй. Харин Монгол Улсад амьдарч байгаа тодорхой хөдөлмөр эрхлээгүй гадаадын иргэн эрүүл мэндийн даатгалд даатгуулах эсэхээ өөрөө шийднэ.

Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд:

- Дотрын өвчний;
- Мэдрэлийн тогтолцооны өвчний;
- Нүд, чих, арьс ба халимын, яс, булчин, холбох нэхдэсийн өвчний;
- Яаралтай бус гэмтэл, мэс заслын өвчний тусламж үйлчилгээ хамаардаг.

Монгол Улсын иргэн түүний эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсэхээс үл хамааран дараах тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцдаг.

- Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ;
- Сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн болон удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах зарим эмгэгийн эмчилгээ, халдвар судлалын үйлчилгээ, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх тарилга, халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйжүүлэлт;
- Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ /зөвхөн төрөлт, жирэмслэлттэй холбоотой шалтгаанаар/;
- Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, осол болон нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлтийн үед гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ;
- Аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврахаар, эсхүл их хэмжээний хохирлоос сэргийлж яваад гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ.

Харин даатгуулсан эсэхээс үл хамааран төрөөс төлбөрийг нь төр хариуцах болон эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд хамаарахгүй тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг өөрөө хариуцна.

Иргэд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлөх хэмжээ

Заавал даатгуулагч	Төлөх шимтгэлийн хэмжээ /₮/		ЭМД-ын шимтгэлийг хариуцаж төлөх байгууллага
	Сарын	Жилийн	
16 хүртэлх насны хүүхэд, хэрэв ЕБС-д суралцаж байгаа байгаа бол 18 хүртэлх насны хүүхэд	670	8040	Улсын төсвөөс
Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн	670	8040	Улсын төсвөөс
Хүүхдээ 2 (ихэр бол 3) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг)	670	8040	Улсын төсвөөс
Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	670	8040	Улсын төсвөөс
Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэн	670	8040	Улсын төсвөөс
Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	Сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын 4 хувиар, үүнээс ажил олгогч 2%-ийг, даатгуулагч өөрөө 2%-ийг төлнө.		
Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	Татварын албанд гаргасан орлогын мэдүүлгийг үндэслэн нийт орлогын 1 хувиар		
Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч	670	8040	Өөрөө
Малчин	670	8040	Өөрөө
Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд	670	8040	Өөрөө
Ял эдэлж байгаа хоригдол	670	8040	Хорих байгууллага
Гадаадын иргэн, харьяалалгүй иргэд	670	8040	Өөрөө

Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээ

Даатгуулагч эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ жил бүр төлөх үүрэгтэй бөгөөд даатгуулсан тохиолдолд тухайн жилдээ зардлыг дараах 8 төрлийн тусламж үйлчилгээний эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх эрхээр хангагдана. Үүнд:

- Хэвтэн эмчлэх тусламж, үйлчилгээ;
- Амбулаторийн тусламж, үйлчилгээ;
- Оношлогоо шинжилгээ;
- Уламжлалт эмчилгээ;
- Нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ/ рашаан, сувиллын зардал/;
- Өдрийн эмчилгээ;
- Хөнгөвчлөх эмчилгээ;
- Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт.

Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг даатгуулагчид олгох хэмжээ

Нэг даатгуулагчийн тусламж, үйлчилгээний хувьсах зардлын хэмжээг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлан улсын хэмжээнд хэрэгжүүлж байна. Тухайлбал, даатгуулагч дараах төрлийн үйлчилгээ авсан тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын хэмжээг хүснэгтээр харууллаа. Үүнд:

№	Тусламж үйлчилгээний төрөл	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага /₮/	Хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллага /₮/
1	Хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ	300 000	175 000
2	Өдрөөр эмчлэх тусламж, үйлчилгээ	135 000	0
3	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	15 000	0
4	Оношлогоо шинжилгээ	55 000	0
5	Уламжлалт эмчилгээ	117 000	117 000
6	Нөхөн сэргээх эмчилгээ	110 000	110 000
7	Хөнгөвчлөх эмчилгээ	300 000	175 000
8	Дараалсан 3 жилийн хугацаанд тусламж, үйлчилгээний зардал гаргаагүй даатгуулагчийг нэг удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулах үйлчилгээ	80 000	80 000

Та даатгалын сангаас үзүүлэх тусламж үйлчилгээний хэмжээний дагуу эрүүл мэндийн төрлөөс хамааран төрийн өмчийн эсхүл хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үйлчилгээ авах боломжтой ба тухайн хэмжээнээс илүү үнэтэй үйлчилгээ хийлгэвэл зөрүү мөнгөө эмчлүүлэгч та өөрөө төлнө. (2013 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 459/280/182 дугаар тушаалын хавсралт)

Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ

Эдгэрэх найдваргүй өвчтэй хүний эмнэлгийн тусламж авах эрхийг хангах, амьдралын чанарыг нь дээшлүүлэх чухал арга зам бол хөнгөвчлөх тусламж үйлчилгээ байдаг. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ гэдэг нь төгс эмчилгээгүй болж, амьдралын төгсгөлийн шатанд орсон хүнд өвчтэй хүн болон түүний гэр бүлийнхэнд амьдралын чанарыг нь дээшлүүлэх, нийгэм-сэтгэл зүйн, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, өвчтөний өвдөлт ба бусад зовиур шаналгааг хөнгөвчлөхөд чиглэсэн асаргаа, сувилгаа, эмчилгээ, сургалт, удирдлага зэрэг цогц үйлчилгээ юм.

Эрүүл мэндийн даатгал төлсөн хэрнээ ямар нэгэн тусламж үйлчилгээ аваагүй хүмүүст үзүүлэх урамшуулал

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан журамд зааснаар даатгуулагч дотор, мэдрэл, эмэгтэйчүүдийн үзлэг, сүрьеэ, нүд, чих хамар хоолойн эмчийн үзлэгт орж, цусны дэлгэрэнгүй шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, цуллаг эрхтний чанд авиан оношлогоо, түрүү булчирхайн чанд авиан оношлогоо, зүрхний бичлэг, тархины цахилгаан бичлэг, нүдний уг дурандах, цээжний зураг авах шинжилгээ хийлгэх үйлчилгээ авч болно.

Даатгуулагчийн эдлэх эмийн үнийн хөнгөлөлт

Даатгуулагч өөрийн өрх (сум, баг)-ийн эмчийн жороор эмийн сангаас зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад заасан үнийн хөнгөлөлт олгох эм авсан бол уг эмийн үнийн тодорхой хувийг даатгалын сангаас олгож үлдэх хувийг иргэн өөрөө төлнө.

Та төрийн албан хаагч бол: Тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцна. (2002 оны Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8)

Урьдчилан сэргийлэх үзлэг болон өвдсөн тохиолдолд та өөрийн оршин суугаа газрын харьяаллаар дараах шатлалын дагуу эмнэлгийн байгууллагад хандана.

Өрх, Сум, Сум дундын эмнэлэг зэрэг I шатлалын эмнэлгүүд хүн амд зайлшгүй болон эмнэлгийн анхан шатны

тусламж, үйлчилгээ үзүүлдэг бол аймаг, дүүрэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүд зэрэг II шатлалын эмнэлгүүд нь үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг. Харин III шатлалын болох эмнэлгүүд улсын хэмжээнд төрөлжсөн, мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байна.

Та эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахаар бол дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ.

Та I шатлалын эмнэлэгт хандах бол:

- Иргэний үнэмлэх эсхүл төрсний гэрчилгээ;
- Эрүүл мэндийн даатгалын дэвтэр.

Харин II болон III шатлалын эмнэлэгт хандах бол:

- Иргэний үнэмлэх эсхүл төрсний гэрчилгээ;
- Эрүүл мэндийн даатгалын дэвтэр;
- 13 А маягтыг бүрдүүлэх шаардлагатай.

13А маягт гэдэг нь "Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас" буюу дараагийн шатны эмнэлэг, мэргэжлийн байгууллага хооронд өвчтөний талаар мэдээлэл солилцох зориулалттай, мэргэжлийн үг үсгээр онош бичигддэг маягт юм. 13А маягтыг Эрүүл мэндийн сайдын 2005 оны 203 тоот тушаалаар баталж, 2005 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөж байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүд болон ажилчдын харьцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээний зөрчил, албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол дээд шатны удирдах албан тушаалтанд гомдол гаргана.



СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

Боловсрол нь өөрөө хүний эрх болохын хамт мөн хүний эрх, эрх чөлөөг хангах үндэс суурь болдог. Тиймээс сурч боловсрох эрхийг олон улсын эрх зүйн гэрээ конвенциор баталгаажуулж, нэгдэн орсон улс орнуудад тодорхой үүрэг хариуцлага хүлээлгэдэг. Сурч боловсрох эрхийн тухай заалтууд НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Боловсрол дахь Алагчлалын эсрэг Конвенц (1960), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (1966), Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (1989) зэрэгт тусгагдсан байдаг. Эдгээр хүний эрхийн баримт бичгүүдэд боловсролын зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Хүний авьяас чадварыг хөгжүүлэх, соёл иргэншил, хэл, үнэт зүйлс, хүний эрхийн зарчмыг хүндэтгэх, байгаль орчныг хайрлан хамгаалах үзлээр хүмүүжүүлэх;
2. Бүх хүмүүсийг нийгэмд илүү үр нөлөөтэйгээр оролцохыг чадваржуулах;
3. Тэгш эрх, хүн хүнээ хүндэтгэх, үндэстэн ястан, шашны бүлгүүдийн эв найрамдал, хоорондох ойлголцлыг дээшлүүлэх.

Боловсролын зорилго нь хүн бүрийн чадавх бололцоо, суралцахуйн цар хүрээгээр тодохойлогдох бөгөөд боловсрол нь хүний эрхийг хүндэтгэх, хангахад чиглэсэн бэлтгэл үйл ажиллагаа хэмээн үздэг. Иймд боловсрол нь зөвхөн сургуулийн орчинд сурах биш харин зохистой суралцахуй, хөгжлийн үйл явцаар дамжуулан амьдралын өргөн хүрээний туршлага эзэмшүүлэхэд чиглэдэг. Мянганы хөгжлийн зорилтуудын талаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын баримт бичигт "Боловсрол бол хүний

эрх бөгөөд үгээгүй ядуу байдал, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих явдлыг багасгах, ардчилал, энх тайван хүлээцтэй байдал, хөгжлийг дэмжих гол хүчин зүйл мөн" гэж тодорхойлжээ.

Сурч боловсрох эрхийн агуулгад:

- Хүн бүрт бага боловсролыг заавал, үнэ төлбөргүй олгох;
- Үнэ төлбөргүй боловсрол олгох замаар техникийн болон тусгай мэргэжлийн боловсролыг оролцуулан дунд боловсролыг нийтэд хүртээлтэй болгох;
- Авьяас чадвартай нь уялдуулан хүн бүрт дээд боловсрол эзэмших боломжийг хүртээмжтэй олгох;
- Хүүхдэд олгох боловсролын чиглэлийг сонгоход эцэг эх давуу эрх эдлэх;
- Төрөөс тогтоосон шаардлагыг хангаж буй тохиолдолд хувь этгээд, байгууллага сургууль байгуулах;
- Анхан шатны боловсролгүй буюу сургуульд суралцаагүй хүмүүсийн боловсролын анхны мэдэгдэхүүнтэй болгох явдлыг дэмжих, эрчимжүүлэх зэрэг ойлголт орно.

Боловсрол бол тогтонги, үл өөрчлөгдөгч зүйл бус харин өөрийн салшгүй үнэт зүйл болох хүний эрхийг агуулан байнга өөрчлөгдөн хувирагч үйл явц юм. Иймд хүмүүс зөвхөн сурч боловсрох төдий бус хүний эрхэд суурилсан чанартай боловсрол эзэмших эрхтэй гэж үздэг. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Сурч боловсрох эрхийн асуудлаарх Ерөнхий зөвлөмж N13 (1999)-ын оршилд "боловсрол бол нийгмээсээ тусгаарлагдсан хүүхэд, насанд хүрэгчдийн хувьд ядуурлаас ангижрах, нийгмийн харилцаанд бүрэн оролцох гол хэрэгсэл" хэмээн онцолсон байдаг.

Иймд боловсрол дахь эрхэд суурилсан хандлага өөрөө зайлшгүй биелэх ёстой шаардлага юм. Сургууль болон сурах бичиг, сургалтын орчин нь үгээр болоод үйл хэлбэрээрээ хүний

эрхэд хүндэтгэлтэй хандах, бүх хүнд чанартай боловсролыг хүртээх үйл ажиллагааны цогц юм. Өөрөөр хэлбэл, хүн зөвхөн сурч боловсрох эрхтэй бус болохыг тусгайлан зааж, боловсрол дахь эрхэд суурилсан хандлагыг чухалчлан үзэх болжээ. Энэхүү гурван хандлагыг авч үзэхгүйгээр боловсролд холбогдох хүний эрх биеллээ олж чадахгүй юм. Үүнд:

1. Боловсрол хүртээмжтэй байх эрх

- Хүүхэд төрснөөс эхлэн насан турш сурч боловсрох;
- Боловсрол нь боломжтой, нийцтэй байх;
- Тэгш бололцоо олгох.

2. Чанартай боловсрол эзэмших эрх

- Өргөн хүрээтэй, амьдралд нийцтэй, тэгш хамруулах хөтөлбөр;
- Эрхэд суурилсан сургалт ба үнэлгээ;
- Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин.

3. Сургалтын орчинд хүндэтгэл хүлээх эрх

- Ялгаатай байдлыг хүндэтгэх;
- Оролцох эрхийг хүндэтгэх;
- Нэгдэл нягтралыг хүндэтгэх.

Сурч боловсрох эрх нь позитив эрх тул уг эрхийг хангах, хэрэгжүүлэхэд төрийн үүрэг хариуцлага чухлаар тавигддаг. Сурч боловсрох эрхийн талаар төрийн хүлээх үүргийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 13 дугаар зөвлөмжид хүн бүрт боловсрол олгохын тулд боловсрол нь боломжтой, хүртээмжтэй, хүлээж авахуйц, амьдралд тохирохуйц байх гэсэн 4А-гийн зарчмаар тайлбарласан байдаг. Сурч боловсрох эрхийн гурван үндсэн оролцогчид нь төр, эцэг эх, хүүхэд юм.

Тэдгээрийн дунд гурвалсан харилцаа байх бөгөөд үүний хамт багш, бодлого боловсруулагчид, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил зэрэг бусад оролцогчдын хувь нэмэр, үүрэг хариуцлагыг чухалчлан үзэх ёстой.

Сурч боловсрох эрх нь хүн төрснөөс эхлэх бөгөөд ямар нэгэн насны хязгаарлалт байхгүй юм. Хүн бүр өөрийн эрхэм чанараа хүндэтгүүлэх эрхтэй бөгөөд тэдний энэхүү түгээмэл эрх нь боловсролын харилцаанд мөн хүндлэгдэх ёстой. Энэ шаардлагыг хангахын тулд боловсролын харилцаа нь хүн бүрийг адил хүндэтгэн үзэх, утга төгөлдөр оролцох бололцоог бүрдүүлэх, хэл, соёл, шашны ялгааг хүндэтгэх, бүх хэлбэрийн хүчирхийллээс ангид байх зэрэг хүний эрхийн зарчмуудтай нийцэн тохирч байх ёстой. Мөн охид, эмэгтэйчүүд, уугуул хүн ам, алслагдсан нутаг дэвсгэрт амьдарч буй хүмүүс, гудамжны хүүхэд, цагаач болон нүүдэлчид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хэл болон соёлын цөөнх зэрэг эмзэг болон тусгай хэрэгцээт бүлгийнхэнд боловсрол хүртээмжтэй байх талаар онцлон анхаарч байна.

Иймд иргэн та бүхэн өөрийн сурч боловсрох хэрэгцээ сонирхол, эрхээ танин мэдэж, боловсролын харилцааны идэвхитэй оролцогч, үр шимийг хүртэгч байна гэдэгт найдаж байна.



ӨВЧТӨНИЙ ЭРХ

Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа хэн болов ч эрүүл мэндээ хамгаалуулахаар эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхтэй. Өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх асуудлыг Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээ, конвенциар баталгаажуулсан байдаг. Иргэнийг эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхээр хангаж, хамгаалах, хүндэтгэх нь төрийн үүрэг мөн.

Иргэний эрүүл мэндийг хамгаалсан хууль, эрх зүйн баримт бичгүүд

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд:

Хүн бүр өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл байх зайлшгүй шаардлагатай хоол хүнс, хувцас, орон байртай байх, эмнэлгийн тусламж болон нийгмийн хамгааллыг хүртэх эрхтэй.

Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн олон улсын пакт:

12 (а) нялхсын эндэгдлийг багасгах, хүүхдийн эрүүл чийрэг өсөлтийг хангах, халдварт өвчин, тухайн нутгийн өвчин, мэргэжлийн болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, өвчилсөн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ, сувилах нөхцөлийг бүгдэд бий болгох.

Монгол Улсын Үндсэн Хууль:

- Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй.

- Монгол Улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно.

Эрүүл мэндийн тухай хууль

Эрүүл мэндийг хамгаалах технологи:

Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний стандарт

Сүрьеэтэй өвчтөний тусламж үйлчилгээний тунхаг бичиг

Иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй авах эрхтэй.

Эрүүл мэндийн тухай хуулиар өвчтөний эрхийг тусгайлан хуульчилж өгсөн. Монгол улсын иргэн дараах тусламж, үйлчилгээний үнэ төлбөргүй авах эрхтэй. Үүнд:

- Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ;
- Сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн болон удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах зарим эмгэгийн эмчилгээ, халдвар судлалын үйлчилгээ, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх тарилга, халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйжүүлэлт;
- Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ /зөвхөн төрөлт, жирэмслэлттэй холбоотой шалтгаанаар/;
- Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, осол болон нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлтийн үед гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ;
- Аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврахаар, эсхүл их хэмжээний хохирлоос сэргийлж яваад гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ.

Иргэн танд эмнэлгийн тусламж, үйлчилгээ хэрэгтэй болсон бол: Өөрийн оршин суугаа газрын харьяалах I, II шатлалын эмнэлгийн байгууллагад хандана. Яаралтай тусламжаас бусад эмнэлгийн тусламжийг өрх, сум, сум дундын эрүүл мэндийн байгууллагын ерөнхий мэргэжлийн эмчийн илгээх бичиг (13А маягт)-ээр III шатлалын эмнэлэгт хандаж үйлчлүүлэх эрхтэй.

Дээрх эрхийн хүрээнд Монгол Улсын эрүүл мэндийн тухай хуульд өвчтөний эдлэх эрхийг баталгаажуулж өгсөн.

- Түргэн тусламжийн үйлчилгээ авах;
- Эрүүл мэндийн зохистой үйлчилгээгээр цаг хугацаанд нь үйлчлүүлэх;
- Өөрийн эрүүл мэндийн тухай мэдээллийг эмч, эрүүл мэндийн байгууллагаас авах;
- Халдварт өвчнөөс бусад тохиолдолд эмчилгээ, оношлогоо шинжилгээ хийлгэхээс татгалзах;
- Эмчилгээ үйлчилгээний талаар холбогдох байгууллагад гомдол гаргах;
- Эрүүл мэндийн байгууллага, ажилтнаас мэдээлэл авах;
- Өөрийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн нууцыг хадгалуулах;
- Хүндэтгүүлэх ба ялгаварлан гадуурхалтаас ангид байх;
- Сэтгэл ханамжтай байдлаар тусламж, үйлчилгээ авах;

Мөн иргэн дархлаажуулалтын талаар дараах эрх эдэлнэ.

- Дархлаажуулалтын тухай бодит мэдээллийг эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс шаардаж авах;
- Сэргийлэх тарилгын үндэсний товлонд орсон болон тархвар судлалын заалтаар хийх сэргийлэх тарилгыг төлбөргүй хийлгэх;
- Сэргийлэх тарилгыг хийлгэхдээ төрийн болон холимог,

хувийн өмчлөлийн аль ч хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагыг сонгох;

- Тарилгын дараах хүндрэлийн үед төв, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад төлбөргүй эмчлүүлэх;
- Эмчийн заалтаар сэргийлэх тарилгаас татгалзах.

Мөн төгс эмчилгээгүй болж, амьдралын төгсгөлийн шатанд орсон хүнд өвчтэй хүн болон түүний гэр бүлийнхэнд амьдралын чанарыг нь дээшлүүлэх, нийгэм-сэтгэл зүйн, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, өвчтөний өвдөлт ба бусад зовиур шаналгааг хөнгөвчлөхөд чиглэсэн асаргаа, сувилгаа, эмчилгээ, сургалт, удирдлага зэрэг цогц үйлчилгээ сайжруулах замаар тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор "Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ" стандарт баталж, хэрэгжүүлэн хорт эдгэшгүй өвчтэй өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

Хөнгөвчлөх тусламж үйлчилгээг:

Анхан шатанд : өрхийн, сумын, багийн бага эмч, сувилагч, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үзүүлнэ;

Хоёр дахь шатанд: дүүргийн ба аймгийн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн эмч, аймгийн ба дүүргийн эмнэлэгт хөнгөвчлөх тусламж үйлчилгээний 5 хүртлэх ор, гэрээр үйлчилдэг хөнгөвчлөх тусламж үйлчилгээний хоспис, өдрийн хоспис, хоспис-амбулатори үйлчилнэ;

Гурав дахь шатанд: Хавдар Судлалын Төвийн хөнгөвчлөх эмчилгээний тасаг, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн хөнгөвчлөх эмчилгээний 1-ээс 2 ор, тусгайлан эрх авсан санхүүжилтийн тодорхой эх үүсвэртэй нарийн мэргэжлийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээний хоспис.

Тус 3 шатлалын үйлчилгээ үзүүлэх байгууллага нь өвчтөнийг хүлээн авах, үзлэг хийх, өвдөлт намдаах, сэтгэлийн ба биеийн шаналгаат шинж тэмдгийг хөнгөвчлөх эмчилгээ

хийх, өвчтөний биеийн байдлыг хянах, үйлчлүүлэгч, тэдний гэр бүлийн гишүүд ба асран сувилах хүнд боловсрол олгох, сургалт явуулах, судалгаа хийх зэрэг тусламж, үйлчилгээ орно.

Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний эмч, сувилагч, бусад эмнэлгийн ажилтан бүр хөнгөвчлөх тусламж үйлчилгээний үндсэн зарчмуудыг баримталж, үйлчлүүлэгчийн эрхийг хүндэтгэнэ.

- Өвчтөний өвдөлт, шаналгаат шинжүүд, сэтгэл санааны хямралыг арилгах ба бие сэтгэлийн зовиурыг хөнгөвчлөх, өвчтөний тав тухтай байдалд анхаарлыг төвлөрүүлэх;
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ нь хүний шаналгааг багасгах үүднээс үхлийг хурдасгахгүй, мөн өөд болох замд нь түүнд саад болохгүй;
- Өвчтөнг нас нөгчих мөч хүртэл нь хүн ёсоор боломжийн хирээр идэвхитэй амьдрах боломж олгох;
- Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ нь өвчтөн, түүний ар гэрийн хүсэлт, хэрэгцээнд нь тохирсон уян хатан байх ;
- Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөнийг ганцаардуулахгүй байх, өөд болох үед нь хамт байх;
- Өвчтөнд эмчилгээ , түүний үр дүн, гаж нөлөө, биеийн байдлын талаар үнэн зөв мэдээллийг болгоомжтой өгөх, өвчтөн, гэр бүлийн хооронд нээлттэй харьцааг дэмжих, амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөнийг хуурахгүй байх;
- Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөний гэр бүлийн гишүүдэд боломжийн хирээр туслах, тэдэнд нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, уй гашууг тайлахад туслах;
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээг хүний нас хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, албан тушаал, боловсрол харгалзахгүйгээр ижил тэгш хүртээмжтэй үзүүлэх;
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээг амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөнд өөд болтол нь тасралтгүй үзүүлэх;

- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээг олон мэргэжлийн багаар үзүүлэх ба багийн гишүүд бие биенийхээ үйл ажиллагааг дэмждэг, нээлттэй харилцаатай байх.
- Америкийн эмнэлгийн нийгэмлэгээс гаргасан өвчтөний эрхийн жагсаалтад:
- Эмчлүүлэгч өөрийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг авах;
- Эмч болон эмчилгээний төрлийг сонгох ;
- Түргэн тусламжийн үйлчилгээг хүртэх;
- Эмчилгээний шийдвэр гаргахад оролцох;
- Хүндэтгүүлэх ба ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх;
- Эрүүл мэндийн нууцаа хамгаалуулах;
- Гомдол хүсэлт гаргах эрхтэй болохыг дурдсан байна.

Сүрьеэтэй өвчтөний эрх:

Сүрьеэтэй өвчтөний тунхаг бичигт сүрьеэтэй өвчтөний эрх үүргийг тодорхойлон бичсэн байна.

Сүрьеэтэй өвчтөн дор дурдсан эрхтэй байна. Үүнд:

- Тусламж, үйлчилгээ: үнэгүй эрх тэгш сүрьеэгийн тусламж үйлчилгээг авах, Олон улсын сүрьеэгийн тусламж үйлчилгээний шинэ стандартад нийцсэн эрүүл мэндийн зөвлөгөө болон эмчилгээ авах, эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх кампанит ажлыг хүртэх эрхтэй байна.
- **Нэр хүнд:** Тусламж үйлчилгээг нэр төр, алдар хүндээ гутаан доромжлуулахгүй, ялгаварлан гадуурхахгүйгээр авах;
- **Мэдээлэл:** Эмчилгээ үйлчилгээний зардал, онош, өвчний явц, санал болгож буй эмчилгээний гарч болзошгүй эрсдэлийн талаарх мэдээлэл, өвчтөний түүхийн хуулбарыг авах, бусад өвчтөнүүдтэй уулзаж, сайн дураараа зөвлөлдөж туршлага солилцох;
- **Сонголт:** Эмчилгээний хоёр дахь хувилбарыг сонгох,

хими эмчилгээ түүний хор уршгийн талаар мэдээлэл авч мэс заслын эмчилгээг зөвшөөрөх эсвэл түүнээс татгалзах, судалгааны ажилд оролцох эсвэл эс оролцох;

- **Итгэл найдвар:** Өвчтөн нь хувийн нууцлал, нэр хүнд, шашин шүтлэг, ба соёлтой байх, эрүүл мэндийн байдлын талаарх мэдээллийг нууцлан хадгалах эрхтэй ба өвчтөний зөвшөөрлөөр мэдээллийг эрх бүхий хүнд өгөх;
- **Шударга байдал:** Эрүүл мэндийн эрх бүхий хүнд цаг тухайд нь үнэнч шудрагаар гомдол саналаа илэрхийлэх;
- **Зохион байгуулалт:** Сүрьеэгээр өвчилсөн хүмүүстэй хамтран олон нийтийн байгууллага байгуулах, түүнд элсэх эрхтэй бөгөөд эрүүл мэндийн тусламж үзүүлэгч эрх бүхий хүмүүсээс тусламж дэмжлэг авах;
- **Аюулгүй байдал:** Сүрьеэгийн эсрэг, зохих сэргээн засах эмчилгээ дууссаны дараа ажлын байрны аюулгүй байдлаар хангуулах, эмчилгээнд шаардлагатай нэмэлт хоол тэжээл болон хүнсний аюулгүй байдлаар хангуулах эрхтэй гэж тус тус зааж өгсөн байна.

Өвчтөн эрхээ эдлэхийн зэрэгцээ мөн тодорхой үүргийг хүлээнэ.

- Эмчлэгч эмчийн заавар, эмчилгээг цаг тухайд нь хийх;
- Эмч, сувилагч, бусад өвчтөнтэй хүндэтгэлтэй хандах;
- Эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрөө цаг тухайд нь төлөх үүрэгтэй.



1994 онд Египетийн Кайр хотноо хуралдсан "Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурал"-аас баталсан "Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"-т нөхөн үржихүйн эрхийн тодорхойлолтыг дараах байдлаар томъёолсон байна.

Нөхөн үржихүйн эрх нь:

- Гэр бүлийн хосууд болон аливаа хувь хүн төрүүлэх хүүхдийн тоо, тэднийг төрүүлэх газар, хугацааг чөлөөтэй бөгөөд хариуцлагатайгаар шийдэх;
- Энэ шийдвэрээ гаргахад хэрэгтэй мэдээлэл авахаас гадна бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн дээд түвшинд эрүүл байх;
- Аливаа хувь хүн нөхөн үржихүйн эрүүл мэндийн хамгийн чанартай, өндөр стандартын тусламж үйлчилгээг авах;
- Ялгаварлан гадуурхалт, албадлага, хүчирхийллээс чөлөөтэйгээр нөхөн үржихүйн талаар шийдвэр гаргах эрхтэй байх гэж тодорхойлсон байна.

Энэ тодорхойлолт нь нөхөн үржихүйн эрхийн хүрээн дэх эрх, үүргийн талаарх ойлголтыг хангалттай гаргаж тавиагүй ч 1994 оноос хойш олон улсын хүний эрхийн тогтолцоо хүний нөхөн үржихүйн эрхийн мөн чанарыг эрэлхийлэн баяжуулсаар ирсэн. Ялангуяа, эмэгтэйчүүдийн эрхийн зөрчил, хүүхдийг хүйсийн сонголтоор төрүүлэх дадал зэрэг үр хөндөлтийн нарийн асуудлуудыг хамарсан нөхөн үржихүйн эрхийн "цөм" нь асуулт хэвээр байсаар байна.

Нөхөн үржихүйн эрх нь эрүүл мэндээ хамгаалуулах эрх зэрэг хүний эрхийн бусад салбаруудтай холбогдож байдаг. 2003 онд НҮБ-ын Хүний эрхийн Комиссоос (өнөөгийн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл) "бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд нь бие бялдрын болон сэтгэл санааны хувьд хүрч болох дээд түвшинд эрүүл байх хүн бүрийн эрхийн салшгүй хэсэг юм" хэмээн тэмдэглэсэн байдаг.

Нөхөн үржихүйн эрхийн салшгүй хэсэг нь бэлгийн амьдралын эрх юм.

Бэлгийн амьдралын эрх нь:

1. Бүх хүн өөрийн бэлгийн амьдралын талаар чөлөөтэй бөгөөд хариуцлагатайгаар шийдвэрээ гаргах эрхтэй. Үүнд бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах сонирхол хэрэгцээ нь бүрэн хамаарна.
2. Бэлгийн амьдрал, түүнтэй холбогдож гаргасан шийдвэр нь аливаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал, доромжлолоос ангид байх эрхтэй.
3. Бэлгийн харилцаа нь хамтын хариуцлагатай, бүх талын хүндэтгэлтэй, харилцан бие биетэйгээ зөвшилцсон, тэгш эрхтэй байна гэж "Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"-төө тусгасан байдаг.

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх нь агуулгын хувьд дараах зүйлсийг багтаадаг:

- Нөхөн үржихүйн шийдвэр гаргах эрх. Энэ нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр гэр бүл болох, гэр бүлээ төлөвлөх болон төрүүлэх хүүхдийн тоо, төрөлт хоорондын хугацаа, хүүхэд төрүүлэх газраа сонгох, энэ шийдвэрээ гаргахад хэрэгтэй мэдээллийг авч сайн дураар сонголтоо хийх асуудал;

- Гэр бүл төлөвлөлтийг багтаасан нөхөн үржихүйн тусламж үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгох;
- Өсвөр насны охид, хөвгүүдэд зориулсан зохих нөхөн үржихүйн боловсрол, мэдээлэл, үйлчилгээг түгээх, хүртээх;
- Өсвөр насныхны гэрлэлт, хүүхдийг хүйсийн сонголтоор төрүүлэх гэх мэт аюултай дадлаас ангид байх;
- Нөхөн үржихүйн уламжлалт зөв дадлыг хүндэтгэх, хүртээх. Жишээлбэл, эх барих эмэгтэй эмчийг сонгон үйлчлүүлэх, төрөх газрыг чөлөөтэй сонгох;
- Бэлгийн хүчирхийллээс ангид байх;
- Албадан үргүй болгох, албадан үр хөндүүлэх, хүчээр жирэмслэлтийг таслан зогсоох зэргээс ангид байх;
- Ялгаварлан гадуурхалтаас ангид байх; Энэ нь нас, хүйс, гэр бүлийн байдал, жирэмсэн эсэх, бэлгийн чиг баримжаа, угсаа гарал, хэл, шашин, соёл, бие бялдрын болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээл, ХДХВ-ын халдвартай эсэхээс үл хамааран нөхөн үржихүйн бусад эрхийг эдлэх явдал юм.
- Төрөөс төрсний өмнөх болон дараах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг багтаасан эхийн өвчлөл, эндэгдлийг бууруулах, эхийн эрүүл мэндийг дэмжих үйлчилгээг хуульчлан нийтэд хүртээх;
- Хувь хүний нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээллийг нууцлан хамгаалах;

Нөхөн үржихүйн эрх нь нийгмийн амьдралд оролцох болон хөдөлмөрлөх эрхүүдтэй харилцан холбогддог. Нөхөн үржихүйн эрх нь олон улсын хүний эрхийн баримт бичигт хүлээн зөвшөөрсөн тодорхой эрхүүдийг хамарч тэдгээр эрхүүдийг хуулиар баталгаажуулсан байдаг ч эдлэх нөхцөл бололцоо, боломжийг төрөөс бүрдүүлэх ёстой.

Дэлхийн хэмжээнд хөгжиж буй улс орнуудын охид эмэгтэйчүүд бэлгийн болон нөхөн үржихүйтэй холбогдох өвчнөөр өвчлөх, дахин хүүхэд төрүүлэх боломжгүй болох улмаар амь насаа алдах эрсдэл өнөөг хүртэл байсаар байна.

Гэр бүлээ төлөвлөх боломж хүн бүрт харилцан адилгүй байдаг ч нөхөн үржихүйн эрх ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал нь хүн бүрийн хувьд тэдгээрийн хөгжил, аюулгүй байдалд нь нэн чухлаар тавигддаг.

Дэлхий дээр өдөр бүр 800 эх төрөхийн дараах цус алдалт, цусны даралт ихсэх эмгэг, халдвар, эрсдэлтэй үр хөндөлт зэрэг төрөлтийн хүндрэлтэй холбоотой шалтгаанаар эндсээр байна³¹.

2000 онд НҮБ-аас батлагдсан Мянганы Хөгжлийн Тунхаглал, 2001 онд батлагдсан Мянганы Хөгжлийн найман Зорилтод Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурлаас баталсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн бүх нийтийн үйлчилгээг хүртэх зорилгыг оруулаагүй байжээ. Харин 2007 онд батлагдаж 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон Мянганы Хөгжлийн Зорилтод "нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэх" гэсэн зорилтыг 4 шалгуураар оруулсан байна.

Мянганы Хөгжлийн зорилт (МХЗ) 5: Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах

Зорилт 5а: Эхийн эндэгдлийг 75 хувиар бууруулах

Шалгуур үзүүлэлт:

5.1 Эхийн эндэгдлийн түвшин;

5.2 Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь.

³¹ Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мэдээлэл, 2010 оны байдлаар.

Зорилт 5б: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй хүргэх

Шалгуур үзүүлэлт:

- 5.3 Жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн хэрэглээ;
- 5.4 Өсвөр насныхны төрөлтийн түвшин;
- 5.5 Жирэмсний хяналтанд хамрагдсан хувь;
- 5.6 Гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээ.

МХЗ-ын зорилт 3 (жендэрийн тэгш байдлыг дамжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх); зорилт 4 (хүүхдийн эндэгдлийг бууруулах); зорилт 5 (эхчүүдийн эрүүл мэндийн сайжруулах) зорилтуудыг амжилттай хангахад нөхөн үржихүйн эрх чухлаар тавигдана гэдэг нь илэрхий юм. Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах болон нөхөн үржихүйн эрх нь салшгүй харилцан хамааралтай юм. Дээр харуулснаар эхийн эндэгдлийг бууруулж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүргэснээр л зорилтыг хангах боломжтой гэж олон улсын нийгэмлэгүүд үздэг байна.



СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХ

"Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ"

(Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх заалт)

Иргэн та төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй

Төр засгийн эрх мэдэл нь ард түмний хүсэл зориг байна. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илэрлээ олно. Хүн бүр нийгмийн гишүүн, ард түмний нэг хэсэг болохын хувьд төр, нийгмийн амьдралд оролцож, улс орны хөгжилд өөрийн биеэр шууд, эсвэл чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан хувь нэмрээ оруулдаг. Иймээс иргэн бүр биечлэн шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан төрийн хэргийг явуулахад оролцох эрхтэй.

Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч, нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгчийг сонгох, ард нийтийн санал асуулгад оролцох, хууль, төрийн чухал шийдвэр гаргахад саналаа өгөх, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны талаар санал гомдол гаргах, төрийн алба хаших, шүүн таслах ажиллагааг явуулахад оролцох зэрэг нь төрийг удирдахад шууд оролцож байгаа хэлбэр юм.

Харин тодорхой байгууллага, албан тушаалтан тухайлбал Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгох замаар өөрийн эрхээ шилжүүлж, төрийн удирдлагыг хэрэгжүүлэх нь төрийг удирдахад оролцох төлөөллийн хэлбэр болно.

Сонгуулийг бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрхтэй.

Иймээс иргэдээс төрийн сонгуульд байгууллага ба нутгийн өөрөө удирдах байгууллагыг бүрдүүлэх, мөн ард нийтийн санал асуулгад оролцохыг сонгох эрх, төрийн сонгуульд байгууллага ба нутгийн өөрийн удирдлагын байгууллага, түүнчлэн төрийн сонгуульд ба нутгийн өөрийн удирдлагын албан тушаалд нэр дэвшин сонгогдохыг сонгогдох эрх гэж ойлгоно.

Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно. Сонгох, сонгогдох эрх нь иргэний улс төрийн эрхийн бүлэгт хамаардаг.

Бидний сонголт нь:

- Эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх боломж;
- Ирээдүйдээ итгэлтэй байх нэг алхам;
- Улсаа удирдахад оролцож, эрхээ хамгаалах арга зам юм.

Хариуцлагатай сонголтоор эрхээ баталгаажуулья.

Сонгууль нь төрийн сонгуульд байгууллага ба орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бүрдүүлэх гол арга

хэрэгсэл юм. Сонгууль нь бүх нийтийн тэгш оролцоог хангасан, сонгогчид хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлсэн, нууц санал хураалтын үндсэн дээр явагдана. Иргэд сонгох, сонгогдох эрхээ эдлэх нь төрийг удирдах хэрэгт оролцож байгаагийн нэг илрэл юм.

Сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө, чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй.

Сонгогчийн эрхийн баталгаа

- Сонгуулийн эрх бүхий тухайн улсын иргэнийг сонгогч гэнэ. Хуулиар эрх нь хязгаарлагдсанаас бусад Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэд сонгуульд оролцоно.
- Сонгогч шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр сонгуульд ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө гаргана.
- Монгол Улсаас гадаад улсад суугаа элчин сайдын яам, олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа, улсын бүртгэлд бүртгэгдсэн сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож санал өгөх эрхтэй.
- Харин эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих газар ял эдэлж байгаа иргэд сонгуульд оролцох эрх эдлэхгүй. Гэхдээ эрх чөлөөг нь хязгаарласан боловч хорих газар ял эдэлж байгаагаас бусад этгээдийн сонгох эрхийг хасах ёсгүй.
- Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө гаргана. Харин бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх

чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болно.

- Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд нь хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.
- Сонгогч хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах боломжоор хангагдсан байна.

Сонгогчдын нэрийн жагсаалт

Сонгогчдын нэрийн жагсаалт нь сонгогчдын сонгуульд оролцох эрхийн баталгаажуулалт юм.

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчийн бүртгэлд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх зэрэг ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах үүргийг хуулиар хүлээсэн байдаг.

Иргэдийн засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг сонгууль товлон зарласан өдрөөс эхлэн санал хураалт дуустал улсын хэмжээгээр түр зогсооно.

Сонгогчийг зөвхөн сонгуулийн нэг хэсэгт сонгогчдын нэг нэрийн жагсаалтад бүртгэнэ. Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ шалгах эрхтэй.

Сонгогч өөрөө болон гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу

бүртгэгдсэн байвал гомдлоо улсын бүртгэлийн байгууллагад санал авах өдрөөс арваас доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.

Улсын бүртгэлийн байгууллага иргэний бүртгэлийн мэдээллийн улсын санг үндэслэн гомдол гаргасан иргэний мэдээллийн талаар лавлагаа гаргана.

Хэсгийн хорооны дэргэд ажиллах иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан уг лавлагааг үндэслэн тухайн сонгогчийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлтийг гурав хоногийн дотор сонгогчдын нэрийн жагсаалтад оруулна.

Саналын хуудас

Саналын хуудас нь сонгогчоос саналаа илэрхийлэх, сонгуулийн дүнг гаргах үндсэн баримт бичиг бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.

- Агуулга, бичилт, хэлбэрийн хувьд сонгогчдод саналаа илэрхийлэхэд хялбар, ойлгомжтой байх;
- Сонгогч саналаа хэрхэн тэмдэглэх тухай товч заавар агуулсан байх;
- Тусгай нууцлалтай, нэгдсэн таних нууц тэмдэгтэй байх;
- Нэр дэвшигч, нам эвслийн мэдээллийг агуулсан байх;

Санал авах байр

Санал авах байрны дотоод зохион байгуулалтыг сонгогчдод ойлгомжтой, хялбар байхаар, санал авах үйл явц ажиглагчдад бүхэлдээ харагдахуйц байхаар Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу зохион байгуулна.

Мөн санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байхын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тусгайлан тоногдсон нэгээс доошгүй тооны санал тэмдэглэх бүхээгтэй байна.

Тус санал тэмдэглэх бүхээгт сонгогч санал тэмдэглэх заавар, зориулалтын үзэг, тавиур (ширээ), харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий нэг ширхэг хавтас, томруулдаг шилтэй байна.

Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна.

Сонгогчийн санал өгөх үе шат

Сонгогч өөрийн байнга оршин суугаа газрынхаа харьяа сонгуулийн хэсгийн санал авах байранд өөрийн биеэр ирж, саналаа биечлэн өгнө.

Сонгогч санал өгөхдөө улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд иргэний үнэмлэх, биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-өө шалгуулна.

Тухайн ажилтан сонгогчийн иргэний үнэмлэх, биеийн давхцахгүй өгөгдлийг иргэний бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчийн бүртгэлтэй тулган үзэж, зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.

Сонгогчийн бүртгэлийн хуудас авсан сонгогч уг бүртгэлийн хуудсыг иргэний үнэмлэхийн хамт хэсгийн хорооны гишүүнд үзүүлэн саналын хуудас авна.

Хэсгийн хорооны гишүүн сонгогчид саналын хуудас олгохдоо иргэний үнэмлэх, сонгогчийн бүртгэлийн хуудсыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган шалгана.

Сонгогч саналын хуудас авч, сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зурна.

Сонгогч санал тэмдэглэх бүхээгт орж, саналын хуудасны зааварт заасан тэмдэглэгээний дагуу нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг сонгож, тэмдэглэгээ хийнэ.

Сонгогч саналаа тэмдэглэсний дараа саналын хуудсыг санал тоолох төхөөрөмж (саналын хайрцаг)-д хийж, санал авах байраас гарна.

Сонгогч санал тэмдэглэхдээ алдаа гаргаж буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмжид хийхээс өмнө эсхүл санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг таньж уншаагүй тохиолдолд сонгогч энэ тухайгаа хэсгийн хороонд мэдэгдэж, уг саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч саналаа өгч болно.

Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа, улсын бүртгэлд бүртгэгдсэн сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцохоо мэдэгдэж бүртгүүлэн өөрийн биеэр ирж оролцоно.

Гадаад улсад байгаа сонгогч саналаа өгөхдөө саналын хуудсыг дугтуйн хамт авч, санал тэмдэглэх бүхээгт орж, саналын хуудасны зааварт заасны дагуу саналын хуудсанд бичигдсэн нэр дэвшигч, нам эвслийн дотроос өөрийн сонгохыг хүссэн нэр дэвшигч, нам эвслийн нэрийн өмнөх дугаарыг сонгож, тэмдэглэгээ хийнэ. Ингээд саналын хуудсаа дугтуйд

хийн битүүмжлэн саналын хайрцагт хийнэ. Сонгогч саналын хуудсанд саналаа тэмдэглэхдээ алдаа гаргаж, саналын хуудсанд зааснаас өөр, буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа саналын хайрцагт хийхээс өмнө энэ тухайгаа салбар комисст мэдэгдэж, алдаатай саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч, саналаа гаргаж болно.

Сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал өгөхөд дараах сонгогчийн саналыг түүний хүсэлт, эмнэлгийн магадлагаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал авах өдрийн өмнөх өдөр авдаг.

- Биеийн эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр хүрэлцэн ирж чадахгүй;
- Нийтийн дайчилгаанд хамрагдан ажиллаж байгаа;
- Захиргааны зөрчлийн улмаас баривчлагдсан, албадан саатуулагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан;
- Байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, цагдан хоригдсон;
- Хил хамгаалалтыг удирдах төрийн захиргааны байгууллага санал авах өдөр өөрийн харьяа тусгай анги, салбарт алба хааж байгаа боловч тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух бүртгэлгүй сонгогчид;
- Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санал авах өдөр зэвсэгт хүчний цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа боловч тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух бүртгэлгүй сонгогчид;

Анхаарах зүйлс

Бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болно.

Сонгогч саналаа өгөхдөө алдаа гаргаж саналын хуудсанд буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсыг зөөврийн битүүмжилсэн хайрцагт хийхээс өмнө хэсгийн хорооны гишүүнд мэдэгдэж хураалган, дахин нэг саналын хуудас авч болно.

Хориглох зүйлс

- Тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх, эсхүл өөр хүний бичиг баримт, эсхүл хуурамч бичиг баримт ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох, хуурч мэхлэх;
- Тухайн хэсгийн хорооноос олгосноос өөр саналын хуудсыг санал өгөхөд ашиглах, эсхүл санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, санал авах байрнаас саналын хуудас авч гарах;
- Саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа баталгаажуулан зураг авах, дүрс бичлэг хийх зэрэг үйлдэл хийх;
- Саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээгээ бусдад харуулах;
- Аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авах.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ БОЛОН БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ ЭРХ



"Нийтийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно."

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 10 дахь хэсэг)

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, байгууллага байгуулах эрх гэдэг нь иргэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр өөрийн итгэл үнэмшил, эрх ашгийн төлөө эвлэлдэн нэгдэж, төрөөс хараат бусаар өөрийгөө удирдах зарчмаар үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн бус олон нийтийн байгууллагад элсэн орохыг хэлнэ.

Энэхүү эрхийн гол зорилго нь иргэдэд тулгамдсан асуудлыг хамтын хүчээр шийдвэрлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэнэ. Хүмүүсийн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх явцад байгуулагдаж буй байгууллага нь ямар ч нэртэй байж болох бөгөөд зөвхөн сайн дурын үндсэн дээр, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх боломжтой байна. Хэнийг ч албадан элсэхийг тулган шаардаж болохгүй.

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, байгууллага байгуулах эрх нь иргэдийн сайн дурын үндсэн дээр өөрийн итгэл үнэмшил, эрх ашиг, үзэл бодлын нийтлэг сонирхолд нийцсэн байх

бөгөөд нам, эвсэл, холбоо, эвсэл, зөвлөл, нийгэмлэг гэх мэт янз бүрийн нэртэй нэгдэл, байгууллагыг үүсгэн байгуулах, элсэн орох хэлбэрээр илэрдэг. Төрийн байгууллага энэхүү эрхийг хязгаарлах буюу түүнийг хууль ёсоор хэрэгжүүлэхэд саад тавихаас түтгэлзэнэ.

Ажилчид ба ажил олгогчид өөрсдийн сонголтоор байгууллага байгуулах, эсхүл түүнд нэгдэн орох эрхтэй. Энэ нь ажилчид, ажил олгогчдын ямар ч ялгаагүйгээр, урьдчилан зөвшөөрөл авалгүй өөрийн саналаар байгууллага байгуулж, тэдгээр байгууллагад гагцхүү дүрэмд нь захирагдах нөхцөлтэйгээр элсэн орохыг хэлнэ.

Байгууллага гэдэг нь ажилчид, ажил олгогчдын ашиг сонирхлыг хангах, хамгаалах зорилго бүхий ажилчид буюу ажил олгогчдын аль ч байгууллагыг хамруулсан ойлголт байна.

Хүний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг хангах, ажил олгогч, ажилчдын үйл ажиллагааг ардчилал, хууль ёсны зарчмаар явуулах, хөдөлмөрийн харилцаанд оролцогч хоёр тал эрх, үүргээ хамтын зарчмаар хэрэгжүүлэх, ажил олгогч болон ажилтан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо өөрсдийн төлөөлөгчөөрөө дамжуулж хамгаалуулахад ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд чухал үүрэгтэй.

Эдгээр байгууллагууд нь үйл ажиллагаандаа ил тод байх, хараат бус байх, харилцан адил тэгш байх зарчмыг мөрдлөг болгоно. Ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн байгууллагыг захиргааны журмаар тараах буюу үйл ажиллагааг нь түр ч гэсэн хориглож үл болно.

Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах, хамтын гэрээ, хэлэлцээр хийх эрх чөлөөг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гэрээ, конвенцоор баталгаажуулсан байдаг.

Үүнд:

- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 1948 оны 87 дугаар конвенц;
- Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай 1949 оны 98 дугаар конвенц;
- Үйлдвэрийн газарт ажилчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгогдох бололцооны тухай 1971 оны 135 дугаар конвенц;
- Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцааны тухай 1978 оны 151 дүгээр конвенц;
- Хамтын хэлэлцээний тухай 1981 оны 163 дугаар конвенц.

Мөн дээрх гэрээ, конвенцийн заалттай холбоотой дараах зөвлөмжийг гаргасан байна. Үүнд:

- Хамтын хэлэлцээрийн тухай 1951 оны 91 дүгээр зөвлөмж;
- Үйлдвэрийн газарт ажилчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгогдох бололцооны тухай 1971 оны 143 дугаар зөвлөмж;
- Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцааны тухай 1978 оны 159 дүгээр зөвлөмж;
- Хамтын хэлэлцээний тухай 1981 оны 163 дугаар зөвлөмж зэрэг болно.

Түүнчлэн, эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах, хамтын гэрээ, хэлэлцээр хийх эрх чөлөөг 1919 оны Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрэм, 1944 оны Филадельфийн тунхаглал, 1998 оны Хөдөлмөрлөх эрх, үндсэн зарчмуудын тухай тунхаглал зэрэг баримт бичигт тусгасан байдаг.

Манай улсад ажилтан үйлдвэрчний эвлэл байгуулах, ажил олгогчид төрийн бус байгууллага байгуулах замаар эвлэлдэн нэгдэж, эрх ашгаа хамгаалах үйл ажиллагаа явуулах эрх

зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хууль болон Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай, Төрийн бус байгууллагын тухай, Хөдөлмөрийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, болон Иргэний хуулиар зохицуулж байна.

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй" гэж заасан.

Үйлдвэрчний эвлэл нь ажилчдын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлыг хамтын ажиллагаагаар дамжуулан хамгаалах, дээшлүүлэх зорилгоор байгуулагддаг.

Үйлдвэрчний эвлэл нь иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах, хамтын гэрээ хэлэлцээрийн зарчмаар хөдөлмөрийн нөхцөл болон амьдралын түвшинээ дээшлүүлэх, нийгэм болон бусад асуудлаар үзэл бодлоо илэрхийлэхийн тулд өөрсдийнхөө санаачилгаар байгуулсан байнгын, ардчилсан байгууллага юм.

Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь:

- Ажлын байран дээр ажиллаж байгаа ажилчдаа хамгаалах;
- Ажилтан, ажилчдын ажлын нөхцөлийг сайжруулах;
- Аливаа асуудлыг хамтаараа хэлэлцэн тохиролцох замаар шийдвэрлэх;
- Амьдралын нь нөхцөл байдлыг дээшлүүлэх арга зам эрж хайх, тусламж дэмжлэг үзүүлэх;
- Нийгмийн аливаа асуудлаар санал бодлоо чөлөөтэй

илэрхийлэх нөхцөл бололцоо бүрдүүлж өгөх зэрэг болно.

Бүхий л улс оронд Үйлдвэрчний эвлэл нь хуулийн этгээдийн эрхтэй байх бөгөөд улмаар Хөдөлмөрийн буюу Ажил эрхлэлтийн Яаманд (Монгол Улсын хувьд Хууль зүйн Яам) албан ёсоор бүртгүүлэх ёстой. Хамт олны нэрийн өмнөөс аливаа асуудлыг шийдвэрлэдэг байгууллага учраас хамт олны хэлэлцүүлэг, ажилчдын сонгууль зэрэгт оролцон манлайлж, ажилчдын итгэл найдварыг нь хүлээсэн төлөөлөгчид энэ байгууллагыг бүрдүүлдэг.

Үйлдвэрчний эвлэл нь ажилчдыг идэвхтэй зохион байгуулж, тэдний ашиг сонирхлыг хамтын хэлэлцээгээр дамжуулан хамгаалах тогтолцоо болохын хувьд түүний төлөөлөл, гишүүд нь удирдлагатай харьцах харилцаагаараа дамжуулан адил тэгш цалин хөлс, тэгш боломж олгох зэрэг олон асуудлаар ажил олгогчидтой хэлэлцэн тохирч, ажиллагчдын эрхийг хамгаалдаг. Иймд үйлдвэрчний эвлэл нь Засгийн газар болон ажил олгогчдын байгууллагуудын хамт нийгмийн яриа хэлэлцээнд оролцох гурван талт бүтцийн нэг болдог.

Дэлхийн өнцөг булан бүрт ажилчдын эрх ашгийг хамгаалах шаардлагаар үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөнүүд идэвхтэй ажиллаж, шийдвэр гаргагчид болон ажил олгогчдод хүчтэй нөлөөг үзүүлж, бодлогыг өөрчлөхийг зорьдог.

Ялангуяа ажилчдын эрхийг дэмжих, хамгаалахын тулд үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд нэгдэн нийлэх нь илүү үр дүнтэй ажиллах үндэс суурь болдог. Тиймээс хөдөлмөрлөх эрх ашигтай холбоотой гарах зөрчил дутагдлыг арилгахын тулд Үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд салбар, байгууллагууд хоорондоо төдийгүй улс орны мөн олон улсын хэмжээнд эвлэлдэн нэгдэж, хамтын үйл ажиллагаа явуулдаг. Ажилчид холбоо байгуулахтай холбоотойгоор ялгаварлан гадуурхлаас хамгаалагдсан байх ёстой. Мөн ажиллагчдын болон ажил

олгогчдын байгууллагууд нь хэн нэгнийгээ давамгайлах, санхүүжүүлэх болон хянах зорилгоор бие биеийнхээ хэрэгт харилцан оролцох үйлдлээс хамгаалагдсан байна.

Үйлдвэрчний эвлэл нь сайн дураараа чөлөөтэй эвлэлдэн нэгдэж үйл ажиллагаа явуулах тул түүнээс гарах, татгалзах нь мөн сайн дурын байна. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлд заасанчлан иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй. Мөн үйлдвэрчний эвлэлд гишүүнээр элсэх буюу гишүүнээс гарахыг тулган шаардаж болохгүй.



ХҮН БҮР ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС АНГИД БАЙХ ЭРХТЭЙ

"Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэхийг хориглоно."

/Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйл/

"Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар ,нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй."

/Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйл/

"...Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ..."

/Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэг/

ЭРҮҮ ШҮҮЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцид зааснаар "эрүүдэн шүүх" гэж "Хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гуравдахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ.

ЭРҮҮ ШҮҮЛТИЙГ ХЭН ҮЙЛДЭЖ БОЛЗОШГҮЙ ВЭ?

Бусдыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх үйлдлийг:

- Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчид / цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөний газрын ажилтан алба хаагч нар гэх мэт/;
- Цэргийн албан хаагч, албан тушаалтнууд;
- Төр захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчид / төрөлжсөн асрамжийн газар, сэтгэцийн эрүүл мэндийн газар, албадан эмчилгээний төв, хүүхдийн хаяг тогтоох газар, хувийн хэвшлийн халамжийн байгууллага гэх мэт/;
- Эмнэлгийн ажилтнууд (байцаалтанд ороход тухайн хүний эрүүл мэндийн байдал тохирох эсэхийг тодорхойлоход шууд оролцдог болон эмнэлгийн шинжилгээг буруу мэдээлэх эсхүл шаардлагатай эмчилгээ үзүүлэхгүй байх арга замаар);
- Төрийн алба хаагчийн захиалгаар, хатгалгаар хамт хоригдогсад нь.

Эрүү шүүлтийн хохирогч нь хэн байж болох вэ?

Эрүү шүүлтийн хохирогч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хорих ял эдэлж буй ялтан, гэрч, зарим тохиолдолд гэмт хэргийн хохирогч байхыг үгүйсгэхгүй. Эрүү шүүлтийн зорилго нь аливаа гэмт хэргийн талаар тухайн этгээдээс мэдээлэл, мэдүүлгийг хүчээр авах буюу хэрэг тулган хүлээлгэх, улмаар тухайн гэмт хэрэгт шийтгэхэд чиглэгддэг.

Олон улсын практикт эрх чөлөөгөө хязгаарлуулсан, хуулиар болон тодорхой нөхцлийн улмаас бусдын эрхшээлд байгаа хүмүүс амьдарч буй байр, орчны эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын муу нөхцөл, биеийн тамир, дасгал хөдөлгөөн

хийх боломж хязгаарлагдсан байдал, хууль тогтоомж, дэг журмыг сахиулахдаа шаардлагагүй буюу хүч хэтрүүлэн хэрэглэх зэргийг зүй бус харьцаанд хамааруулдаг.

Мөн цэргийн анги нэгтгэл, төрөлжсөн асрамжийн газар, сэтгэцийн эрүүл мэндийн газар, албадан эмчилгээний төв, хүүхдийн хаяг тогтоох газар, хувийн хэвшлийн халамжийн байгууллагад гэх мэт газруудад байгаа эрх чөлөөгөө хязгаарлуулсан, хуулиар болон тодорхой нөхцлийн улмаас бусдын эрхшээлд байгаа хүмүүстэй хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцсан бүх үйлдлийг эрүү шүүлтийн нэг хэлбэр хэмээн авч үздэг.

Олон улсын хэмжээнд эрүү шүүлтийг бие махбодын эрүү шүүлт, сэтгэл санааны эрүү шүүлт, эмнэлгийн чанартай эрүү шүүлт гэж 3 ангилдаг. Эрүү шүүлтэд өртсөн хохирогчдын бие махбодийг хүчтэй шаналган зовоох гэдэгт бие эрхтэнд нь халдаж зодох, гэмтээх, тамлах зэргээр тарчлаах, гэмтэл учруулах, амь насыг нь хохироох, бие эрхтэнд нь өвдөлт, зовлон шаналгаа үүсгэх, хүч хэрэглэх зэргийг ойлгоно.

Сэтгэл санааны дарамтанд оруулах үйлдэлд биеийн хүчирхийллээр бус үг хэллэг, тодорхой үйлдлээр заналхийлэх, айлган сүрдүүлэх, доромжлох, сэтгэл санааг нь хүчтэй цочроон давчдуулах, мөн хувь хүний нэр төр, алдар хүндэд бүдүүлгээр халдах зэрэг үйлдлүүд орно.

Эмнэлгийн эрүү шүүлт гэдэг нь сэтгэцэд нөлөөлөх эм тариа болон эсвэл химийн бодис ашиглан шаналгах, өөрөөс нь зөвшөөрөл авалгүйгээр шинжлэх ухааны болон эмнэлгийн туршилтанд оруулах гэх мэт үйлдлүүд орно. Хохирогч нь эдгээрээс болж бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэндээрээ хохирдог.

Эрүү шүүлтээс хамгаалах арга хэрэгслүүд

Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцид нэгдэн орсон улс орнууд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бүхий л арга хэмжээг авахыг тухайн улсын Засгийн газарт үүрэг болгосон байдаг. Эдгээр арга хэмжээнүүдэд:

- Хууль бусаар хорихгүй байх;
- Өмгөөлөгч авах эрхээр хангах;
- Өөрийн хүссэн эмчээр эрүүл мэндийн үзлэг хийлгэх эрх;
- Хоригдсон тухай нь ар гэрийнхэнд нь нэн даруй мэдэгдэх;
- Гадаад орчинтой холбогдох боломж олгох, төрөл төрөгсөдтэйгээ уулзах, эргэлт уулзалт авах эрхээр хангах;
- Баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийг хүлээн авах, шилжүүлэх, тээвэрлэх үйл ажиллагааг хяналттай болгох;
- Төрийн тусгай албан хаагчдыг тусгай хөтөлбөрт сургалтанд хамруулах ;
- Эрүүшүүлт базүй бус харьцаанаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээ авах төрийн үүргийг заавал хуульчлах;
- Хэн нэгэн эрүү шүүлтэд өртсөн тохиолдол бүрийг мөрдөн шалгах, баримтжуулах, гэм буруутай этгээдэд ял оногдуулах;
- Мөн хохирогчийн эрхийг сэргээх, учирсан хохирлыг нөхөн төлөх, гэрчийг хамгаалах.

Хууль бусаар хорихгүй байх: Эрүү шүүлтэд өртөхгүй байх гол баталгаа бол хууль бусаар хорихгүй байх өөрөөр хэлбэл шүүгчийн хүчин төгөлдөр захирамжгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй газар, ямарваа нэгэн хөндлөнгийн (прокурор, шүүхийн) хяналтгүйгээр хорих явдлыг гаргахгүй байх явдал мөн. Хуулиар зөвшөөрөөгүй аливаа газарт хорихыг хууль бус газар гэж үзэх бөгөөд ийм газар хоригдох нь аливаа хяналтын гадуур байдаг тул ямагт эрүү шүүлт тулгах, хэрэг хүлээлгэх, албадан мэдүүлэг авах, хууль бус арга хэрэглэхэд тохиромжтой нөхцөл байдал болдог.

Өмгөөлөгч авах эрх: Эрүүгийн аливаа хэрэгт сэжиглэгдсэн, баривчлагдсан хэн боловч өмгөөлөгч авах, эрх зүйн туслалцаа хүртэх эрхтэй байдаг. Энэ эрхийг нь хэдий чинээ сайн хангана тэр чинээгээр аливаа хууль бус үйл ажиллагаа, эрүү шүүлтээс ангид байж урьдчилан сэргийлж болно гэж үздэг. Тухайлбал, сэжигтэн, яллагдагч, өмгөөлөгч авах, зөвхөн өмгөөлөгчтэй байцаалт өгөх, ганцаарчлан уулзах уулзалт хүссэн нөхцөлд түүний хүсэлтийг заавал хангах ёстой.

ЭРҮҮ ШҮҮЛТЭНД ӨРТСӨН ХҮН ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ АВАХ ЭРХТЭЙ

Өөрийн хүссэн эмчээр эрүүл мэндийн үзлэг хийлгэх боломжоор хангах нь эрүү шүүлтээс сэргийлэх, эрүү шүүлт явагдсан тохиолдолд түүний ул мөрийг бэхжүүлэх гол нөхцөл болдог. Энэ нь хөндлөнгийн нотлох баримт болдог ба хоригдсон этгээд аливаа хууль бус үйлдлийн улмаас бие эрхтэндээ авсан гэмтэл, шарх сорви, ул мөрийг шударгаар тогтоох боломжийг бүрдүүлсэн заалт мөн. Гэвч ийм хүсэлт гаргах тохиолдол ховорхон байдаг ба үзлэгийг ихэвчлэн хорих байрны эмнэлгийн ажилтнууд хийдэг. Хоригдогсдод энэ эрхийг тайлбарлах, тийм хүсэлт гаргасныг нь цаг тухайд нь бүртгэх, биелүүлэх зэрэг асуудлыг нарийн зохицуулж хяналт тавих нь чухал юм.

Хоригдогсод өөрийн хүссэн эмчээр буюу төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн эмчээр үзлэг хийлгэх хүсэлт гаргах эрх нь хорих газрын эмч нарыг үгүйсгэж буй хэрэг огт биш юм. Харин хоригдогсдын эрхийг бодитойгоор бүрэн дүүрэн хангаж буй хэрэг юм.

Эмч нь үзлэг хийх явцад тухайн этгээдэд бие махбодид нь хүчирхийлэл үйлдсэн шинж, ул мөр илэрсэн тохиолдолд хойшлуулшгүй шуурхай арга хэмжээ авах, холбогдох албан

тушаалтанд мэдээлэх, шалгуулах, баримтжуулах талаар хууль зүйн мэдлэг чадварыг эзэмшсэн байх ёстой.

Эмчийн үзлэг нь эрүү шүүлтээс үүссэн ул мөрийг баримтжуулах, үйл ажиллагааг мөрдөн шалгах, гэм буруутанд хариуцлага хүлээлгэхэд шүүхийн шатанд чухал нотлох баримтын үүрэг гүйцэтгэдэг.

Хоригдогсдын гадаад орчинтой холбогдох, гэр бүлийн гишүүд, төрөл төрөгсдөөсөө эргэлт, уулзалт авах эрх нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бас нэг хамгаалалт болдог. Өөрөөр хэлбэл түүний гэр бүлийн гишүүн, төрөл төрөгсөд нь тухайн хүнтэй уулзах боломжтой байх нь түүнийг мөрдөн шалгаж буй үйл ажиллагаа нь хууль ёсны дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих боломжийг бүрдүүлдэг.

ЭРГЭЛТ УУЛЗАЛТ АВАХ, ӨМГӨӨЛӨГЧТЭЙ БАЙХ НЬ ЭРҮҮ ШҮҮЛТЭД ӨРТӨХГҮЙ БАЙХ БАТАЛГАА МӨН

Эрүү шүүлт тулгах болон зүй бус харьцаа үүсгэхэд тухайн албан тушаалтан өөрийнхөө үйлдлийг аль болох нуух, бусдад мэдэгдэхээс болгоомжлох, түүнийг төрөл төрөгсөдтэй нь уулзуулахгүй байхыг эрмэлзэнэ. Ялангуяа эрүү шүүлтийн ул мөр арилтал хэнтэй ч харьцуулахгүй байхыг хичээдэг.

Тиймээс хоригдогч нь эргэлт уулзалт авах, өмгөөлөгчтэй байх нь түүнд үүссэн нөхцөл байдлыг ар гэр болон өмгөөлөгч нь мэдэх, эрх бүхий байгууллагад хандах, шалгуулах боломжийг олгох хөндлөнгийн хяналт болдог. Хоригдогсдыг хүлээн авах, шилжүүлэх, байцаалт болон шүүхэд хүргэх, тээвэрлэх үед хийгдэх үйл ажиллагаа нь эрүү шүүлтээс сэргийлэх бас нэг нөхцөл болдог байна. Ялангуяа баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийг анх хүлээн авахдаа эрүүл мэндийн үзлэгт сайтар хамруулах, биед нь үүссэн гэмтэл согог, шарх, сорвийг нэг бүрчлэн баталгаажуулан баримтжуулах, байцаалт болон шүүхэд очсоны дараа нь эмчийн үзлэгт оруулах, тэмдэглэл хөтлөх нь чухал ач холбогдолтой.

Харин байцаалт болон шүүхэд очихоор хорих байрнаас гарах, буцаж ирэх үед бие болон хувцас, эд зүйлд нь заавал үзлэг хийж үзлэгийн протокол хөтлөх ёстой. Энэ нь зөвхөн аюулгүй байдал талаас нь анхаарсан байхаас гадна байцаалтанд очих, буцаж ирэх, байцаалтанд орох үедээ эрүү шүүлтэд өртсөн эсэхийг илрүүлэн гаргахад чухал нөлөөтэй.

- Эрүү шүүлт тулгасан үйлдлийг онц аюултай гэмт хэрэгт тооцох ёстой.
- Эрүү шүүлт тулгах замаар гаргуулсан мэдүүлгийг шүүн таслах ажиллагаанд нотлох баримт болгон ашиглахгүй. Харин түүнийг ийнхүү мэдүүлэг гаргасны нотолгоо болгон эрүү шүүлт тулгасан гэх гэмт хэрэгт яллагдаж байгаа этгээдийн эсрэг ашиглаж болно.
- Эрүү шүүлтэд өртсөн хүн хохирлоо нөхөн төлүүлж, түүний дотор эрүүл мэндээ аль болох бүрэн сэргээхэд шаардлагатай шударга, тохирсон нөхөн төлбөр авах эрхтэй. Эрүү шүүлтэд өртсөний улмаас нас барвал уг төлбөрийг түүний гэр бүл, төрөл төрөгсөд авах эрхтэй.
- Төрийн тусгай албан хаагчдад тусгай хөтөлбөрийн дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар сургалтын ажлыг зохион байгуулах, холбогдох дүрэм, журамд тусгайлан зааж тусгах шаардлагатай байдаг.



ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ

Монгол Улсын нэгдсэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.", Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй." гэж тус тус заасан нь эрүү шүүлтийн улмаас учирсан хохирол, эрүүл мэнд, сэтгэл санааны нөхөн төлбөр авах эрхийг баталгаажуулсан байна.

НҮБ-аас батлан гаргасан "Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмууд"-ын 3.3.-т төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байна. Тухайн хохирлыг хариуцах засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулна хэмээн заажээ.

Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...

Монгол Улсын Үндсэн хууль -ийн Арван зургадугаар зүйлийн 14³²дэх заалт

³² УИХ-аас 1992 онд баталсан.

НҮБ-аас батлан гаргасан "Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмуудын тунхаглал"-ыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 40/34 дугаар тогтоолоор 1985 онд баталсан юм.

Үндсэн зарчмуудын ач холбогдол:

Энэхүү зарчим, стандарт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үед хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгоход ач холбогдолтой. Түүнчлэн шударга ёсны зарчмыг хангах, олон улсын стандартыг хэрэгжүүлэх үндэс болдог.

Гэмт хэргийн хохирогч:

НҮБ-ын гишүүн орнууд хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулийнхаа дагуу буюу эрх мэдлээ урвуулан, хэтрүүлэн ашигласан үйлдлийн улмаас бие махбод, сэтгэл санааны дарамтад орсон, санхүүгийн алдагдал хүлээсэн, эсвэл үндсэн эрх нь ноцтойгоор зөрчигдсөн зэрэг гарз хохирол учирсан хүнийг хэлнэ.

Нөхөн олговор:

Гэмт этгээд буюу түүний өмнөөс хариуцлага хүлээх гуравдагч этгээд нь хохирогч, түүний гэр бүлийн гишүүн, асрамжид байсан хүмүүсийн хохирлыг шударгаар барагдуулна. Нөхөн олговор гэдэгт эд хөрөнгийг эргүүлж өгөх, учруулсан гэмтэл, хохиролд нөхөн төлбөр төлөх, хохирогч болсонтой холбогдсон зардлыг нөхөх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх зэргийг ойлгоно.

Хохирлыг шуурхай, шударгаар барагдуулах ажиллагааг хөхиүлэн дэмжих үүднээс гишүүн улс нь дараах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнд:

- Хохирлын нөхөн төлбөр хийгдсэн байдлыг ял шийтгэлийг хөнгөрүүлэх хүчин зүйл болгох;
- Төлвөл зохих нөхөн төлбөрөөс дээгүүр торгууль тогтоож, тухайн нөхөн төлбөр хийгдсэн тохиолдолд торгуулийг хүчингүй болгох;
- Мөн нөхөн төлбөр хийгдсэн тохиолдолд хүчингүй болгох нөхцөлтэй ял шийтгэл оногдуулах;
- Нөхөн төлбөрийг хийлгүүлэх зорилгоор хариуцлага хүлээх этгээдийн өмч хөрөнгийг хураах, битүүмжлэх;
- Хохирлыг барагдуулах бүтээлч аргуудыг хэрэгжүүлэх; Жишээ нь: гэмт хэрэгтэн, хохирогч харилцан зөвшөөрсөн тохиолдолд хохирлыг эд хөрөнгө засварлах буюу хохирогчид ажил үйлчилгээ үзүүлэх замаар барагдуулж болдог.
- Тухайн нутаг дэвсгэрийн нийгмийн буюу халамжийн хөтөлбөрт хамруулахаар нөхөн төлбөр хийх; Жишээ нь: Нидерландад тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, хулгай хийсэн насанд хүрээгүй хүнээр хулгайд өртсөн дэлгүүрийг цэвэрлүүлэх, эвдэрсэн эд зүйлийг засварлуулах зэргээр хохирол барагдуулдаг байна.
- Нийтийн ахуйн үйлчилгээний салбарт ажил хийлгэх; Энэ нь нөхөн төлбөрийн буюу шийтгэлийн тогтсон хэлбэрт хамаардаг.
- "Торгуулийн ял" нь хохирлын нөхөн төлбөрөөс ялгаатай байдаг. Энэ торгуулийг төрөөс хохирогчид үзүүлэх үйлчилгээ ба олгох нөхөн төлбөрийн сан бүрдүүлэх зорилгоор авдаг юм. Өөрөөр хэлбэл торгох ялын хуримтлалыг зөвхөн хохирогчид олгох нөхөн төлбөр, тэдэнд үзүүлэх үйлчилгээг санхүүжүүлэхэд зарцуулах ёстой.

Нөхөн олговрыг гэм буруутай этгээд төлөх боломжгүй буюу эх үүсвэр тодорхойгүй бол төрөөс наад зах нь а/ хүнд гэмтэл авсан буюу сэтгэцийн эрүүл мэнд алдагдсан, б/ гэмт хэргийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон, нас барсан хохирогчийн гэр бүлийн гишүүн, асрамжид байсан хүнд мөнгөн хэлбэрээр нөхөн олговор олговол зохино.

Тусламж:

Хохирогчид нөхөн олговроос гадна шаардлагатай материаллаг, эмнэлгийн, сэтгэл зүйн, нийгмийн халамжийн тусламжийг төрийн болон орон нутгийн эх үүсвэрээс олгохыг зөвлөсөн байна.

Төрөөс төлбөл зохих хохирол:

Төрийн байгууллага, албан тушаалтны бусдад учруулсан хохирол, гэм хорыг төрөөс хариуцан арилгах үүрэгтэй бөгөөд тэдний албан тушаалтан гэм буруутай эсэхээс үл хамааран тэдний бусдад учруулсан бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэнд, эд материалын хохирлыг төр арилгах учиртай.

Зарим улсын хувьд:

Оросын холбооны улсад: сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг шүүхийн журмаар олгодог байна. Нөхөн төлбөрийг олгохдоо тухайн буруутай үйлдэл үйлдсэн этгээдээс нэхэмжилдэг. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Эрделевскийн хүснэгтийг ашиглаж байна.

ОХУ-ын Иргэний хуулийн 151 дүгээр зүйлд "Хэрвээ тухайн иргэнд эдийн бус хохирол (бие эрхтэний эсвэл сэтгэл санааны шаналал) учруулсан эсвэл хуульд заасан бусад тохиолдолд шүүх гэмт этгээдэд учруулсан эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай шийдвэр гаргаж болно." гэж заасан.

Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо шүүх гэмт этгээдийн гэм буруу болон бусад нөхцөл байдлыг анхаарч авч үзнэ. Түүнчлэн шүүх учруулсан бие эрхтний болон сэтгэл санааны хохирлын хэмжээ болон тухайн хувь хүний онцлогийг харгалзан үзэх ёстой.

Мөн тус хуулийн 152 дугаар зүйлд "Тухайн иргэний эсрэг худал хуурмаг, нэр хүнд, алдар хүндэд халдсан тохиолдолд энэхүү мэдээллийг худал хуурмаг болохыг тогтоолгохын зэрэгцээ энэхүү сэтгэл санааны хохирол барагдуулахыг шаардах эрхтэй.", 1101 дүгээр зүйлд "Эдийн бус хохирлын нөхөн төлбөрийг мөнгөн хэлбэрээр олгоно. Эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг шүүх тогтоох бөгөөд хохирогчид учирсан гэм хорын хэмжээ (бие эрхтэн эсвэл сэтгэл санааны), гэмт үйлдэлийн буруутай байдлыг үндэслэн тогтооно. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо зүй ёсны шаардлага болон шудрага байдалд нийцсэн хэмжээ тогтооно." гэж заасан нь оновчтой зохицуулалт болжээ.

ОХУ-ын одоогийн шүүхийн практикт хууль тогтоомжоор зохицуулагдсан, эсхүл ОХУ-ын дээд шүүхээс удирдамж болгосон сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх хэмжээг тогтоох аргачлал байхгүй хэдий ч зарим аргачлалыг шүүхийн практикт хэрэглэдэг байна. Тухайлбал, А.М.Эрделевскийн зохиосон хүснэгтийг³³ шүүхийн практикт хэрэглэж байна.

Сэтгэл санааны нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход $D = d \cdot f_v \cdot i \cdot c \cdot (1 - fs)$ томъёог ашиглахыг эрдэмтэн судлаач Эрделевский санал болгож байна.

Хүснэгт 1

Гэмт үйлдэл	Сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ	
	Нэгжид ноогдох дүн	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
Хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулах	0.8	576
Дээрх үйлдэл нь тарчлаан зовоож онц хэрцгийгээр үйлдэгдсэн бол	1	720
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр гэмтэл учруулах	0.3	216
Дээрх үйлдэл нь тарчлаан зовоож, хэрцгийгээр үйлдэгдсэн бол	0.5	360
Хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл учруулсан бол	0.03	24

³³ Б.Д.Завидов. Моральный вред. 2001., С 21-24

$$D = d * f_v * i * c * (1 - f_s)$$

- D – Сэтгэл санааны хохирлын нийт дүн;
- d - Сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ;
- f_v – Гэмт этгээдийн үйлдсэн гэм хорын хэмжээ. Гэм хор нь 0-ээс их 1-ээс бага байна $0 \leq f_v \leq 1$;
- i – хүвь хүний онцлог. 0-ээс их 2-оос бага $0 \leq i \leq 2$;
- c – анхаарч үзвэл зохих нөхцөл байдал. 0-ээс их 2-оос бага $0 \leq c \leq 2$;
- f_s – хохирогчийн гэм буруутай байдал. 0-ээс их 1-ээс бага $0 \leq f_s \leq 1$.

Хүснэгт 2

Гэмт хэргийн төрөл	Учирсан хэмээн үзэж байгаа сэтгэл зүйн хохирлын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ³⁴ тооцох нь
Бусдын эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулах	576
Дээрх гэмт хэргийг онц харгис аргаар, тохуурхан даажигнаж, эсхүл зовоон тарчлаан үйлдэх	720
Бусдын эрүүл мэндэд хүндэвтэр гэмтэл учруулах	216
Дээрх гэмт хэргийг онц харгис аргаар, тохуурхан даажигнаж, эсхүл зовоон тарчлаан үйлдэх	360
Хүний эрхтэн эсхүл эдийг шилжүүлэн суулгах зорилгоор авахыг албадах	288
Дээрх гэмт хэргийг эрхшээлдээ байгаа эсхүл биеэ хамгаалах чадваргүй хүний тухайд үйлдэх	360
Бэлгийн замын халдварт өвчин халдаах	36
Өвчтөнд тусламж үзүүлээгүйн улмаас эрүүл мэндэд нь хүндэвтэр гэмтэл учруулах	24
Дээрх гэмт хэргийг өвчтөний эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулан үйлдэх	216
Хүн хулгайлах	576
Дээрх гэмт хэргийг бие махбодид шаналал учруулан үйлдэх	720

³⁴ ОХУ-д хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 1300 рубль байгаа бөгөөд 2007 оны 9 дүгээр сараас 2300 рубль болсон.

Дээрх гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд хүнд эсхүл хүндэвтэр гэмтэл учруулах	1080
Хууль бусаар хорих (1 хоног)	216
Дээрх гэмт хэргийг бие махбодид шаналал учруулан үйлдэх	360
Дээрх гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд хүнд эсхүл хүндэвтэр гэмтэл учруулах	576
Сэтгэцийн эмнэлэгт хууль бусаар байрлуулах (1 хоног)	216
Дээрх гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд хүнд эсхүл хүндэвтэр гэмтэл учруулах	504
Хуурамч мэдээлэл тараах	24
Дээрх гэмт хэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан үйлдэх	36
Доромжлох	12
Дээрх гэмт хэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан үйлдэх	24
Хурьцал үйлдэх, эсхүл бэлгийн шинжтэй хүчирхийллийн бусад үйлдлийг хүчин, заналхийлэл, эсхүл хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг ашиглан үйлдэх	432
Дээрх гэмт хэргийг алах, эсхүл эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулахаар заналхийлэх замаар /хамтад нь/ үйлдэх	720
Дээрх гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулах	1080
Иргэнийг ялгаварлан гадуурхах	144
Зохиогч, зохион бүтээгчийн эд хөрөнгийн бус эрхийг зөрчих	144
Итгэл үнэмшил, шашин шүтэх эрхийг зөрчих	18
Хүүхэд үрчлэх, зохиомол аргаар үр суулгах тухай нууцыг задруулах	144
Хууль бусаар саатуулах	144
Хууль бусаар цагдан хорих (1 хоног)	288
Хууль бусаар эрх чөлөөг хязгаарлах бусад тохиолдол (1 хоног)	7.2
Мэдүүлэг өгөхийг албадах	216
Дээрх гэмт хэргийг хүч хэрэглэн, тохуурхан даажигнаж эсхүл эрүүдэн шүүн үйлдэх	576

Иргэний эрх, эрх чөлөөг бусад аргаар албан тушаалтан, захиргааны байгууллагын хууль бус үйлдэл, шийдвэрээр зөрчих	36
Дээрх гэмт хэргийг их хэмжээний хохирол учруулан үйлдэх	144

Хохирлын нөхөн төлбөрийг тухайн буруутай этгээдээс гаргуулдаг. Буруутай этгээдэд нөхөн төлбөр олгох хангалттай хөрөнгө байхгүй бол улсын төсвөөс энэхүү нөхөн төлбөрийг олгодог. Нөхөл төлбөр олгох улсын сангийн хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлдэг. Жил бүр энэхүү сангийн санхүүжилтийг ОХУ-ын Засгийн газраас баталж өгдөг бөгөөд Улсын төсвийн тухай хуулиар зохицуулдаг.

Украйн улсад Эрделевскийн хүснэгтийг Украин улсын шүүх үйл ажиллагаанд удирлага болгох талаар Дээд шүүхээс захирамж гаргаж шүүхийн практикт ашигладаг байна. Хохирлыг ОХУ-тай адил буруутай этгээдээр нөхөн төлүүлдэг байна.

Австри улсад: Эрүүгийн хэргийн хохирогч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллаганы явцад хохирол нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй. Тус улсын Эрүүгийн процессын тухай хуулийн 4 дүгээр параграфт зааснаар байцаан шийтгэх ажиллаганы явцад иргэний журмаар тухайн асуудлыг шийдвэрлэж байна. Үүнийг Adhdsionsverfahren буюу иргэний журмаар шийдвэрлэх гэж нэрлэдэг. Гэхдээ эрүүгийн шүүх процессын явцад эрүүгийн болон иргэний хэргийг аль алиныг нь шийдвэрлэдэг байна.

Австрийн Иргэний хуулийн 1325 дугаар зүйлд шаналал, зовиураас үүдэлтэй эдийн бус хохирлыг /Schmerzensgeld/-ыг хэрхэн төлөх талаар заасан. Энд бие мах бодид учруулсан гэмтлийн хохирлыг буруутай этгээдэд нөхөн төлүүлнэ гэж заасан. /1325. Wer jemanden an seinem Körper verletzt, bestreitet

die Heilungskosten des Verletzten, ersetzt ihm den entgangenen, oder, wenn der Beschädigte zum Erwerb unfähig wird, auch den künftig entgehenden Verdienst; und bezahlt ihm auf Verlangen darüber ein den erhobenen Umständen angemessenes Schmerzensgeld./

Тус улсын Гэмт хэргийн хохирогчид тусламж үзүүлэх тухай хуульд зааснаар хохирол нөхөн төлүүлэх эрх нь хууль ёсны эрх юм.

Дани улсад: Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тухай хууль, журам байдаггүй. Харин Шүүхийн захиргааны тухай хууль буюу Administration of Justice Act (AJA)-гаар эрүү, иргэний хэрэг маргааныг шийдвэрлэдэг.

Данийн эрх зүйд гэмтэж, бэртсэн хохирогчийг тодорхойлсон ойлголт байдаггүй. Харин сонирхогч этгээд өөрөө хүсэлт гаргаж эрхээ хамгаалуулж болдог.

Их британид: Нөхөн төлбөрийн тухай хуулийг баталж мөрдөж байна. Тус хуулиар Санхүүгийн үйлчилгээ хариуцсан эрх мэдэл бүхий байгууллагаас баталсан Санхүүгийн үйлчилгээний нөхөн төлбөрийн загварыг ашиглах ба Тусгай шүүхээр асуудлыг шийдвэрлэхээр заасан. Мөн Төрийн нарийн бичгийн даргыг Зохицуулагчаар тохоон томилж, холбогдох журмыг боловсруулах үүрэг өгсөн. Нөхөн төлбөрт зориулсан Нэгдсэн санд хуримтлал үүсгэх хувь хэмжээг тусгайлан заасан байна.

Английн парламентын зүгээс хүн алах, гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар хуульчлаагүй боловч эдгээр ойлголтыг тодорхой болгох, удирдлага болгох журмыг хуульчид өмнөх хэрэг тохиолдлоос эшлэн авч байсан онцлогтой. Иймээс нийтлэг эрх зүйн орнуудын шүүгчид шийдвэр гаргахдаа дээд шүүхийн харьяаллын хүрээнд тогтоосон хуулийг "жишиг" болгон ажиллаж, хувийн

эрх зүйн орнуудын шүүгчид хуулийн зохицуулалтыг ягштал баримталдагтай адил жишгээ удирдлага болгон шийдвэр гаргаж байна. Лордуудын танхим буюу дээд шүүхээс XVIII зуунд анх удаа өөрийн өмнөх шийдвэрүүдэд тулгуурлан, тусгай зохицуулалтыг хуульд зааж өгсөн ч 1964 онд тус хуульд нэмэлт өөрчлөлт орж, шүүгчид дотоод итгэл үнэмшлээр шийдвэр гаргах боломжийг бүрдүүлсэн. Гэхдээ анхан шатны шүүхүүд нь дээд шүүхийн гаргасан журмыг удирдлага болгосон байна.

АНУ-д: 11 муж нь нөхөн төлбөрийн дээд хэмжээний тухай хууль гаргасан (энгийн хохирлын хэмжээг 1-5 дахин ихэсгэх), зарим муж 300,000-5 сая ам.доллар гэж тогтоосон, 13 муж Улсын сан (Treasury), эсвэл Адил тэгш шударга ёсны эвслээс тогтоосон хувь хэмжээг удирдлага болгодог ажээ³⁵. Мөн АНУ-ын дээд шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг 9 дахин ихэсгэснээс хэтэрч болохгүй гэж тусгайлан шийдвэр гаргасан нь орон даяар хэрэгжих жишээтэй. Гэхдээ хохиролд олгох нөхөн төлбөрийн хэмжээний 75 болон түүнээс дээш хувийг Улсын буюу хандивын сангаас гаргаж чадахгүйд хүрсэн учир дутагдалтай байна. Урьдчилан тооцоогүй зардлын хэмжээ буюу хохирлын нөхөн төлбөрийн хувь нь нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс бүрэн хамааралтай байгааг судлаачид мөн онцолдог байна. Ийнхүү задгай байдлыг хууль тогтоогчийн зүгээс хуулиар шийдвэрлэх чиг хандлагатай гэж үзэж болно.

Япон улсад: Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны дэргэд цөмийн хор хохирлын нөхөн төлбөрт зориулсан хураамжийг цөмийн талбар буюу онгоц бүрт 120 тэрбум иен байхаар тооцдог ба гадаад улсын зүгээс цөмийн хөлөг онгоц ирэх бол нэг бүрт нь 36 тэрбум иен нөхөн төлбөрт байршуулахыг шаарддаг байна. Нөхөн төлбөрт зориулсан хураамжаа Хууль зүйн асуудал хариуцсан товчоо буюу Тойргийн хууль зүйн асуудал хариуцсан товчоонд шилжүүлж, Яамны зөвшөөрөлтэйгээр хохирол учирсан талаар

³⁵ <http://uscode.house.gov/download/pls/28C171.txt>

гомдол гаргасан этгээдэд олгоно. Нөхөн төлбөр олгох журмыг Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам болон Хууль зүйн яам хамтарч гаргадаг онцлогтой. Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны дэргэд Цөмийн хохиролтой холбоотой нөхөн төлбөрийн асуудал эрхэлсэн Маргаан таслах хороо ажиллахаар тус тус хуульчилжээ. Энэ хуультай холбогдуулан Ажлын байран дээр ослын даатгалын тухай хуульд (the Insurance Act for the Compensation of Work Accidents (Act No. 50 of 1947)) нийцүүлэн асуудлыг нарийвчлан зохицуулжээ.

Хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хууль /Victim Compensation Act /-иар уг харилцааг зохицуулж байгаа бөгөөд гэмт хэргийн хохирогчоос мэдүүлэг авах үедээ цагдаа нь тухайн хохирогчийн эрхийг хамгаалах төлөөлөгч томлиуулахаар шүүхэд хүсэлт гаргах үүрэгтэй байдаг. Ихэнх онц хүнд гэмт хэргүүдэд хохирогч нь өөрөө тухайн төлөөлөгчийн туслалцааг авах эрхтэй. Төлөөлөгч нь хохирогчид учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэхэд туслалцаа үзүүлж ажилладаг.

Олон улсын эрх зүй болон ихэнх улсын үндэсний хууль тогтоомжоор эдийн бус буюу сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирлыг үнэлдэг, хүний амь насны гэм хорыг тооцдог эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байна.

Харин Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт хохирогч гэж нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хэлнэ гэж заасан. Нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, бие эрхтний хохирол нь эдийн засгийн эргэлтэд арилжааны зүйл болдоггүй ба эдийн бус хохиролд хамаардаг. Харамсалтай нь энэ төрлийн хохирлын хэмжээг хэрхэн яаж тооцож, барагдуулах талаар эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас гэмт хэргийн улмаас хохирсон иргэд өөрт

учирсан хохирлоо бодитой, бүрэн дүүрэн, шударгаар нөхөн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй, хохирсоор байгаа юм³⁶.

Жишээ нь: Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан тохиолдолд түүнийг оршуулахтай холбоотой зардал болон гэм хор учруулсны төлбөрийн хэмжээг Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.3 дахь хэсэгт зааснаар тогтоож байна. Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.3 дахь хэсэгт "Хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсны төлбөрийг түүний өв залгамжлагч шаардах эрхтэй." гэж заасан ч Дээд шүүхийн өмнөх тайлбарт дурдсанаар эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй хэвээр байна. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгахтай холбоотой харилцааг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт зохицуулсан нь албан тушаалтны хууль бус ажиллагааны улмаас учирсан хохирлыг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх боломж олгож байна.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 388 дугаар зүйлийн 388.1. дэх хэсэгт "Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэтгэл санааны үр дагавраа арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших хийгээд бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй." гэж заасан байдаг.

Тус зүйлийг Улсын дээд шүүхийн тайлбар³⁷-аар энэ зүйлийн 388.1. дэх хэсэгт заасан "Хууль зөрчсөн ажиллагаа" гэдэгт мөн зүйлийн 389.2.-т заасан тохиолдлуудаас гадна

³⁶Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтын талаарх судалгааны тайлан. ХЭҮК, 2013 он

³⁷Улсын дээд шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоол

байцаан шийтгэх ажиллагааны явцад эрүүдэн шүүгдэж, хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртөж, сэтгэл санаа, эрүүл мэнд, амь насаараа хохирсон явдлыг хамааруулж үзнэ.

"Эрүүдэн шүүгдсэн" гэдэгт Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлийн 1-д заасан "хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдэл"-ийг ойлгоно хэмээн тодорхойлжээ.

Тиймээс тус заалтыг үндэслэн эрүү шүүлтийн хохирогч нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлгийг удирдлага болгон иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гарган, төрөөс хохирлоо нөхөн төлүүлэх боломжтой байгаа юм.



ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХ

Монгол улсын Үндсэн Хууль, хууль олон улсын гэрээ конвенцоор хүн бүр халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хохирогч, сэжигтэн, яллагдагчийн Үндсэн Хууль, бусад хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, эрх бүхий мэргэжлийн өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй.

Өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан хууль, эрх зүйн баримт бичиг

- Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 11 дүгээр зүйл
"Гэмт хэрэгт яллагдаж буй хүн бүр өөрт нь тулгасан хэргийг өмгөөлүүлэх... эрхтэй"
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
14.2(b) "өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх сонгож авсан өмгөөлөгчтэйгээ харилцах"
14.2(d) "өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх...өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх",
- Монгол Улсын Үндсэн хууль
16.14 дэх хэсгийн заалт "... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах"

55.1, 55.2 дахь хэсэгт "шүүгдэгчид өөрийгөө өмгөөлөх эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ"

- **Эрүүгийн байцаан шийтгэх хууль**

41.1 дэх хэсэгт "Өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлэх,"

35.2.7 дэх хэсэгт "сэжигтэн, яллагдагч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах"

- **Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль**

34.2 дахь хэсэгт "Өмгөөлөгч гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийг төлөөлөхдөө төлөөлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хуульд заасан бүх арга хэмжээ авах ба шаардлагатай эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэргийн бодит байдлыг тогтооход туслах үүрэгтэй."

- **Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль**

29.2 дэх хэсэгт "Талууд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд өмгөөлөгчийн туслалцаа авч болно."

- **Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль**

6.1 эх хэсэг "Хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүн нь төлбөрийн чадваргүй яллагдагч байна."

- **Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль**

24.1.3 дахь хэсэгт "Хуульч нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн туслалцаа үзүүлэх, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зохих байгууллагад төлөөлөх"

Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоол "Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр"

45.2 дахь хэсэгт "...төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээний зардлыг төр хариуцна" гэж иргэний эрхээ хамгаалуулах, төр, хуулийн байгууллагад хандах эрхийг нь баталгаажуулж өгсөн. Өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх бодит боломжийг бүрдүүлж, хангаж, хамгаалах нь төрийн үүрэг юм.

Иргэн эрүү, захиргаа, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийгөө өмгөөлөх, эрх бүхий байгууллагаас авсан мэргэжлийн өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх болон төлбөрийн чадваргүй бол улсаас томилж өгсөн өмгөөлөгчөөр өмгөөлүүлж, хууль зүйн туслалцаа авах эрхтэй.

Өөрийгөө өмгөөлөх гэдэг нь: Эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн эрх ашгийг хамгаалан бие даан оролцохыг хэлнэ.

Хууль зүйн туслалцаа нь: Өөрт тохиолдсон асуудал, нотлох баримт цуглуулах талаар зөвлөгөө авах, мэргэжлийн өмгөөлөгчийн туслалцаа авахыг ойлгоно. Мэргэжлийн өмгөөлөгч нь тухайн процесс ажиллагаанд оролцохдоо өмгөөллийн туслалцаа үзүүлж буй өмгөөлүүлэгчийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавихаас гадна мэргэжлийн өндөр ёс зүйтэй байна.

Өмгөөлөгч нь хэрэгт оролцох талаар тохиролцсон буюу томилогдсон үеэс өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээс татгалзах эрхгүй.

Өмгөөлөгчөөр заавал хангах тохиолдол

Дор дурдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч заавал өмгөөлөгч авна. Үүнд:

- Өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй бол (хэлгүй, дүлий, хараагүй, сэтгэцийн өвчтэй байх);
- Насанд хүрээгүй байх;
- Монгол хэл, бичиг мэддэггүй бол;
- Цаазаар авах ял шийтгэгдэж болох;
- Хэргийнхээ талаар харилцан эсрэг сонирхолтой хэд хэдэн сэжигтэн, яллагдагчид, шүүгдэгчийн аль нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;
- Төлбөрийн чадваргүй этгээд өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан бол өмгөөлөгчөөр заавал хангагдах эрхтэй.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө өөрөө сонгох эрхтэй бөгөөд нэг этгээд хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болно. Энэ эрхийг баталгаатай эдлүүлэхийн тулд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө сонгон аваагүй бол түүний хүсэлтээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хангах бөгөөд өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж тулгаж болохгүй.

Төлбөрийн чадваргүй этгээд хууль зүйн туслалцаа авах эрхтэй

Төрөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаатай эдлүүлэхийн тулд "Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай" хууль, мөн 2006 онд Засгийн газраас "Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр" -ийг баталж, Хууль зүйн туслалцааны

төвүүдийг аймаг, дүүргүүдийн засаг даргын тамгын газрын дэргэд байгуулан ажиллуулж байна.

Хүн бүр хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар /хохилогч, хариуцагч, сэжигтэн, яллагдагч/ хууль зүйн туслалцаа авах боломжтой ч амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур орлоготой, төлбөрийн чадваргүйгээс энэ эрхээ бүрэн эдлэх боломжгүй байдаг. Иймээс төр хууль зүйн туслалцаа авах шаардлагатай иргэний эрхийг нь хангаж мэргэжлийн өмгөөлөгч томилж, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлнэ. Төлбөрийн чадваргүй иргэн сум, дүүрэг, багийн Засаг даргаас энэ тухай тодорхойлолтыг авч аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлд хандаж, томилолтын өмгөөлөгч авах эрхтэй.

Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх;
- Эрүү, иргэн, захиргааны хэрэгт анхан шатны хууль зүйн зөвлөгөө өгөх;
- Эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа явуулдаг.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч таныг сэжигтнээр тооцож, тогтоол үйлдсэн үеэс та өөрийгөө өмгөөлөх буюу өмгөөлөгчийн туслалцаа авах эрхтэй болохыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор сануулах үүрэгтэй.

Хууль зүйн туслалцаа авахын тулд хаана хандах бэ?

- Хуульчдын холбоо;
- Монголын өмгөөлөгчдийн холбоо;
- Хууль зүйн туслалцаа үзүүлэх төв;
- Хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх хуулийн этгээд;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид энэ тухай хүсэлт гаргах;
- Өмгөөлөгчийг сонгохдоо өөрөө буюу төрөл садны хүний туслалцааг авах
- Төлбөрийн чадваргүй бол төлбөрийн чадваргүй болохыг тодорхойлсон баримтыг бүрдүүлэн харьяа нутаг дэвсгэрт байрлах эрх зүйн туслалцааны төвд хандах эрхтэй.

ШУДАРГА ШҮҮХЭЭР ШҮҮЛГЭХ ЭРХ



Шударга шүүхээр шүүлгэх эрх нь хувь хүнийг шударга бусаар яллахаас төрөөс хамгаалсан үндсэн эрх юм. Төр өөрийн иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн байхаас үл хамааран бүх хүний эрхийг хууль, шүүхийн өмнө тэгш хангах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүх үүрэгтэй байдаг. Хүний эрхийн хороо "шударгаар шүүлгэх" гэдэг нь "талуудын адил тэгш байх, шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явуулах зэрэг нөхцөлийг хангасан байх явдал" гэж тайлбарлажээ.

Шударга шүүхээр шүүлгэх эрх нь эрүүгийн хэрэг, эрх зүйн маргаан эхэлсэн үеэс шүүхээр хэргийг бүх шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэж дуусах хүртэлх үеийг хамаарна. (Шүүхээс өмнөх шатанд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийн талаарх мэдээллийг хохирогчийн эрх, сэжигтэн, яллагдагчийн эрх, хоригдогчийн эрх, хохирол нөхөн төлүүлэх эрх хэсгээс үзэж танилцана уу.)

Шүүх хурлаас өмнөх шатанд эдлэх эрх:

- Халдашгүй дархан байх;
- Халдашгүй дархан байх эрх нь дур мэдэн, хууль бусаар баривчилж, цагдан хоригдохоос хамгаалагдах явдал юм.
- Албадан саатуулагдсан тухай мэдээлэл авах;
- Баривчлагдсан, түр албадан саатуулагдсан хүн бүрт баривчлагдсан, саатуулагдсан шалтгаан болон өмгөөлөгч авах зэрэг эрхийг нь сануулахаас гадна тэдэнд ямар ял тулгаж байгааг нэн даруй мэдэгдэх ёстой. Энэхүү мэдээлэл нь баривчилгаа болон түр саатуулах ажиллагааг хуулийн дагуу явуулахад хяналт тавьж, ял оногдуулсан тохиолдолд өөрийгөө хамгаалах боломжийг олгодог.

- Шүүх хурлаас өмнө хууль зүйн болон эрүүл мэндийн тусламж авах;
- Эрүүгийн хэрэгт сэжиглэгдэн хорионд байгаа хүн бүр эрхээ эдлэх, өөрсдийгөө хамгаалах, хууль зүйн туслалцаа авах, шаардлагатай үед эмчид үзүүлэх, эмчилгээ хийлгэх эрхтэй.
- Боломжит хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эсхүл суллагдах;
- Эрх чөлөө нь хязгаарлагдсан хүн бүрийн эрхийг хамгаалахын тулд нэн даруй шүүхэд эсхүл шүүх эрх мэдэл бүхий албан тушаалтанд шилжүүлсэн байх ёстой.
- Өмгөөлөлд бэлтгэх боломжтой цаг хугацаа, нөхцөлөөр хангагдах;

Шүүх хэргийг шийдвэрлэхдээ талуудыг ижил тэгш эрхтэйгээр оролцуулж өмгөөлүүлэх бололцоогоор хангах ёстой.

Эрүү шүүлтээс ангид байж, хүнлэг нөхцөлд хоригдох

Хүн бүр өөрт нь тулгасан ялыг аливаа эрүү шүүлт, зүй бус харьцаанаас ангид байж, шүүх хуралд бэлтгэх бүрэн бололцоогоор олгосон нөхцөлд хуульд захирагдах, шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй.

Шүүх хэргийг хянан шийдвэрлэх үед эдлэх эрх:

- Шүүхийн өмнө эрх тэгш байх;

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт Монгол Улсын иргэн Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон

гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно гэж заажээ.

Олон улсын хүний эрхийн гэрээ болон үндэсний хууль тогтоомжуудад шүүх хурлын явцад эрх тэгш байх баталгааг олон талаар хангасан байдаг. Үүнд хуулиар ялгаварлан гадуурхахыг хориглох болон шүүхэд тэгш эрхтэйгээр хандах эрхүүд багтана.

- **Хуулийн дагуу байгуулагдсан бие даасан, хараат бус болон шударга шүүхээр шүүгдэх;**

Шударга шүүхийн урьдчилсан нөхцөл нь шүүх тухайн хэргийг шийдвэрлэхдээ хуулийн дагуу байгуулагдсан, хараат бус, бие даасан байж шударга шийдвэр гаргах явдал мөн.

- **Шударгаар шүүлгэх;**

Шударгаар шүүлгэх эрх гэм буруу нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох, албадан саатуулахгүйгээр хэргийг шийдвэрлэх, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх нөхцөлөөр хангагдах, гэрчийг дуудан мэдүүлэг авах, хуулийг буцаан хэрэглэхээс хамгаалуулах эрх зэрэг эрхийг багтааснаас ч өргөн агуулгыг хамаардаг. Шударгаар шүүлгэх эрхийг хэрэгжүүлэхэд талуудад тэгш боломж олгох, мэтгэлцэх, байцаан шийтгэх ажиллагааг шуурхай явуулах зэрэг зарчмыг мөрдлөг болгоно.

- **Нээлттэй шүүлгэх;**

Нээлттэй шүүлгэх эрхийн хүрээнд шүүн таслах ажиллагаанд хэргийн оролцогч талуудаас гадна олон нийт оролцож шүүн таслах ажиллагааг хэрхэн явуулж ямар шийдвэр гаргаж байгааг мэдэх эрхтэй.

- Гэм буруу нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох;

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно" гэж заажээ.

Энэ нь эрүүгийн хэрэгт буруутгагдаж байгаа ямар ч этгээдийг шударга шүүхийн үйл ажиллагааны дагуу бурууг нь нотлогдох хүртэл буруугүй гэж тооцох эрх юм. Нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруутай мэтээр харьцаж болохгүй.

- Сэжигтэн өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, мэдүүлэг өгөхөөс татгалзах;

Төрийн байгууллагуудыг болон төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа албан тушаалтанд шууд ба шууд бус байдлаар хүнд бие махбодын болон сэтгэл санааны албадлага хэрэглэх, шахалт үзүүлэх хэлбэрээр байцаалт явуулахыг хориглосон байдаг.

- Өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгчийн туслалцаа авах;

Гэмт хэрэгт яллагдаж байгаа хүн бүр өөрсдийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, шүүн таслах ажлын шаардлагаас хамааран тэдэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр шүүхээс томилсон өмгөөлөгчтэй байх, өмгөөлөгч авсны хөлсийг төлөх чадваргүй бол үнэ төлбөргүйгээр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй.

- Шүүх хуралд биечлэн оролцох, давж заалдах;

Гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хүн бүр шүүхийн шийтгэсэн болон оноосон ялыг эргэн хянуулахаар хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй бөгөөд энэ нь гэмт хэргийн хүнд хөнгөнөөс үл хамаарна.

- **Орчуулагчаар хангагдах;**

Гэмт хэрэгт яллагдаж байгаа хүн бүр шүүн таслах ажиллагаа явуулж буй хэлийг ойлгохгүй тохиолдолд орчуулагчийн туслалцааг үнэ төлбөргүй авах эрхтэй.

Шударгаар шүүлгэх эрхийг хангахад эрүүгийн шүүн таслах ажиллагааны явцад дээрх эрхүүд хангагдаж буй эсэхэд төр анхаарлаа хандуулах ёстой.

Шударга шүүхээр шүүлгэх эрхийн хүрээнд дараах зарчмууд үйлчилдэг

Шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим нь арьс үндэс, арьсны өнгө хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулах ёстой. Түүнчлэн гэмт хэргийн төрөл, хэлбэрээс үл хамааран гэмт хэрэгт холбогдсон этгээд адил хамгаалалт эдлэх, шүүн таслах ажиллагааны явцад оролцогчид тэгш боломжоор хангагдсан байх өөрөөр хэлбэл "яллах болон өмгөөлөх тал" тэнцвэртэй байхыг илэрхийлдэг.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй" гэж баталгаажуулжээ.

Мөн шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа хүн бүрт тэгш, нээлттэй, хүртээмжтэй байхыг ойлгоно.

- Гэм буруугүйд тооцох зарчим буюу сэжигтнээр тооцогдохоос эхлэн шүүхээр хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд

гэмт буруугүйд тооцох нь эрүүгийн хэрэг үүсгэхээс эхлэн хэрэгт холбогдсон этгээдтэй харьцахыг тодорхойлох зарчим юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14(2) дахь заалтад "эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй" гэж баталгаажуулсан байдаг.

Гэм буруутай болохыг хуулийн дагуу нотлох хүртэл гэм буруугүйд тооцох эрхийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатанд баталгаатай хангана. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг гэм буруутайг эргэлзээгүйгээр нотлох нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын үүрэг бөгөөд тэдгээрээс олон нийтэд сөрөг мэдэгдэл хийх нь гэм буруутайд тооцох эрхийг зөрчсөн явдал болно.

Хохирлоо нөхөн төлүүлэх эрх:

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 6 дахь заалтад "Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу заримт талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ" гэж заасны дагуу нөхөн төлбөр авахын тулд хувь хүн:

- Гэмт хэрэг үйлдсэн гэж эцсийн шийтгэл ногдуулсан байх. Эцсийн шийтгэл гэдэг нь тухайн хэргийн талаар цаашид давж заалдах болон хянан шийдвэрлэх хүсэлт гаргах боломжгүй, бүхий л арга хэмжээг авч барагдуулсан.
- Шүүхийн шийдвэрээр хорих эсвэл бусад төрлийн ялыг эдэлсэн байх явдал хамаардаг байна.

ШАШИН ШҮТЭХ, ЭС ШҮТЭХ ЭРХ



Шашин шүтэх эс шүтэх, үзэл үнэмшилтэй байх эрх чөлөө нь олон улсын стандартын дагуу тодорхойлсноор харилцан адилгүй боловч хоорондоо уялдаатай маш олон асуудлыг хамарсан өргөн хүрээтэй эрх юм. Энэ нь эргэл мөргөл хийх, шашны зан үйлээс эхлээд сургаал номлол айлдах буюу сонсох, сурталчлах, уламжлалт шашнаа өвлүүлэх, цаашилбал шашин шүтлэгээ солих зэрэг хүний заншил, үзэл бодол, итгэл үнэмшилтэй холбоотой олон харилцааг хамарна. Хүний эрх, эрх чөлөө салшгүй байхын хувьд, ялангуяа хүн болохын хувьд итгэл, үнэмшил сүсэг бишрэлтэй байх нь нийгэмд оршин буй хүний оюун санааны эрх чөлөөний тод илрэл юм.

Монгол Улс Үндсэн Хуульдаа хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахдаа шашин шүтэх, эс шүтэх эрхийг нэгэн заалт болгон оруулж, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар төрөөс сүм хийдтэй харилцах харилцааны зохицуулалт, иргэн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг тодорхойлж өгсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дүгээр зүйлийн 16.1.15.

"Монгол Улсын иргэн ... шашин шүтэх эс шүтэх эрх чөлөөтэй"

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 3 дугаар зүйл

1. Аливаа шашныг шүтэх буюу эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна.
2. Иргэнийг шашин шүтэх, эс шүтэхэд албадах, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.
3. Иргэдийг шашин шүтлэгийн ялгаа болон шашин шүтэх,

эс шүтэх байдлаар нь ялгаварлан гадуурхах, доромжлох, хагалан бутаргах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4. Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг гагцхүү бусад иргэний мөнхүү эрх чөлөө, эрүүл мэнд, ёс суртахуун болон үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг тогтон зохицуулж байгаа Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээр зохицуулан хэрэгжүүлнэ.
5. Иргэний шашин шүтлэгийн байдлыг уг хүн өөрөө хүссэнээс бусад тохиолдолд албан баримт бичигт тусгахыг хориглоно.

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний эрх зүйн орчныг бий болгон, ханган ажиллах үүрэгтэй төр хийгээд шашин, сүм хийдийн харилцааны үндсийг тодорхойлохдоо уг хуульд "... төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх зарчимд үндэслэнэ..." гэжээ. Энэ нь шашин нь үндэсний аюулгүй байдал, төрийн тусгаар тогтнолд аюул занал учруулахгүй байх, төр нь шашны эрх, эрх чөлөөг хүндэтгэн, цаашилбал ханган орших үндсийг заасан гэж ойлгоно. Тиймээс энд аль аль талд нь хүний хуваагдашгүй, харилцан уялдаатай эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах үүргийг зааж өгсөн ажээ.

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө олон улсад

Олон улсын хэмжээнд хүний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг нилээн өргөн хүрээнд баталгаажуулж, гэрээ конвенцуудад тусгасан бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн тогтолцоонд анх 1986 онд шашны хүлээцтэй байдлын асуудал хариуцсан тусгай илтгэгчийн мандатыг бий болгож байсан нь 2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Комиссын тогтоолоор уг мандатын нэрийг шашин шүтэх, эс шүтэх буюу итгэл үнэмшилтэй байх эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч болгож өөрчилснийг Эдийн засаг, нийгмийн

Зөвлөл 2000/261 тоот тогтоолоороо баталгаажуулжээ. Хүний эрхийн Комиссын халааг авсан НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөл 2010, 2013 онд энэ мандатын хугацааг дахин сунган ажиллаж байна. Тусгай илтгэгчийн мандатыг Хүний эрхийн Зөвлөлийн 6/37 тоот тогтоолын дагуу

- Үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд шашин шүтэх эс шүтэх буюу итгэл үнэмшилтэй байх эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн арга хэмжээг хөхиүлэн дэмжих;
- Шашин шүтэх, эс шүтэх буюу итгэл үнэмшилтэй байх эрхийн хэрэгжилтэд учирч буй саад бэрхшээлийг тодорхойлох, тэдгээр саад бэрхшээлийг даван туулах санал зөвлөмж гаргах;
- Шашин шүтлэг, итгэл үнэмшил дээр суурилсан үл хэлцэх байдал, ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг устгах тухай тунхаглалын зүйл заалтад нийцээгүй тохиолдол, засгийн газрын үйл ажиллагааг үргэлжлүүлэн шалгах, цаашид авах арга хэмжээнийн талаар санал зөвлөмж гаргах;
- Мэдээлэл цуглуулах, санал зөвлөмж өгөх зэрэг илтгэх, тайлагнах үйл явцад жендэрийн баримжаатай хандлагыг ашиглах гэж тодорхойлжээ.

Одоо энэ мандатыг эзэмшигч нь ХБНГУ-ын иргэн Хайнер Биэлефелдт юм.

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний хүрээнд олон улсын стандартын дагуу дараах асуудлуудыг харилцан уялдаатай буюу харьцуулсан шинжтэйгээр авч үздэг. НҮБ-ын шашин шүтэх, эс шүтэх буюу итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудал хариуцсан тусгай илтгэгчид НҮБ-д өгсөн илтгэлүүдэд уг эрх чөлөөний асуудлыг томъёолж, нөхцөл байдлыг дүгнэхдээ дараах үндсэн асуудлуудын хүрээнд нилээн өргөн хэмжээнд авч үзсэн байдаг. Үүнд:

- Шүтэх, эс шүтэх буюу итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө;
- Ялгаварлан гадуурхалт;
- Эрсдэлт бүлгүүд;
- Шүтэх, эс шүтэх буюу итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө хүний бусад эрхтэй солбицох уулзвар.

Үүний дундаас шүтэх, эс шүтэх буюу итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг салбарлуулан авч үзвэл:

- Шашин шүтлэг буюу итгэл үнэмшилтэй болох, түүнийгээ өөрчлөх, түүнээсээ татгалзах эрх чөлөө;
- Дарамт шахалтаас анхгид байх эрх чөлөө;
- Шашин шүтлэг буюу итгэл үнэмшлээ илэрхийлэх эрх;
- Ялгаварлан гадуурхалт.

Хүмүүсийн хоорондын харилцаанд шашин шүтлэг, итгэл үнэмшлийн талаарх асуудал ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөхтэй зайлшгүй холбогдоно. Иймд эн тэргүүнд шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг зөрчихөөс сэргийлэхийн тулд ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах асуудлыг ярих шаардлагатай. Нэгдсэн Үндэстний Байгууллагын шашин шүтэх, эс шүтэх эрх буюу итгэл үнэмшилтэй байх эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгчийн өмнөх илтгэлүүд, мөн Хүний эрхийн хорооны Ерөнхий зөвлөмжүүдэд ялгаварлан гадуурхалтыг энэ эрхийн хүрээнд дараах сэдвээр ангилсан байна. Үүнд:

- Шашин шүтлэг, итгэл үнэмшлээр ялгаварлан гадуурхалт;
- Төрийн шашин.

Эрсдэлтэй бүлгүүд

Ямар нэг байдлаараа нийгмийн зонхилох буюу эрх мэдэл бүхий хэсгээс ялгаатай өвөрмөц онцлогтой зарим бүлэг шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө хэрэгжүүлж, ялгаварлан

гадуурхалтаас ангид байх эрхээ эдлэж чадахгүй байх нь бий. Иймд шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө нь эрсдэж болох өртөмтгий бүлгүүдийн асуудлыг бас анхаарах шаардлагатай юм.

- Эмэгтэйчүүд;
- Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүс;
- Дүрвэгчид;
- Хүүхэд;
- Үндэсний цөөнх;
- Цагаач ажилчид.

Шүтэх, эс шүтэх буюу итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө хүний бусад эрхтэй солбицох уулзвар

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаажих, хэрэгжих нөхцлийн хувьд дараах эрхүүдтэй уялдаа холбоотой авч үздэг. Үүнд:

- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө;
- Амьд явах эрх;
- Халдашгүй байх эрх;
- Эрүү шүүлтээс ангид байх эрх.

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө гэдэг нь өөрийн итгэл үнэмшлийг хадгалах төдийгүй бусдын өмнө чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байхын нэр бөгөөд өөрийн гэсэн шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй байсныхаа төлөө амь насаа алдах, халдлагад өртөх, эрүү шүүлт, зүй бус харьцааны хохирогч болох зэрэг аюул заналаас ангид байх эрхийн тухай асуудал ч бас энд хамаарна.



ИРГЭДИЙН МЭДЭХ ЭРХ

"Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана" хэмээн Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлд заасан байдаг. Өөрөөр хэлбэл, мэдэх, мэдээлэл авах эрх нь хүний заяамал эрхүүдийн нэг юм. Та хүний төрлийг олж хорвоод мэндлэхдээ л энэхүү эрхтэйгээ хамт ирсэн гэсэн үг. Иргэн та мэдэх эрхтэй, хүссэн мэдээллээ олж авах эрхтэй.

Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын үзэл санааг хүлээн зөвшөөрч, Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын Пакт, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактад нэгдэн орж, хүний эрх, мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой заалтуудыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн. Мөн иргэн таны үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл олж авах эрх, эрх чөлөөг Монгол Улсын Үндсэн хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар тус тус баталгаажуулсан байдаг. Иргэн та мэдэх эрхээ эдэлж, үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээлэл олж авснаар төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, шууд болон шууд бус хэлбэрээр оролцох боломжтой.

Та төрийн байгууллагаас ямар мэдээлэл хүсэх эрхтэй вэ?

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу төрийн байгууллагууд дараах 4 төрлийн

мэдээллийг танд нээлттэй, ил тод байлгаж, өгөх, мэдээлэх үүрэгтэй. Үүнд:

1.Үйл ажиллагааны ил тод байдал:

- Тухайн байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтэц;
- Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь;
- Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт;
- Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар;
- Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл;
- Иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний төрөл ангилал, мэдээлэл;
- Төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл;
- Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа;
- Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээлэл;
- Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

2. Хүний нөөцийн ил тод байдал:

- Сул орон тооны зар;
- Албан хаагчийн ёс зүйн дүрэм;
- Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам;
- Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар;
- Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар;
- Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

3. Төсөв, санхүүгийн ил тод байдал:

- Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл;
- Тухайн жилийн төсөв;
- Өмнөх оны төсвийн гүйцэтгэл;
- Дараа жилийн төсвийн төсөл;
- Жилийн эцсийн санхүүгийн тайлан;
- Санхүүгийн тайланд нь хийсэн аудитын дүгнэлт;
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;
- Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийн хэмжээ;
- Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл
- Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Концессын гэрээ байгуулсан тухай бүрт концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл;
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал:

- Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримталж буй эсэх мэдээлэл;
- Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга;
- Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл;
- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл;
- Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан;
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн;
- Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

Мөн нийтэд мэдээлэхийг хориглосон буюу Төрийн нууцын тухай хуулиар тогтоосон нууцлалын зэрэгтэй баримт бичгүүдээс бусад дараах мэдээллийг төрийн байгууллагаас авах эрхтэй. Үүнд:

- Тухайн байгууллагын эзэмшилд байгаа бүх төрлийн мэдээ, баримт бичиг, гэрээ, контракттай холбоотой мэдээлэл;
- Тухайн байгууллагын эзэмшилд байгаа эд зүйлтэй холбоотой мэдээлэл;
- Тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл.

Эдгээр мэдээллийг та цахим болон цаасан хэлбэрээр, мөн амаар тайлбарлуулан авах боломжтой. Мэдээлэл авах хүсэлт гаргахдаа овог, нэр, гэрийн хаяг, цахим шуудан, утасны дугаар, иргэний үнэмлэх, эсвэл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж гарын үсэг зурна. Гарын үсгээ зурах

боломжгүй хүндэтгэх шалтгаантай тохиолдолд бусдаар зуруулж болно.

Таны хүссэн мэдээллийг төрийн байгууллага, албан тушаалтан ажлын 7 өдөрт багтаан гаргаж өгөх ёстой. Шаардлагатай гэж үзвэл энэ хугацааг нэг удаа 7 хоногоор сунгаж болно.

Хэрвээ таны мэдээлэл авах эрхийг зөрчсөн гэж үзвэл тухайн байгууллага, албан тушаалтны талаар дээд шатны байгууллага, албан тушаалтанд, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст, эсвэл шүүхэд гомдол гаргах боломжтой.

Иргэдийн мэдэх, мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага

Иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөөгүй төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэлийг оногдуулна. Иргэдийн мэдээлэл авах эрхийг 3 буюу түүнээс дээш удаа зөрчсөн тохиолдолд тухайн албан хаагчийг эрх бүхий этгээд төрийг албанаас хална. Харин шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мэдээлэл хүсэгчийн эрх, үүрэг

Мэдээлэл хүсэгч мэдээлэл авах талаар дараах эрх эдэлнэ:

- Эрх тэгш байх;
- Мэдээлэл авах хэлбэрээ сонгох;
- Мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх;

- Мэдээлэлтэй холбогдсон асуудлаар нэмэлт лавлагаа авах;
- Мэдээллийн агуулгын талаар амаар тайлбарлуулах;
- Мэдээллийн албан ёсны эх сурвалжийг мэдэх;
- Мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн гэж үзвэл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах;
- Хуульд заасан бусад эрх.

Мэдээлэл хүсэгч мэдээлэл авахдаа дараах үүрэг хүлээнэ:

- Хуульд заасан мэдээлэл авах журмыг биелүүлэх;
- Мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
- Авах мэдээллээ бодитой тодорхойлсон байх.

Иргэн, хуулийн этгээдэд өгөхийг хориглох мэдээлэл

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд зааснаар онцгой нөхцөл, оюуны өмч, хувь хүний нууц, байгууллагын нууцыг хамгаалах үүднээс зарим мэдээллийг бусдад задруулахыг хориглосон байдаг. Үүнд:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэл байгаа бол;
- Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хянан шалгагдаж байгаа асуудалтай холбоотой бол;
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол;
- Тухайн мэдээлэл нь олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах явцтай холбоотой бол;

- Оюуны өмчтэй холбоотой мэдээллийг өмчлөгчийн зөвшөөрөлгүй бол;
- Хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээлэл;
- Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдийн /гүйцэтгэх удирдлага буюу түүнээс эрх олгосон бусад этгээд/ бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.

ХҮҮХДИЙН ЭРХ



Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассемлеи Хүүхдийн эрхийн тухай Конвенцийг 1989 онд соёрхон баталснаас хойш даруй 25 жил болжээ. Монгол Улс уг конвенцид 1990 онд нэгдэн орсноор түүнийг хүлээн зөвшөөрсөн дэлхийн 5 дахь орон болсон түүхтэй билээ.

Хүүхэд насыг тодорхойлох нь:

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэгдүгээр заалтад "18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ" хэмээн тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд "Хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад уг хууль үйлчилнэ" хэмээн заасан нь хүүхэд насны тухай Хүүхдийн эрхийн тухай конвенцид нийцүүлэн тодорхойлсон байна.

Хүүхэд бол хүний эрхийн хэм хэмжээний хувьд "эрх эдлэгч" юм. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалахын төлөө эцэг эх, төр, төрийн албан хаагчид болон бусад байгууллага, хувь хүмүүс үүрэг хариуцлага хүлээнэ.

Хүүхдийн эрхийн зарчмууд

Хүүхдийн эрх нь хүний эрхийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг учраас хүүхдийн эрхийг хамгаалахад хүний эрхийн зарчмууд нэгэн адил түгээмэл үйлчилнэ. Тиймээс хүүхдийн эрх дэлхийн хэзээ ч, хаана ч адил, түгээмэл байж, бүх хүүхэд эрхээ ямар нэг ялгаварлалгүйгээр эдлэх, хамгаалуулах, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх эрхтэй юм.

Хүүхдийн эрхийн тухай

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хууль нь Монгол улсад хүүхдийн эрхийг хамгаалах талаарх эрх зүйн хэм хэмжээний цогц бөгөөд үүнд хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн зарчмуудыг тусгасан. Тэдгээр зарчмууд нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (1990)-ийн үзэл санаа, зарчмуудыг тусгасан байх ёстой. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (1990) болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хуульд хүүхдийн эрхийг:

- ХӨГЖИХ ЭРХ
- АМЬДРАХ ЭРХ
- ОРОЛЦООНЫ ЭРХ
- ХАМГААЛУУЛАХ ЭРХ

гэсэн дөрвөн үндсэн агуулгаар авч үздэг. Эрхийн агуулгыг хүүхдийн эрхийн талаарх бусад олон улсын гэрээ, конвенц болон үндэсний хууль тогтоомжид заасан байдлаар дэлгэрүүлэн авч үзье.

Хүүхэд эсэн мэнд амьдрах эрхтэй

- Амьд явах, амьдрах зайлшгүй эрхээ хүлээн зөвшөөрүүлэх;
- Төрмөгцөө бүртгэлд хамрагдах, нэр авах, иргэний харьяалалтай болох;
- Эцэг эхтэйгээ амьдрах, тэдний хайр энхрийлэл, анхаарал халамжид байх;
- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт гадаадад цагаачлах, дүрвэх, байнга амьдрах, эх орондоо эргэн ирэх;
- Эрүүл, аюулгүй орчинд амьдрах;
- Төрөөс эмнэлгийн тусламж авах, тэтгэвэр тэтгэмж, асрамж, халамж хүртэх эрхтэй.

Хүүхэд хөгжих эрхтэй

- Сурч боловсрох;
- Төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших;
- Оюун ухаан, авьяас билэг, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах;
- Шашин шүтэх, эс шүтэх;
- Чөлөөтэй бодож сэтгэх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх эрхтэй.

Хүүхэд хамгаалуулах эрхтэй

- Хүүхдийг гэр бүл, эцэг, эхээс нь хууль бусаар салгаж үл болно;
- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч эрхийг нь зөрчсөн тохиолдолд хүүхэд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу зогсоох, таслах, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг харилцаагаа сэргээх;
- Хувийн болон захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлаа хамгаалуулах эрх.

Хүүхэд нийгмийн амьдралд оролцох эрхтэй

- Хүүхэд нас, биеийнхээ онцлог, эрүүл мэндэд тохирсон тоглоом, наадам, соёл урлаг, биеийн тамир, аялал жуулчлалын арга хэмжээнд оролцох, амрах;
- Хүүхдийн олон нийтийн байгууллагад сайн дураараа эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран цуглах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
- Хүүхэд өөрт нь зориулсан сургалт, эмчилгээ, асрамж, сувилал, бусад үйлчилгээнд үнэлэлт өгөх, энэ талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
- Хүүхэд өөрийн бүтээсэн оюуны үнэт зүйлийг өмчлөх эрхтэй;

- Хүүхэд өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх эрхтэй.

Хүүхэд гомдол гаргах эрхтэй

Хүүхэд бие махбод, сэтгэл санааны хувьд бүрэн хөгжөөгүй, томчуудаас бүх талаар хараат, эмзэг, тусгай хамгаалалт шаардлагатай байдаг учраас эрх нь зөрчигдөх эрсдэл өндөр байдаг.

Тийм ч учраас хүүхэд бүр эрх нь зөрчигдөж байна гэж үзвэл энэ талаарх гомдлоо гаргах эрхтэй. Харин гомдол хүлээн авсан этгээд нь хүүхдийн ашиг сонирхолыг эн тэргүүнд анхаарч, түргэн шуурхай тусламж, үйлчилгээ үзүүлэх ёстой байдаг.

Хүүхэд юуны талаар гомдол гаргаж болох вэ?

Өөрт тулгараад байгаа бүхий л асуудлаар хандаж болно. Жишээ нь:

- Асран хамгаалагч болон хамтран амьдарч буй хүмүүсийнхээ өөртэй нь таагүй харьцдаг талаар;
- Авах ёстой халамж, үйлчилгээгээ авч чадахгүй байвал;
- Хүүхэдтэй холбоотой аливаа шийдвэр гаргахдаа саналыг нь сонсохгүй, тоохгүй байвал;
- Хүнд хүчир ажил хийлгэж байвал;
- Элдвээр шоолж, доромжилж нэр төрд нь халдаж байвал гэх мэт.

Гомдол гаргахдаа анхаарах зүйлс

Хүүхэд гомдлоо хэд хэдэн хэлбэрээр гаргаж болно. Үүнд:

- Амаар;
- Бичгээр;

- Утсаар;
- Цахим шуудангаар.

Бичгээр гаргаж буй гомдол нь дараах загвараар бичигдсэн байвал зохино.

- Хаана, хэнд хандаж байгаа тухай;
- Он, сар, өдөр;
- Гомдол гаргачийн нэр;
- Гомдол гаргах болсон шалтгаан, хүссэн зүйлийн утга;
- Гомдол гаргагчийн хаяг, овог нэр, эргэж холбоо барих утас.

Хүүхдийн эрхийг хамгаалахын тулд ХЭҮК, хүүхдийн эрхийн бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран юу хийх вэ?

- Хүүхдийн эрхийн асуудлаар судалгаа явуулж, мэдээллээр хангах;
- Хүүхдийн эрхийн боловсролын үйл ажиллагааг дэмжих;
- Хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүүхдийн эрхийн зарчмуудад нийцэж байгаа талаар санал, зөвлөмж, шаардлага гаргах;
- Хүүхдийн эрх зөрчигдсөн тухай гомдол хүлээн авч шалгаж шийдвэрлэх;
- Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах;
- Хүүхдийн эрхийн асуудлаар зөвлөгөө өгөх, эвлэрүүлэх, зуучлах.



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Эмэгтэйчүүдийн эрх нь эмэгтэйчүүдэд шууд болон шууд бусаар хамаарах хүний эдлэх ёстой хуульчилсан эрхүүдийг хамааруулсан ойлголт. Үүнд:

- Ялгаварлан гадуурхалт ба хүчирхийллээс ангид байх;
- нөхөн үржихүйн эрх, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн амьдралд эрэгтэйчүүдийн адил тэгш оролцох;
- үр шимээс тэгш хүртэх.

гэх мэт эмэгтэйчүүдэд шууд хамаарах эрхээс гадна хөдөлмөрлөх, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг хүний бүх эрхүүд хамаарна.

Яагаад эмэгтэйчүүдийн эрхийг бусад хүний эрхээс онцгойлон авч үзэж, тусгайлан баталгаажуулах шаардлагатай бэ?

Эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийн баталгааг эрэгтэйчүүдийн адил төвшинд хүргэх, эмэгтэйчүүдийн бие махбод, физиологийн ялгааг хүлээн зөршөөрч, хүйсийн нь хувьд дорд үзэх, ялгаварлан гадуурхахгүй байх зорилгоор Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцид³⁸ /цаашид ЭЯГБХУТК гэх/ эмэгтэйчүүдийн хүний эрхийн асуудлыг иж бүрэн, цогц байдлаар төрөлжүүлэн баталгаажуулсан.

Тус конвенцид эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурах явдлыг устгах талаар авч хэрэгжүүлбэл зохих бодлогын арга хэмжээ, тэгш байдлыг хангахын тулд авах тусгай болон

³⁸ НҮБ-ын Ерөнхий Ассемблей 1979 оны 12-р сарын 8-нд Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц /ЭАБХУТК/ баталсан. Монгол Улс 1981 онд нэгдэн орсон.

түр арга хэмжээ, жендэрийн үүрэг болон хэвшмэл ойлголт, эмэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдрал дахь оролцоо, хөдөөгийн эмэгтэйчүүд, хуулийн өмнө тэгш байх зэрэг эмэгтэйчүүдэд хамаарах олон асуудлыг тусгасан байдаг.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах гэж юуг хэлэх бэ?

"Ялгаварлан гадуурхалт" гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ³⁹.

Ялгаварлан гадуурхалт нь шууд ба шууд бусаар илэрдэг.

"Шууд ялгаварлан гадуурхалт гэж" гэж бусдыг хүйсээр ялгаварлаж адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон үйлдлийг ойлгоно⁴⁰.

Тухайлбал: Эмэгтэй гэдгээр илтээр шударга бус, ялгавартай хандаж ажилд авахаас татгалзахыг хэлнэ. "Шууд бус ялгаварлан гадуурхалтад" гэж хүйсэд хамааралгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг хэлдэг⁴¹.

Өөрөөр хэлбэл 180 см-ээс дээш өндөртэй, царайлаг хүмүүсийг ажилд авна гэсэн зар нь эмэгтэйчүүдэд тэгш бус хандаж байгаагийн илэрхийлэл юм.

³⁹ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсэгт

⁴⁰ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дэх хэсэгт

⁴¹ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дэх хэсэгт.

Ялгаварлан гадуурхалтанд өртсөн бол хаана хандах бэ?

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхсан бол ТА:

- Үйлдэрчний эвлэлийн болон бусад олон нийтийн байгууллагад гомдол гаргаж болно.

Мөн Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах бүрэн боломжтой. Комисс таны гомдлыг Монгол Улсын Хүний эрхийн Комиссын хуулиар олгосон бүрэн эрхийнхээ дагуу шийдвэрлэнэ.

ЭЯГБХУТК-д баталгаажуулсан эрхийг тухайн улс зөрчсөн бол гомдлыг ЭЯГБХУК-ын Хороонд гаргаж болно⁴².

Өөрөөр хэлбэл:

- Засгийн газрын бүх түвшин, салбарт ЭЯГБХУТК-ыг зөрчиж байвал

ЭСВЭЛ

- Аливаа хувь этгээдүүдийн зүгээс эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахгүй байх явдлыг Засгийн газар хангах үүргээ биелүүлэхгүй бол та тус хороонд хандаж болно. Жишээлбэл: Хэрэв Монгол Улсын -ын Засгийн газар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гомдлыг шалгах, холбогдох этгээдийг шийтгэх, эрхийг сэргээлгэх үүргээ биелүүлээгүй бол энэ нь ЭЯГБХУТК-ын зөрчил юм.

⁴² НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1999 оны 10 дугаар сарын 6-ны өдөр ЭЯГБХУТК-ын Нэмэлт Протоколыг баталжээ.

• 2000 оны 12 дугаар сарын 22-ны өдөр ЭЯГБХУТК-ын Нэмэлт Протокол хүчин төгөлдөр болсон.

• 2002 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Монгол улс соёрхон баталсан.

Гомдолд тавих шаардлага:

- Гомдлоо бичгээр гаргах, НҮБ-ын 6 хэлний аль нэг хэл дээр бичих;
- ЭЯГБХУТК болон нэмэлт протоколын аль нэг зүйл заалтыг засгийн газар нь зөрчсөн байх;
- Хохирогч эрхээ сэргээлгэх талаар дотоодын бүх л механизмд хандсан байх;
- Хохирогч ЭЯГБХУК-ын Хороонд урьд өмнө нь гомдол гаргаагүй байх;
- Холбогдох баримтуудыг хавсаргасан байх шаардлагыг хангасан байх;
- Тухайн улс уг гэрээнд нэгдэн орсон буюу гэрээг соёрхон баталсан байх;

Гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх үе шат

Нэг: Өргөдөл гомдлыг хүргүүлэх

ЭЯГБХУТК-д заасан эрхийг гишүүн улс зөрчсөн гэх өргөдөл гомдлыг хувь хүн /хохирогч өөрөө/, бүлэг хүмүүс/ хохирогчид/ аль эсвэл тэдний өмнөөс төлөөлөх эрх бүхий этгээд гаргаж хүргүүлнэ.

Хоёр: Өргөдөл гомдлыг бүртгэх

Хорооны ажлын алба таны гомдлыг хүлээн авч гомдолд байх дээрх шалгуурыг хангасан эсэхийг шалгаж гомдлыг бүртгэж авна.

Гурав: Шаардлагатай түр арга хэмжээ авах хүсэлт (заавал биш)

ЭЯГБХУТК-ын Хороо эцсийн шийдвэрээ гаргахаас өмнө хохирогчид учирч болзошгүй ноцтой хор хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү түр арга хэмжээ авахыг тухайн гишүүн улсаас хүсч болно. Тухайлбал Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь насанд учирч болзошгүй аюулаас хамгаалах арга хэмжээ авахыг хүсэх гэх мэт.

Дөрөв: Гомдлын агуулгын талаарх шийдвэр гаргах

Хэрэв гомдол нь хүлээн авах шалгуурт нийцэж байвал Хороо нь тухайн гишүүн улс ЭЯГБХУТК-ын дагуу үүргээ зөрчсөн эсэхийг хаалттай хуралдаанаар авч хэлэлцэж, зөрчлийг улс хэрхэн арилгах талаарх санал зөвлөмж гаргадаг. Харин тухайн хэргийг шалгаад ямар нэг эрх зөрчсөн асуудал байхгүй буюу уг гомдол хүлээн авах шалгуур хангаагүй гэж шийдвэр гарвал уг шийдвэрийг гомдол гаргагч болон тухайн улсад хүргүүлсэнээр маргаан эцэс болно.

Тав: Хэрэгжүүлэх болон цаашид авах арга хэмжээ

- Хорооноос өгсөн санал зөвлөмжийг хэрэгжүүлэх нь тухайн гишүүн улсын үүрэг юм.
- Тухайн улс нь санал зөвлөмжийг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээний талаарх албан захидлыг 6 сарын дотор хүргүүлэх ёстой.
- Хороо нь гаргасан санал зөвлөмжөө эргэн харж, цаашид арга хэмжээ авах эсэхээ шийддэг.

ЭЯГБХУТК-ын Хороонд хандсаны ач холбогдол:

- ЭЯГБХУТК-ыг зөрчсөн тохиолдолд зөрчигдсөн эрхийг нь сэргээнэ.
- Засгийн газрын хариуцлагыг сайжруулна.
- Тухайн асуудалд олон улсын анхаарлыг хандуулна.
- Хуулийн шинэчлэл гэх мэт бүтцийн өөрчлөлтийг бий болгох буюу эмэгтэйчүүдийн хүний эрхийн асуудлаарх хууль ёсыг бэхжүүлнэ.

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ



Хүнийг үндэс, угсаа, хэл, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

Монгол Улсын Үндсэн хууль Арван дөрөвдүгээр зүйл

Бидний жендэр гэж хэрэглэж ирсэн үг нь англи gender үг бөгөөд эртний франц болон латин "төрөл", "анги", "бүлэг" гэсэн утга агуулсан үгнээс гаралтай.

Жендэр

Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ⁴³.

Жендэрийн эрх тэгш байдал

Эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлдэг⁴⁴.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс:

- Ижил хөдөлмөрт адил цалин хөлс авах;
- Сурч боловсрох;

⁴³ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 заалт

⁴⁴ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 заалт

- Өмч эзэмших;
- Орон сууц, ажлын байртай болох;
- Эрүүл мэндээ хамгаалуулах адил нөхцөлөөр хангагдах;
- Эрх мэдлийг тэнцвэржүүлэх нийгмийн баталгаа болдог.

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын эрх тэгш байдал нь хүний эрхийн үндсэн асуудал төдийгүй хүн төвтэй тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлт, урьдач нөхцөл нь болдог.

Жендэрийн хэвшмэл үзэл

Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг хэвшмэл үзэл гэж ойлгодог⁴⁵. Жендэрийн хэвшмэл үзэл, ойлголтыг хүмүүс өөрсдөө дараах байдлаар бий болгодог.

- Хэлц үг, өвөрмөц хэллэг, аман яриа;
- Дуу, шүлэг;
- Кино, драм, ардын урлаг, хошин урлаг;
- Шашин, соёл, зан заншил;
- Боловсрол;
- Хэвлэл мэдээлэл, зар сурталчилгаа.

Жендэрийн хэвшмэл үзэл, ойлголт нь эрх мэдлийн, хөрөнгө нөөцийн, нийгэмд эзлэх байр суурийн ялгавартай байдлыг үүсгэх үндэс болж, улмаар хэн нэгнийг ялгаварлан гадуурхах, хүний эрхийн зөрчлийг бий болгож байдаг.

⁴⁵ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 заалт

Жендэрийн ялгаварлан гадуурхалт

Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл эс үйлдэхгүйг ойлгодог⁴⁶.

Жендэрийн ялгаварлан гадуурхалт нь тэгш бус байдал, ядуурал, ажилгүйдэл, хүчирхийлэл, боловсрол ба ухамсрын доройтол, хариуцлагагүй үйлдлүүд зэрэг сөрөг үр дагаварыг дагуулж улс орны хөгжил, нийгэмд сөргөөр нөлөөлөх суурь болдог.

ЖЕНДЭРИЙН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ НЬ ДАРААХ БАЙДЛААР ИЛЭРЧ БОЛНО

Улс төрийн хүрээнд:

- Улс төрийн нам, үйлдвэрчний ба олон нийтийн бусад байгууллагад гишүүнээр нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох;
- Бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгох сонгогдох эрхээ эдлэхэд.

Эдийн засгийн хүрээнд:

- Аж ахуй нэгж байгуулах, эрхлэх, түүний үр шимийг хүртэх;
- Аливаа өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахад.

Хөдөлмөрийн харилцаанд:

- Ажилд орох, албан тушаалд дэвших;
- Ижил ажилд, адил цалин хөлс тогтоох;

⁴⁶ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 заалт

- Жирэмсэн, хүүхэд асрах хугацаанд ажлаас халах, ажлын байрыг нь хэвээр хадгалахад;
- Ажлын байранд бэлгийн дарамтанд оруулах.

Боловсролын хүрээнд:

- Боловсрол эзэмших, сургалтын зээл, тусламж, тэтгэмж авах;
- Мэргэжил эзэмших, мэргэжилээ дээшлүүлэхэд.

Эрүүл мэндийн хүрээнд:

- Эрүүл мэндээ хамгаалуулах эрхээ ямар нэг ялгаварлан гадуурхалтгүй тэгш эдлэх.

ЖЕНДЭРИЙН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ ГЭЖ ҮЗЭХГҮЙ

- Зөвхөн нэг хүйсийн онцлог хэрэгцээнд зориулсан эрүүл мэнд, боловсролын зэрэг төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх;
- Оюутан, суралцагчдын дотуур байр, эмнэлэг, асрамж, амралт, сувилал, хорих болон түр саатуулах газар, эрүүлжүүлэх байранд хүйсээр нь ялган байрлуулах;
- Аль нэг хүйсийн гишүүнчлэл бүхий олон нийтийн ба төрийн бус байгууллага байгуулах;
- Зөвхөн нэг хүйсийн хүмүүсийг хамруулсан урлаг, спортын арга хэмжээ зохиох;
- Тухайн ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалж ажилд авахдаа зөвхөн нэг хүйсийн хүнийг сонгох.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхгүйг жендэрт суурилсан хүчирхийлэл хэлнэ.

Хүчирхийллийн илрэх хэлбэрүүд:

- Гэр бүлийн хүчирхийлэл;
- Ажлын байрны бэлгийн дарамт;
- Бэлгийн хүчирхийлэл;
- Хүн худалдаалах гэмт хэрэг;
- Хүчээр биеийг нь үнэлүүлэх;
- Хүчээр гэрлүүлэх гм.

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ ҮҮРЭГ ХҮЛЭЭГСЭД

- Улсын Их Хурал;
- Засгийн газар;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга;
- Жендэрийн Үндэсний Хороо;
- Төрийн Албаны Зөвлөл;
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс⁴⁷;
- Үйлдвэрчний эвлэлийн хороо;
- Олон нийтийн байгууллага;
- Ажил олгогч;
- Иргэн.

⁴⁷ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан жендэрийн эрх тэгш байдлын тухай заалтын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих, эдгээр хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлнэ.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ЭРХ

Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.

(Монгол Улсын Үндсэн Хуулийн арван дөрөвдүгээр зүйлийн 2 дах заалт)

Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ?

Олон улсад хүний хөгжлийн бэрхшээлтэй байдлыг бие эрхтний согог /impairment/, чадвар алдалт /disability/, хандикап /handicap/ гэсэн үе шатуудад хувааж үздэг.

- Бие эрхтний согог гэдэг нь хүний биеийн анатомийн бүтэц ба физиологи, сэтгэл зүйн үйл ажиллагаа алдагдах, эсвэл хэвийн бус байхыг хэлнэ. Ийм байдал нь байнгын буюу түр зуурын шинжтэй байж болно.
- Чадвар алдалт гэдэг нь бие эрхтний согогийн улмаас хүний хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан байхыг хэлдэг.
- Бие эрхтний согог болон чадвар алдалтынхаа улмаас нийгмийн бүхий л амьдралд оролцох бололцоо алдагдсан байдлыг хандикап гэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэнийг хэлэх вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь орчны бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг хэрхэн тогтоох вэ?

16 нас хүрээгүй хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг оршин суугаа аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комисс тогтооно.

16 болон түүнээс дээш насанд хүрсэн иргэнийг хөгжлийн бэрхшээлтэй болохыг нь оршин суугаа аймаг, дүүргийнх нь эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн Засаг даргын тамгын газар бүртгэж, үнэмлэх олгох бөгөөд энэхүү үнэмлэхээр төрөөс үзүүлж буй хуульд заасан нийгмийн халамж, тусламж, хөнгөлөлт болон бусад үйлчилгээнд хамрагдах эрхтэй болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ямар эрх эдлэх вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, соёлын бүхий л эрхийг ямар нэг ялгаварлалгүйгээр эдлэх эрхтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц /2006 он/-д хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр эдлэх эрхийг баталгаажуулсан байдаг. Үүнд:

- Амьд явах эрх;
- Хуулийн өмнө тэгш байх эрх;
- Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрх;
- Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх;
- Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхээс ангид байх эрх;
- Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх чөлөө;

- Хувийн нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх эрх;
- Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх;
- Бие даан амьдрах болон оршин суугаа орчиндоо байх эрх;
- Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө;
- Хувийн нууцаа хүндэтгүүлэх эрх;
- Орон гэр, гэр бүлээ хүндэтгүүлэх эрх;
- Сурч боловсрох эрх;
- Эрүүл мэндээ хамгаалуулах эрх;
- Сэргээлт, нөхөн сэргээх үйлчилгээ хэрэглэх эрх;
- Хөдөлмөрлөх эрх;
- Хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх;
- Улс төр, нийгмийн амьдралд оролцох эрх;
- Соёлын амьдралд оролцох эрх.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь нийгмийн халамж, хамгааллын ямар төрлийн үйлчилгээнд хамрагдах эрхтэй вэ?

- Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж авах;
- Нийгмийн халамжийн тэтгэвэр авах;
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж авах;
- Тусламж, хөнгөлөлт эдлэх;
- Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах;
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдах;
- Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах;
- Боловсрол, соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдах.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс ямар тусламж, хөнгөлөлт үзүүлдэг вэ?

1. Бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;
2. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох;
3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;
4. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх эсхүл автобусаар үйлчлэх;
6. Дотоодын рашаан, сувилалд асруулах, сувилуулах шаардлагатай дараах этгээдэд нэг талын унааны болон эрхийн бичгийн үнийн зардлыг дор дурдсан хувиар жилд нэг удаа нөхөн олгох:

- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь;
 - хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрамжилж яваа нэг иргэнд 50 хувь;
 - үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50 хувь.
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дотоодын рашаан, сувилалд дараалал харгазахгүйгээр сувилуулах;
 8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;
 9. Насанд хүрсэн бүрэн хараагүй иргэний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;
 10. Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;
 11. Хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх
 12. Бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчих шаардлагатай болвол ирж буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;
 13. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгох;
 14. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй

ганц бие иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгох;

15. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн тохиолдолд түүний оролцсон тэмцээний давтамжийн хугацаанд ногдох тэтгэвэртэй нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тусламж олгох;
16. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх сэргээн засах үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх;
17. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар усан эмчилгээ хийлгэхээр бол эмчилгээний зардлын 70 хувийг нөхөн олгох;
18. Иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй зорчино;
19. Худалдаа, тээвэр, холбоо, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэргүүн ээлжинд үйлчилнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсрол

Сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэн бусадтай адил тэгш, ямар нэг алагчлалгүйгээр, бүх шатны боловсрол, мэргэжил эзэмших эрхтэй.

Боловсролын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг элсүүлэх хөнгөлөлтэй нөхцөл бүрдүүлж, тэнцсэн тохиолдолд тухайн иргэний, түүнчлэн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг сурагч буюу оюутны сургалтын зардлыг төрийн сан хариуцана.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургахаар "...хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд цэцэрлэгийн нэг бүлэгт байж болно" гэж зохицуулсан.

Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгцээт боловсрололгохясли, цэцэрлэг, бүхшатны сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд үнэ төлбөргүй хамрагдахыг төрөөс дэмжинэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажил, хөдөлмөр эрхлэлт

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулахаар зохицуулсан.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар богиносгож болох бөгөөд хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд цалин хөлс авч байгаа гэсэн шалтгаанаар нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын аливаа тэтгэвэр, тэтгэмжийг нь зогсоохыг хориглоно.

Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг авч ажиллуулаагүй тохиолдолд төлбөрийг сар бүр улсын төсөвт Засгийн газрын тогтоолын дагуу ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээг тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож тогтоодог. Харин аж ахуйн нэгж, байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас халах, сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд ажил, албан тушаалд авахаас татгалзахыг хориглоно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нөхцөл нь харшлахгүй тохиолдолд ажилд авахаас татгалзсан бол ямар хариуцлага ноогдуулах вэ?

Хөдөлмөрийн тухай хууль /1999 он/-ийн 141 дүгээр зүйлийн 141.1.4 дэх хэсэгт "Тахир дутуу болон одой хүний биеийн байдал нь хөдөлмөр эрхлэхэд саад болохооргүй буюу хөдөлмөрийн нөхцөл нь харшлахгүй байгаа тохиолдолд уг шалтгаанаартүүнийгажилдавахаастатгалзсаналбантушаалтныг 5000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох шийтгэл шүүгч ноогдуулна."гэж заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн бусдын адил үйлдвэрчний байгууллагад орох, эвлэлдэн нэгдэх эрхтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зөрчигдсөн тохиолдолд хаана хандах вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн та Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн тохиолдолд өөрөө болон хууль есны төлөөлөгч эцэг, эх, асран хамгаалагчаараа дамжуулан Хүний эрхийн Үндэсний Комисс болон холбогдох төрийн байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудад хандаж болно.



ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХИЙН ЭРХ

Үндэстний цөөнх гэж хэнийг хэлэх вэ?

Үндэстний цөөнхийн талаар бүрэн нэгдсэн тодорхойлолт хүний эрхийн хамт олны хувьд байхгүй боловч төр болон бусад оролцогч талууд, тухайн улсын олонх анхаарч харгалзан авч үзэх ёстой онцлог шинжүүд бий. Үүнийг тоймловол:

- Угсаатны зүй;
- Газар нутаг;
- Хэл соёл;
- Ёс заншил;
- Шашин шүтлэг.

Үндэстний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох, хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах, өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзэл бүхий олонхоосоо ялгаатай бүлэг хүмүүсийг хэлнэ.

Монгол Улсын хувьд дээрх тодорхойлолтын дагуу үндэстний цөөнх хэмээх ойлголт нь голчлон Казах, Уйгур угсааны Духа иргэдийг хамарна. 1992 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас батласан Үндэсний Цөөнхөд хамаарах хүмүүсийн эрхийн тухай Тунхаглалд үндэстний цөөнхийн эрхийг хангахад төр дараах үүрэгтэй оролцоно. Төр аливаа бодлого шийдвэр гаргахдаа үндэстний цөөнхийн дээрх онцлогийг харгалзан үзэж байх шаардлагатай.

Төрийн үүрэг:

1. Үндэстний цөөнхийн гишүүдэд соёл, шашин шүтлэг, уламжлал, зан заншлаа сахин хамгаалах, хөгжүүлэх, дэлгэрүүлэх таатай орчныг бүрдүүлэх;
2. Үндэстний цөөнхөд эх хэлээрээ сурах, боловсрол эзэмших, өөрийгөө хөгжүүлэх зохистой боломж, нөхцөл олгох;
3. Өөрийн нутаг дэвсгэрт байгаа цөөнхийн түүх, уламжлал, хэл, соёлын тухай мэдлэг ойлголтыг дэлгэрүүлэх, цөөнхөд хамаарах хүмүүс нийгмийн тухай мэдлэг ойлголт олох баталгааг хангах;
4. Эдийн засгийн ахиц дэвшил, хөгжилд оролцох боломж олгох;
5. Үндэстний цөөнхийг төрийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргах болон нутгийн өөрөө удирдах түвшинд оролцуулах, хөгжлийн төсөл, хөтөлбөр боловсруулах, төлөвлөж, хэрэгжүүлэхэд цөөнхийн оролцоог хангах, хууль ёсны ашиг сонирхлыг нь харгалзан үзэх;

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үндэсний Цөөнхөд хамаарах хүмүүсийн эрхийн тухай Тунхаглалд үндэсний цөөнхийн эрхийг дараах байдлаар томъёолжээ.

Үүнд:

Үндэстний цөөнхийн эрх:

1. Үндэстний онцлог, уламжлал, зан заншил, шашин шүтлэг, соёлоо дагах, сахих, хадгалах, хамгаалуулах, хөгжүүлэх. Энэ бол тухайн үндэстний цөөнх хүн амын олонхийн дунд өөрсдийн түүх уламжлал, шашин шүтлэгээ мартаж, соёлын ялгаа, онцлогийг алдан уусахгүйгээр сахин хамгаалах боломж олгоход чиглэсэн эрх юм.
2. Эх хэлээрээ хорио цээргүйгээр өөр хоорондоо болон олон нийтийн дунд харилцах, түүнийгээ төрийн түвшинд хүлээн

зөвшөөрүүлэх, хэл соёлоо уламжлах, хадгалах, хамгаалах. Энд үндэстний цөөнхөд хамаардаг хүн өөрийн эх хэлээр харилцсанахаа төлөө бусдын ялгаварлан гадуурхалт, сөрөг хандлагад өртөхгүй байх баталгааг хангаж байна. Эх хэлээ дуртай үедээ хэрэглэдэг байх нь уламжлалт хэл соёлоо мартахгүй байх нэг үндэс болдогийн хувьд бусад эрхийн урьдач нөхцөл болох нь ч бий.

3. Нийгэм, соёл, улс төр эдийн засгийн харилцаа, шашны зан үйлд оролцох эрх. Энэ эрх баталгаажсаны үндсэнд үндэстний цөөнх нь нийгмийн аливаа харилцаанд оролцохдоо ялгаварлан гадуурхалтаас ангид байх, нийгэмд эрх тэгш байр суурьтай байх боломжтой байна.
4. Өөрсдийн ахуй амьдралд үндэсний болон бүс нутгийн түвшинд нөлөөлөх шийдвэр гаргахад санал бодлоо илэрхийлж, оролцоо, хувь нэмрээ оруулах. Энэ нь өдөр тутмын амьдралд нь нөлөөлж, ахуй амьдралд нь өөрчлөлт авчрах төрийн бодлого боловсруулах, эрх бүхий этгээдийн шийдвэр гаргах явцад оролцох эрх юм.
5. Эвлэлдэн нэгдэж, холбоо байгуулах эрх. Үндэстний цөөнхийн гишүүд угсаатны зүй, газар зүй, хэл соёл, шашин шүтлэг зэрэг өвөрмөц онцлогоо хадгалан хамгаалах болон бусад эрхээ хамгаалахын тулд эвлэлдэн нэгдэх эрхтэй юм.
6. Дотооддоо болон хилийн чанадад байгаа үндэс угсаа нэгтнүүдтэйгээ холбоо тогтоох, харилцах эрх. Эндээс аль нэг улсын үндэстний цөөнх өөрсдийн оршин суугаа газар орон болон хилийн чанадад байгаа гарал угсаа нэгтэнтэйгээ ямар нэг хориггүйгээр, харилцаа холбооны боломжит хэлбэрээр харилцах эрхийг баталгаажуулахад оршино.

ХОХИРОГЧИЙН ЭРХ



Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгайлан заагдсан нийгэмд аюултай гэмт хэргийн улмаас:

- амь нас;
- нэр төр;
- алдар хүнд;
- санаа сэтгэл;
- бие эрхтэн;
- эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэдэг.

Хохирогч нь:

- Насанд хүрсэн, хүрээгүй;
- Хэрэг хариуцах чадвартай, чадваргүй;
- Эрэгтэй, эмэгтэй;
- Аль ч улсын иргэн хэн ч байж болно.

Хэрвээ аливаа нэг гэмт хэргийн улмаас тухайн хэргийн хохирогч нас барсан бол, эсхүл өөрийн үйлдлийг ухамсрлан өөрийн эрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон бол тухайн хохирогчийн гэр бүлийн гишүүний хэн нэг нь тухайлбал хохирогчийн эцэг эх, ах дүү, эхнэр, нөхөр, төрсөн болон дагавар хүүхдийн аль нэг, эсвэл төрөл садных нь хүнийг хохирогчоор тооцож тогтоол гаргаж тухайн ажиллагаанд оролцуулж, тэрээр хохирогчийн эрх үүргийг нэгэн адил эдэлнэ.

Та эрх үүргээ сайтар ойлгож мэдэх нь гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх, гэмт этгээдэд зохих ял шийтгэлийг оноох, өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, өөрийгөө хамгаалуулах гол хүчин зүйл болно гэдгийг анхаарвал зохино.

Хэрэв та дээрхи байдлаар гэмт хэргийн улмаас хохирсон бол таныг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гарган хохирогчоор тогтооно. Үүний дараа та эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч субъект болж дараах эрхүүдийг эдэлнэ.

Нэг. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд

- Хэргийн талаар нотлох баримт гарган өгөх;
- Нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;
- Эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг дууссаны дараа хавтаст хэргийн бүх материалтай танилцах;
- Өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо өмгөөлүүлэхээр өмгөөлөгч сонгон авах;
- Хэргийн талаар чухал мэдээлэл өгнө гэж үзсэн аливаа этгээдийг гэрчээр асуулгах, шинжээч томилж, дүгнэлт гаргуулах тухай хүсэлт гаргах.

Хоёр. Прокурорын хяналт, шүүхийн шатанд

- Нэмэлт нотлох баримт шалгуулахаар хүсэлт гарган шалгуулах;
- Өөрийн хууль ёсны ашиг сонирхлыг өмгөөлүүлэхээр өмгөөлөгч авах, өөрөө өөрийгөө өмгөөлөх;
- Гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хүсэлт гарган, нотлох баримт цуглуулан өгөх;
- Эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
- Хэргийн шүүгдэгч, шинжээчид болон гэрч нарт асуулт тавих;
- Цагаатгах буюу шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж

- заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах;
- Шүүхийн шийдвэрт прокурор, шүүгдэгчийн өмгөөлөгч нараас гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцаж тайлбар гаргах;
 - Шүүх хуралдааны явцад шүүгч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргах.

Гурав. Өмгөөлөгчөөр сонгох, эрх зүйн туслалцаа авах эрх

Таныг эрүүгийн хэргийн хохирогчоор тогтоосон тухай тогтоол гарсны дараанаас эхлээд та эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцохдоо өөрийн хууль ёсны эрх ашгийг өмгөөлүүлэхээр өмгөөлөгч авах эрхтэй.

- Өмгөөлөгчөө өөрөө сонгон авах /Нэг буюу хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болно./
- Өмгөөлөгчөөсөө байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд татгалзах, өөр өмгөөлөгчийг сонгон авах эрхтэй.

Хэрвээ та өөрийнхөө эрх ашгийг хамгаалуулахаар өмгөөлөгч сонгон аваагүй бол таны хүсэлтийг харгалзан байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хангах бөгөөд харин танд өмгөөлөгчөө сонгоход тань тодорхой ямар нэгэн хүний нэрийг тулган зааж болохгүй гэдгийг та мэдэх хэрэгтэй.

Хэрвээ таны өөрийн чинь сонгон авсан өмгөөлөгч уг хэрэгт ямар нэгэн байдлаар оролцох боломжгүй болсон, эсхүл та өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөсөө сайн дураараа татгалзсан тохиолдолд өөр өмгөөлөгчийг сонгон авах эрх тань нээлттэй байна.

Та өмгөөллийн хөлс төлөх төлбөрийн чадваргүй, амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой бол оршин суугаа газрынхаа баг, хорооны засаг даргаас тодорхойлолт авч Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд албан ёсоор хандах хэрэгтэй.

Дөрөв. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах хохирогчийн эрх

Та эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хууль ёсны эрх ашиг, сонирхлоо зөрчигдсөн гэж үзвэл гомдол гаргах эрхтэй.

Та гомдлоо бичгээр болон амаар гаргаж болно

Энэ хоёр хэлбэрийн аль нэгээр гаргасан гомдлоо та уг гомдлыг хянан үзэж, шийдвэр гаргах эрх бүхий байгууллага болох хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга болон харьяа дүүргийн, нийслэлийн болон Улсын Ерөнхий Прокурорын газарт хандан гаргана. Хугацааны хувьд байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд гомдол гаргах таны эрх нээлттэй байх болно.

- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргавал уг гомдлыг тухайн хэрэг бүртгэх болон мөрдөн байцаах албадын удирдлага, цагдаагийн ерөнхий газрын хяналт шалгалт дотоод аудитийн хэлтэс болон прокурорт;
- Прокурорын үйл ажиллагаа болон шийдвэрийн тухай гомдлыг дээд шатны прокурорт;
- Шүүгч дангаараа гаргасан шийдвэрийн талаарх гомдлыг тухайн шүүхийн ерөнхий шүүгчид, харин шүүх бүрэлдхүүнээрээ гаргасан шийдвэрийн талаар дээд шатны

шүүх, мөн шүүгчийн ёс зүйн хороонд хандаж гомдлоо гарган шийдвэрлүүлэх эрхтэй.

Аюулгүй байдлаа хамгаалуулах эрх

Хэрэв тухайн гэмт хэргийн сэжигтэн яллагдагч болон түүний ар гэрийн зүгээс таны амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул занал хийсэн, хийхээр завдсан нөхцөл байдал тогтоогдсон тохиолд та Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу өөрийн амь нас эд хөрөнгийг хамгаалуулахаар хүсэлт гаргаж хуулийн дагуу хамгаалалт авах эрхтэй.



ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧДЫН ЭРХ

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь сэжигтний эрх

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, дор дурдсан этгээдийг сэжигтнээр тооцно.

- Гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан;
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан;
- Уг этгээдийн бие, хувцас, эд зүйлс, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон;
- Уг этгээд хэргээ илчлэн ирсэн;
- Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол.

Сэжигтний эрх

- Ямар хэрэгт сэрдэгдэж байгаагаа мэдэх;
- Өөртэй нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэсэн, баривчилсан буюу таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах;
- Баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;
- Мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах;
- Эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

- Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах;
- Өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр байцаан шийтгэх ажиллагаанд оролцох;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх.

Сэжигтэн өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэгт холбогдолгүйгээ болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ямар хэрэгт сэрдэгдэж байгааг сэжигтэнд тэр даруй, түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгчид нь 48 цагийн дотор мэдэгдэнэ. Хэдийгээр сэжигтнээр тооцогдсон боловч хуулийн дагуу гэм буруутай нь тогтоогдох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй. Өөрөөр хэлбэл тухайн үйлдэлд ТАНЫГ гэм буруутайд тооцсон шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох хүртэл ТА гэм буруугүй.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь яллагдагчийн эрх

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг яллагдагч гэнэ.

Шүүхэд шилжсэн яллагдагчийг шүүгдэгч, шийтгэх тогтоол гарсан бол ялтан гэж тус тус нэрлэнэ. Тиймээс шүүгдэгч нь яллагдагчийн эрхийг нэгэн адил эдэлнэ.

Яллагдагчийн эрх

- Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх;
- Яллагдагчаар татсан болон таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах;
- Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах;
- Өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах;
- Сонгосон ялын талаар бичгээр болон амаар тайлбар гаргах;
- Мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах;
- Баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;
- Өөрт холбогдсон хэргийн материалтай танилцах;
- Шүүх хуралдаанд оролцох;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн ажиллагаанд гомдол гаргах;
- Шинжээч томилсон тогтоол болон шинжээчийн дүгнэлттэй танилцах;
- Эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр өөрийн болон өмгөөлөгч, төлөөлөгчийнхөө хүсэлтээр хийлгэж байгаа байцаан шийтгэх тодорхой ажиллагаанд оролцох, уг ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах тухай хүсэлт гаргах;
- Шүүх хуралдаанд эцсийн үг хэлэх;
- Шүүхийн шийдвэрт гомдол гаргах;
- Бусад этгээдээс шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцах, түүнд тайлбар өгөх;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн

хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх.

Яллагдагч нь өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, түүнчлэн өөрийн гэм буруугүйг болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй.

Яллагдагчаар татагдсан ч тухайн үйлдэлд ТАНЫГ гэм буруутайд тооцсон шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох хүртэл ТА гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хохирогчийн эрх

Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ.

Иргэн, хуулийн этгээдийг хохирогчоор тогтоохдоо хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

Хохирогчийн эрх

- Өмгөөлөгч авах;
- Баримт сэлт гаргаж өгөх;
- Нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;
- Шүүх хуралдаанд оролцох;
- Шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;
- Эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцах;

- Гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;
- Цагаатгах буюу шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах;
- Бусад этгээдээс шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцаж, тайлбар гаргах;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах.

Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, эсхүл эрх зүйн чадамжгүй болсон бол дээрх эрхийг түүний гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүн эдэлнэ.

Хохирогчийн үүрэг

- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн дуудсанаар ирэх;
- Хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх;
- Өөрт илэрхий болсон хэргийн талаарх баримт сэлтийг задруулахгүй байх;
- Шүүх хуралдаан болон байцаан шийтгэх ажиллагааны журмыг сахих.

Хохирогч мэдүүлэг өгөхөөс санаатайгаар татгалзсан, зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 254, 255 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүсэлт гаргах эрх:

Хүсэлт гаргах эрх

Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч нь тодорхой байцаан шийтгэх ажиллагаа явуулах, хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалган тогтоох, түүнчлэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх болон шүүгчид гаргах эрхтэй.

Хүсэлт гаргах журам

Хүсэлтийг байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд гаргаж болох ба тус хүсэлтэд тогтоолгох үйл явдал, явуулах байцаан шийтгэх ажиллагаа, гаргуулах шийдвэрийн талаар тодорхой дурдана. Бичгээр гаргасан хүсэлтийг хэргийн материалд хавсаргах ба хүсэлтийг амаар гаргасан бол байцаалтын болон бусад ажиллагааны тэмдэглэлд заавал тусгана. Хүсэлтийг хангаагүй явдал нь байцаан шийтгэх ажиллагааны тухайн болон өөр үе шатанд тухайн хүсэлтийг дахин гаргах эрхийг хязгаарлахгүй. Өөрөөр хэлбэл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч нь нэг асуудлаар хэдэн ч удаа хүсэлт гаргах эрхтэй байх ба түүнийг эрх бүхий албан тушаалтан заавал хянаж, шийдвэрлэж байх үүрэгтэй.

Хугацаа, шийдвэрлэлт

Хүсэлтийг боломжтой бол шууд, боломжгүй бол түүнийг гаргаснаас нь хойш 5 хоногийн дотор хангах эсхийг шийдвэрлэнэ. Хүсэлт нь хэргийг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор тогтоох, оролцогч болон бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бол хангах ба бусад тохиолдолд хэрэгсэхгүй болгоно. Хүсэлтийг бүрэн болон хэсэгчлэн хангах, эсхүл хангахаас татгалзах тухай үндэслэл бүхий тогтоол, захирамжийг гаргах ба тус шийдвэрт хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болно.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд гомдол гаргах эрх:

Гомдол гаргах эрх

Байцаан шийтгэх ажиллагааны оролцогч, түүнчлэн уг ажиллагааны улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн бол иргэн, хуулийн этгээд нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрхтэй.

Гомдол гаргах журам

Гомдлыг хуульд заасны дагуу хянан үзэж шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана. Гомдлыг амаар буюу бичгээр гаргах ба амаар гаргасан гомдлыг байцаалтын болон бусад ажиллагааны тэмдэглэлд тусгаж, хүлээн авсан албан тушаалтан, гомдол гаргагч гарын үсэг зурна.

Хугацаа, шийдвэрлэлт

Гэмт хэрэгт сэрдэгдэн баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд гомдол гаргасан бол баривчлах болон цагдан хорих байрны захиргаа 24 цагийн дотор хаягаар нь хүргүүлэх үүрэгтэй.

Гомдлыг хүлээн авсан албан тушаалтан 14 хоногийн дотор, нэмэлт материал шалгах буюу бусад арга хэмжээ авах бол ажлын 21 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА ХҮНИЙ ЭРХ



"Хүн бүр нийгмийн гишүүнийхээ хувьд нийгмээс хангамж авах эрхтэй бөгөөд нэр төрөө хамгаалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын талын эрх дархаа тухайн орны хүчин чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны нөөц бололцоонд нийцүүлэн эдлэх эрхтэй"

(Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 22 дугаар зүйл)

Хүн худалдаалах гэмт хэрэг:

Хүнийг мөлжих зорилгоор, хүч хэрэглэхээр заналхийлэх, буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хүнийг хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, тухайн охид, эмэгтэйчүүдийн эмзэг байдлыг нь далимдуулан гэмт хэрэгтээ ашиглах зэрэг аргаар охид, эмэгтэйчүүдийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.

Хүнийг мөлжих зорилго:

Биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харьцаанд хүчээр оруулан мөлжих, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил хэрэглэх, эрх чөлөөгүй байлгах, эд эрхтнийг нь авах зэрэг үйлдлийг ойлгоно. Түүнчлэн, мөлжих зорилгоор охид, эмэгтэйчүүдийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгт гэж үзнэ.

Нийгмийн хүчин зүйлс:

- Охид, эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засгийн доогуур байр суурь;
- Иргэд, олон нийтийн дэмжлэг бага, мэдээллийн сул тогтолцоо;
- Тухайн улсын соёл, практик үйл ажиллагаа;
- Гэр бүл болон нийгэм дэх биеийн болон бэлгийн дарамт шахалт;
- Хүйсийн хувьд ялгаврлан гадуурхах үзэл;
- Үндэстний цөөнх болон нутгийн уугуул хүн амыг ялгаварлан гадуурхах үзэл;
- Нийгмийн эмзэг бүлэгт хамаарагсдын эрх зүйн хамгаалалтын сул байдал;
- Хэвлэл мэдээллийн бодлого, хууль бус зар сурталчилгаа.

Эдийн засгийн хүчин зүйлс:

- Хувь хүний болон гэр бүлийн гишүүдийн бусдад тавьсан өр зээл;
- Ядуу буурай орнуудын нийгмийн ядуу эмзэг бүлгийн доторх хүнс тэжээлийн хомсдол;
- Тухайн бус нутгийн тэгш бус эдийн засгийн хөгжил;
- Байгалийн гамшиг ган гачиг, үер ус, газар хөдлөлтийн үед үүссэн эдийн засгийн хямралт нөхцөл;
- Тухайн улс орны ажилгүйдлийн түвшин их, хүн амын орлого бага;
- Орлогын тэгш бус хуваарилалт.

Улс төр, эрх зүйн орчны хүчин зүйлс:

- Тухайн улс орны дотоодын хууль эрх зүйн тогтолцоо, хуулийн хэрэгжилт;
- Улс орнуудын хамтын ажиллагаа, хилийн шалган нэвтрүүлэх

үйл ажиллагааны шударга байдал, авлигаас ангид байх нөхцөл;

- Цагаач ажилчдын талаарх бодлого, зохицуулалт.

ХҮН ХУДАЛДААЛЖ БОЛОХ ЭД БАРАА, ХЭРЭГСЭЛ БҮТЭЭГДЭХҮҮН БИШ ЮМ

Хүн хил давуулан худалдах гэмт хэргийн эхний шат бол гадаад улсад байгаа хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч этгээдтэй холбоо тогтоож, охид, эмэгтэйчүүдийг гадаадад ажиллуулах гэрээ хэлцэл байгуулах явдал буюу тэднийг элсүүлэх ажиллагаа юм.

Үүний дараа охид эмэгтэйчүүдийг цуглуулах, дамжуулах, гадаадад гарган хүчээр хөдөлмөрлүүлэх, боолчлох, биеийг нь үнэлүүлэх, сексийн бусад зорилгоор ашиглах, хуурамч гэрлэлт, үрчлэлтээр халхавчлан үнэгүй гэрийн зарц хийлгэх, гэмт хэрэг үйлдүүлэх, гуйлга гуйлгуулах, эд эрхтнийг нь худалдаалах зэрэг мөлжлөгийн олон төрөл хэлбэр, үе шат бий.

Хүн худалдаалах гэмт хэрэгт хэн ч өртөхийг үгүйсгэхгүй

Хүн худалдаалагчид нь байнгын ажлын байргүй иргэд, тэр дундаа охид, эмэгтэйчүүдийг гадаадад цалин, орлого ихтэй ажилд, эсвэл гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучилна гэх нэрийдлээр хууран мэхэлж урхиндаа оруулдаг. Түүнчлэн хүүхэд ч уг гэмт хэргийн объект болж болдог. Хүн худалдаалагчид хүүхдийг худалдах, биеийг нь үнэлэх, садар самуунд уруу татах зэрэг гэмт үйлдлээ интернэт болон бусад дэвшилтэт технологи ашиглан гүйцэтгэх явдал сүүлийн үед ихэсч байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг улс дотроо эсхүл гадаад улсад худалддаг. Энэхүү гэмт хэрэгт татагдан орсон улс орнуудыг дотор нь хүлээн авагч, дамжуулагч улс, илгээгч улс хэмээн гурван төрөлд ангилдаг байна.

Хүлээн авагч улсад секс туризм их хэмжээгээр өсч байгаа нь нэг талаар энэ гэмт хэргийг гарах хүчин зүйл болдог.

Дамжуулагч улс нь өөрсдөө хүнээ бэлтгэдэггүй, ихэвчлэн транзит хэлбэрээр дамжин өнгөрүүлдэг. Илгээгч улс нь тусгай арга хэлбэрээр энэ төрлийн гэмт хэргийг нэгдсэн зохион байгуулалттайгаар маш өндөр түвшинд зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд, хувь хүмүүс зохион байгуулдаг.

Бэлгийн мөлжлөг:

Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгт ихэвчлэн өсвөр насны болон нөхөн үржихүйн насны охид, эмэгтэйчүүд өртдөг байна. Ийм төрлийн гэмт хэрэг газар авч байгаа нь нийгэм дэх эмэгтэйчүүдийн тэгш бус статустай шууд холбоотой байдаг.

Боолын хөдөлмөр:

Хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгт эмэгтэйчүүдээс гадна хөдөлмөрийн идэр насны эрэгтэйчүүд их өртдөг гэсэн судалгааг Зүүн өмнөд Азийн орнуудад хийсэн байдаг. Иргэдийн хөдөлмөрийг нь мөлжих зорилгоор дотоодод болон бусад улс орнууд руу өндөр хөлстэй ажлын тухай хуурамч зар сурталчилгаа ашиглаж уг гэмт хэргийг үйлддэг.

Эд эрхтний наймаа:

Дэлхий дээр хүний эд эрхтнийг дамлан худалдаалах бизнес газар авсан учир Дэлхийн эрүүл мэндийн байгууллага амьд хүний эд эрхтнийг донор болгон худалдаалахтай тэмцэхийг уриалж байна. Олон улсын практикаас үзэхэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эд эрхтэнийг нь авч дамлан худалдаалах хуурамч гэрлэлтээр халхавчлах, хүүхдийг гадаадад үрчлүүлэхээр халхавчлах, хүчээр эд эрхтнээ гэрээслэх

гэрээслэл бичүүлэх, эсвэл төрөл садангийн хэн нэгэнтэй үгсэн тохиролцож, хохирогчийн эд эрхтэнийг донор болгох зөвшөөрөл бичгээр гаргуулах гэсэн хэлбэрээр үйлддэг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг тухайн улсын төр хамгаалах үүрэгтэй

"Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай" 1979 оны НҮБ-ын конвенцийг Монгол Улс 1980 онд гарын үсэг зурж, 1981 онд соёрхон баталжээ. Конвенцийн 6 дугаар зүйлд зааснаар оролцогч улсууд эмэгтэйчүүдийг худалдах, тэднийг биеийг нь үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг таслан зогсоохын тулд зохистой бүх арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээ авах үүргийг хүлээсэн байдаг.

Хүн худалдаалах гэмт хэрэг зохион байгуулалттай, улс орнуудыг дамжиж үйлдэгддэг тул үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бие даасан төрөлд хамааруулах болжээ. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр олон улсад Палермогийн конвенц гэж нэрлэгдсэн "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц", мөн уг конвенцийн нэмэлт болох "Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"-ыг баталсан юм. Энэ баримт бичиг нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар хийсэн анхны томоохон алхмын нэг бөгөөд Монгол Улс 2008 оны 5 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсон.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"

-д Монгол Улс 2008 оны 5 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсон. Тус протоколд оролцогч улсууд нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах үүргийг хүлээдэг. Үүнд:

- Эрүүгийн шинжээр нь гэмт хэргийг үйлдэхийг завдах, гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцох, гэмт хэргийг үйлдэх зорилгоор бусад этгээдийг зохион байгуулах буюу удирдах үйлдийг эрүүгийн гэмт хэрэгт тооцоход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна;
- Хүн худалдаалах хэргийн хохирогчдын хувийн амьдралыг ба тэдгээрийг бие хүний хувьд, тухайлбал, хүн худалдаалахтай холбогдох хэргийн шүүн таслах ажиллагааг нууц байлгах замаар, дотоодын хууль тогтоомжоор байж болох хэмжээнд хамгаална;
- Хүн хэргээс урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх, хүн худалдаалах хэргийн хохирогчид, ялангуяа эмэгтэйчүүд ба хүүхдүүдийг дахин хэлмэгдэхээс хамгаалах асуудлаар бүрэн цогц бодлого хөтөлбөрүүд болон бусад арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлнэ;
- Хууль сахиулах, цагаачлалын буюу бусад холбогдох байгууллагууд дотоодынхоо хууль тогтоомжийн дагуу зохих тохиолдолд нэг нэгтэйгээ мэдээлэл харилцан солилцох замаар хамран ажиллана;
- Эдгээр байгууллагуудын ажилтнуудад хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх асуудлаар сургалт явуулах буюу эрчимжүүлэх шаардлагатай;
- Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэхэд шаардлагатай байж болох байдлаар хилийн хяналтыг болмжийн хэрээр бэхжүүлнэ.

"Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч"-Тухайн гэмт хэрэгт бүх талаараа хохирсон хүнийг хохирогч гэнэ. Өөрөөр хэлбэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын амьд явах

эрх чөлөөтэй, халдашгүй байх эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, боолчлол эрүү шүүлтээс байх эрх зөрчигдөж, хэрцгий, хүнлэг бус харилцааны золиос болдог.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид дараах чиглэлээр туслалцаа, дэмжлэг үзүүлнэ.

- Зохих орон байраар хангах;
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод ойлгогдох хэлээр, ялангуяа хуулиар тогтоосон эрхийн талаар зөвлөгөө мэдээлэл өгөх;
- Эмнэлгийн, сэтгэл зүйн ба материаллаг туслалцаа үзүүлэх;
- Хөдөлмөрлөх, боловсрол эзэмших болон суралцах болоцоогоор хангах.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой ажиллахдаа дараах зүйлст анхаарна.

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсны шууд нөлөөгөөр үйлдсэн үйлдэл болон хууль бусаар хил зөрчсөн хэргээр хорих, шийтгэхийг цээрлэх;
- Хууль сахиулах байгууллага, ялангуяа хилийн байгууллага улс орныхоо хилийг чандлан сахихаас гадна хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, олон улсын стандартад нийцүүлэн тэдэнтэй зохистой харьцах үүрэгтэй;
- Аливаа этгээд өөрийгөө болон бусдыг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хэмээн мэдүүлсэн тохиолдолд түүнд туслах бүх төрлийн арга хэмжээг авах.

Хууль сахиулах байгууллагын албан хаагч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой зохистой харьцах дараах үндсэн зарчмуудыг мөрдлөг болгоно. Үүнд:

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нь онцгой хүнд гэмт хэргийн хохирогч бөгөөд тэндэнд бололцоотой


бүх төрлийн тусламжийг шуурхай үзүүлэх хэрэгтэй. Хууль сахиулах байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд л тусламж үзүүлнэ гэж болзол тавихгүй байх;

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн ойр дотны хүмүүсийн аюулгүй байдлыг хангах талаар хууль сахиулах байгууллагын албан хаагч нэн түрүүнд анхаарч, арга хэмжээ авах;
- Хэрэг бүрдүүлэх, мөрдөн байцаах бүх үе шатанд хохирогчийн болон түүний ойр дотны хүмүүсийн аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээ авч ажиллах; (хохирогчид туслах байгууллагаас тусламж авах, тэдэнд туслах)
- Хууль сахиулах байгууллагын албан хаагч хохирогчид шударга, илэн далангүй хандаж түүний сайн мэддэг хэлээр тэдний гаргах шийдвэрээс гарч болох үр дүн, үүрэг хариуцлагын талаар тайлбарлаж өгөх үүрэгтэй;
- Хохирогчийн сайн ойлгох хэлээр хохирогчид туслах, төрөл бүрийн туслалцаа үзүүлдэг ямар байгууллага байдаг талаар хэлж, холбоо барихад нь туслах үүрэгтэй.

БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ



Бизнесийн байгууллагуудыг хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих ажилд хамруулахын тулд олон улсын санаачлагатай уялдуулж, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах зэрэг олон төрлийн үйл ажиллагааг явуулах боломжууд байдаг.



Энэхүү баримт бичгүүд нь бизнесийн байгууллагыг эрх зүйн болон санхүүгийн ямар нэг, үүрэг хариуцлага хүлээхгүй, харин тухайн байгууллагын нэр хүндийг өсгөж, хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ДАЯН ДЭЛХИЙН ГЭРЭЭ"-НИЙ 10 ЗАРЧИМ

"Даян дэлхийн гэрээ"-нд нэгдсэн орох санаачлагыг НҮБ-аас 2000 оны 7 дугаар сард эхлүүлсэн. Энэхүү гэрээ нь дараах 10 зарчмаас бүрддэг. Үүнд:

Хүний эрх /Аж ахуйн нэгж/

Зарчим 1. Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах олон улсын тунхаглалыг дэмжин хүндэтгэх;

Зарчим 2. Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчихгүй байх;

Хөдөлмөр эрхлэлт /Бизнес эрхлэгчид сахиж байх ёстой/

Зарчим 3. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг үр ашигтайгаар хүлээн зөвшөөрөх;

Зарчим 4. Хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх аливаа хэлбэрийг арилгах;

Зарчим 5. Хүүхдийн хөдөлмөрийг устгах;

Зарчим 6. Хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн хүрээнд ялгаварлан гадуулах явдлыг арилгах;

Байгаль орчин /Аж ахуйн нэгж/

Зарчим 7. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны өөрчлөлт, доройтлоос урьдчилан сэргийлэх;

Зарчим 8. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах хариуцлагыг өндөржүүлэх;

Зарчим 9. Байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэн нэвтрүүлэх.

Авлига

Зарчим 10. Авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийн эсрэг тууштай үйл ажиллагаа явуулах;

Энэхүү Даян дэлхийн гэрээ нь бизнесийн байгууллагыг тогтвортой, нийгмийн хариуцлагатай бодлого батлах, дэлхий даяар бизнесийг дэмжих, тэдгээрийн хэрэгжилтийн талаар тайлагнах НҮБ-ын санаачилга юм.

"Даян дэлхийн гэрээ"-ний 10 зарчим нь зохицуулалтын арга хэрэгсэл биш бөгөөд харин гэрээнд нэгдэн орсон оролцогч талууд Засгийн газар, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нөлөөлөх, ажиллах боломжийг олгох зорилготой болно.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН “БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХИЙН УДИРДАХ ЗАРЧИМ”

"Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим"-ыг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр баталсан.

Нэгдүгээр зарчим – Хамгаал: Төр зохистой бодлого, зохицуулалтаар дамжуулан хүний эрхийг гуравдагч талууд зөрчихөөс хамгаалах үүрэгтэйг онцолсон.

Хоёрдугаар зарчим – Хүндэл: Бизнесийн байгууллага хүний эрхийг хүндэтгэх үүрэг хамаарах буюу эрсдлийн судалгаа, нөлөөллийн үнэлгээ, хуулийг чанд мөрдөх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх ёстой юм.

Гуравдугаар зарчим – Эрхийг сэргээ: Бизнесийн байгууллагууд иргэдийн гомдол, саналыг хүлээн авч, яриа хэлэлцээрийн зарчмаар шийдвэрлэнэ.

Бизнесийн байгууллага нь бизнесийн орчинд ажиллахдаа хүний эрхийг хангах, хүндэтгэх чиглэлээр дараах үйл ажиллагаагаа явуулах хэрэгтэй. Үүнд:

- Хүний эрхийг хүндэтгэх;
- Хүний эрхийн зөрчил гаргахаас зайлсхийх;
- Байгууллагынхаа үйл ажиллагаатай холбоотойгоор хүний эрхийг зөрчсөн аливаа сөрөг үйлдлийг нэн даруй олж илрүүлэх;
- Хүний эрхийн талаарх бодлого хөтөлбөр боловсруулах;
- Үйл ажиллагаандаа үнэлгээ хийх, үр дүнг удирдлагад танилцуулах, үйл ажиллагааныхаа соёлд нэвтрүүлэх;

Хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг нь төр үүрэг хариуцлага боловч бизнесийн байгууллага үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэснээр бизнесийн цоо шинэ боломжууд бий болохын зэрэгцээ цаашид тохиолдох аливаа эрсдлийг амжилттай даван туулах, урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах үндэс сууриа улам бэхжүүлж чадах болно.



АЖЛЫН БАЙРАН ДАХЬ БЭЛГИЙН ДАРАМТ

Бэлгийн дарамт гэж юу вэ?

ТАНЫГ ХҮСЭЭГҮЙ БАЙХАД:

- Бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлэх;
- Хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулах;
- Бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх;
- Айлган сүрдүүлэх;
- Тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. (Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь хэсэг)

Ажлын байран дахь бэлгийн дарамтын (цаашид АББД гэх) онцлог:

- Албан тушаал, эрх мэдэл бүхий этгээдээс давуу байдлаа ашиглан үйлдэгддэг;
- Хохирогч хүсээгүй буюу зөвшөөрөөгүй байхад зөвхөн нэг талын хүсэл зоригоор илэрхийлэгддэг;
- Ажлын байр, боловсрол, соёлын газар орчинд ихэвчлэн үйлдэгддэг;
- Санаатай, мөн давтагдах шинжтэй;
- Хүлээн авашгүй бэлгийн шинжтэй үйлдлийг аль нэг давуу талаа ашиглан санал болгодог;
- Хүч хэрэглэн тулган шаарддаг.

АББД-нд хэн өртөж болох вэ?

Нас, хүйс, гэр бүлийн байдал, биеийн гадаад төрх, мэргэжлийн байр суурь, чадварыг үл харгалзан ХЭН ч өртөж болдог. Гэвч ажлын байранд эмэгтэйчүүд илүү ихээр өртдөг бөгөөд хохирогч нь бие махбод, сэтгэл санаа, эд материалын хохирлыг давхар амсдаг.

АББД-ын илрэх хэлбэрүүд

- **Үг яриагаар дарамтлах:** эвгүйрхэх, ичээх үг хэлэх, бэлгийн сэдэлттэй санал хүсэлт тавих, дооглох басамжлах, уриалах, тулгах, доромжлох, заналхийлэх, бэлгийн таашаал үзүүлэхийг шахах, шаардах гэх мэт.
- **Үйл хөдлөлөөр:** ширтэх, шалиг харцаар харах, бэлгийн шинжтэй дохио зангаа өгөх, өдсөн зураг, хэвлэмэл хуудас, дүрс үзүүлэх, сүлжээ ашиглан захидал, зурвас илгээх, хормойг нь сөхөх, хувцас, эд зүйлийг урж гэмтээх гэх мэт
- **Бие махбодиор:** биед зохисгүй хүрэх, эмзэг газруудаар илж таалах, базах, чимхэх, бэлэг эрхтнээ хүргэх, биеэр довтлох, бэлгийн харьцаанд орох гэх мэт.

АББД-ыг хэн үйлдэж болох вэ?

- Үдирдах ажилтан;
- Эрх мэдэл бүхий хүмүүс;
- Хамтран ажиллагсад;
- Түншүүд, харилцагчид, үйлчлүүлэгчид;
- Таних ба үл таних хүн.

АББД хаана үйлдэгддэг вэ?

- Ажлын байр, өрөө, тасалгаа;
- Ажлын байрны амралтын өрөө, коридор;

- Байгууллагын тээврийн хэрэгсэл дотор;
- Баяр ёслолын болон хүлээн авалтын арга хэмжээний үеэр;
- Томилолтоор ажиллаж байх үед зочид буудал, тээврийн хэрэгсэл дотор;
- Түнш байгууллагын албаны болон бусад өрөө, тээврийн хэрэгсэл дотор гэх мэт.

АББД яагаад илэрдэггүй вэ?

Ажлын байрны бэлгийн дарамтанд өртсөн хохирогч гол төлөв асуудлаа нуун далдалдаг. Учир нь:

- Гэр бүл, үр хүүхэд, нэр төр, алдар хүндтэй холбоотой байдаг;
- Хүчирхийлэл үйлдэгч нь эрх мэдэл бүхий этгээд байдаг;
- Ажлаас халагдах вий гэсэн айдас, түгшүүртэй байдаг;
- Бэлгийн дарамт хэзээ нэгэн цагт дуусна гэсэн хүлээлттэй байдаг;
- Хаана, хэнд хандахаа мэддэггүй гэх мэт.

Хэрэв та АББД-нд өртсөн бол хаана хандах вэ?

- Ажлын байран дахь бэлгийн дарамтанд өртсөн тухай гомдлоо тухайн этгээдийн харьяалах дээд шатны албан тушаалтан эсвэл хүний нөөцийн ажилтанд гаргах боломжтой. Мөн үйлдвэрчний эвлэлийн байгууллага болон хөдөлмөрийн маргаан таслах комисст хандаж болно;
- Ажлын байрны бэлгийн дарамт нь заавал хүчиндүүлсэн байхыг шаардахгүй бөгөөд ийм заналхийлэл нь бодитой, хохирол учруулж болзошгүй бол та өөрийн аюулгүй байдлыг хангаж цагдаагийн байгууллагад гомдлоо гаргаж болно;
- Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалдаг төрийн бус байгууллагуудад хандаж болно;
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хуулиар олгосон бүрэн эрхийнхээ дагуу ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

ХҮНИЙ ЭРХ БА ТӨРИЙН ҮҮРЭГ



Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлээс...

Хүний эрх бол хүний зэрэгтэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа юм. Өнөө цагийн төрийн үүрэг нь энэхүү баталгааг бий болгож, хүндэтгэн сахиж, хэрэгжүүлэх явдал билээ. Иймээс төр нь өөрийн улсын иргэдийн болон нутаг дэвсгэр дээр нь амьдарч буй хүн бүрийн эрх, эрх чөлөөг:

- Хүндэтгэх;
- Хангах;
- Хамгаалах үүргийг хүлээдэг.

Хүний эрхийг хүндэтгэх

Тухайн эрх, эрх чөлөөг эдлэхэд ямарваа нэгэн хууль бус, шударга бус саад учруулахгүй, зөрчихгүй байхыг ойлгодог. Жишээлбэл, үзэл бодлоо илэрхийлэх хэлбэрүүдийг хааж боох, алагчилах, хууль бусаар баривчлах, хэргийг хянан шалгах явцдаа эрүүдэн шүүх замаар мэдүүлэг авах зэргээр хүнийг хохироохгүй байх үүргийг төр, түүний албан тушаалтнууд хүлээж байдаг.

Хүний эрхийг хамгаалах

Хууль тогтоомж батлах замаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг арилгах бүтэц, тогтолцоог бий болгох гэж ойлгож болно.

Тухайлбал, хувийн компанид хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл нь хуульд зааснаас доогуур байх, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхсан бол хуульд заасны дагуу зөрчлийг арилгуулах нь төр хүний эрхийг хамгаалах үүргээ биелүүлж байгаагийн илрэл юм.

Хүний эрхийг хангах

Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх нөхцөл бололцоог төр дээшлүүлэх, сайжруулах үүрэгтэй. Ялангуяа хялбаршуулах (үйлчилгээний хүртээмжийг амар хялбар болгох), хөхиүлэн дэмжих (мэдээлэх), хэрэгжүүлэх (эмзэг бүлгийг эн тэргүүнд анхаарч, тэгш байдлыг бүрдүүлэхэд чиглэх) арга хэмжээг авна. Жишээлбэл, төрөл бүрийн үйлчилгээг нэгтгэсэн нэг цонхны үйлчилгээ, хүүхдийн тэрэг түрсэн, тэргэнцэртэй, эсвэл ахмад настай хүн, хүүхэд хүртэл явах боломжтой налуу зам, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг дүүрэг, аймгийн төвүүд дэх "Эрх зүйн туслалцааны төв"-үүдийг нэрлэж болох юм.

Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлээс...

Үндсэн хууль, олон улсын гэрээнд хүн бүрийн эдлэх ёстой эрхүүдийг баталгаажуулж, төрийн хүлээх үүргийг зааж өгсөн байдаг. Тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1-т заасны дагуу "Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг

арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй." Жишээлбэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх, эс шүтэх зэрэг хууль тогтоомжоор баталгаажуулан шууд хэрэгжүүлдэг эрх, эрх чөлөө бий.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1-т заасны дагуу "Энэхүү Пактад оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, байгаа бүх боломжийнхоо хэрээр зохистой арга хэмжээг авах үүрэгтэй" гэж заасан.

Харин сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн хамгаалал хүртэх эрх зэрэг эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх нь төрийн үйл ажиллагаа, эдийн засаг, нийгмийн хөгжил, бусад нөөц бололцооноос шууд хамаардаг. Тиймээс дээрх баримт бичигт заасан үүргийг дэлгэрүүлэн тайлбарлавал:

- а) "Дэвшилттэйгээр хангах" гэдэгт эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л эрхийг богино хугацаанд бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болохыг хүлээн зөвшөөрч, эрхүүдийг хүндэтгэн хангах арга хэмжээг нэн даруй авч аажим аажмаар хангахыг ойлгоно.
- б) "Бүх боломжийнхоо хэрээр" гэдэгт улсуудын эдийн засаг, санхүүгийн бололцоо, бусад нөөц харилцан адилгүй тул тодорхой цаг хугацааны дараа эрхүүдийг бүрэн дүүрэн хэрэгжүүлж болно. Гэхдээ үүнийг төр өөрөө хангалттай нөөц бололцоотой болох хүртлээ эрхүүдийг хамгаалахгүй гэж буруугаар тайлбарлаж болохгүй. Харин өөрийн чадах

хэрээр эрхүүдийг эдлэх явдлыг сайжруулахаар бүхий л талаар хичээх ёстой.

- с) "Зохистой арга хэмжээг авах" гэдэгт оролцогч улсууд энэ Пактад нэгдэн орсны дараа богино хугацаанд авч хэрэгжүүлэх зорилгод чиглэсэн дэвшилттэй алхам хийнэ гэсэн үг. Эрх бүртэй холбоотой нөхцөлийг харгалзан тэдгээрт тохирсон зохистой арга хэмжээг өөрсдөө шийдвэрлэн авч хэрэгжүүлэх ёстой.

Төрийн зүгээс эрхүүдийг хэрэгжүүлэхдээ төрийн үүргийг хэрэгжүүлэх нөөц, чадавх, боломж бололцоог хангасан байхын зэрэгцээ эрхүүдийн мөн чанарыг сайтар анхаарч, үзүүлэх үйлчилгээгээ хүний эрхийн тодорхой зарчимд нийцүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Хүрэлцээтэй байх: Төрийн үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар хуульчлаад зогсохгүй тухайн байгууллагын барилга байгууламж, тоног төхөөрөмж, ширээ сандал, ариун цэврийн өрөө, ундны цэвэр ус, мэргэжлийн боловсон хүчин, тэдний боломжийн цалин хөлс зэрэг асуудлыг шийдсэн байна.
2. Хүртээмжтэй байх: Ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр үйлчлэх, аливаа нэгэн үйл ажиллагаанд хүн бүр оролцох тэгш боломжоор хангагдсан эсэхээр хэмжигддэг.
3. Хүлээн зөвшөөрөгдсөн байх: Төрийн зүгээс шаардлагатай дүрэм журмыг ойлгомжтой байдлаар тогтоох, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх, төрийн үйлчилгээ авах боломжийг орчны болон мэдээллийн түвшинд бүрдүүлсэн байх зэрэг асуудлыг хамарна.
4. Цаг үетэйгээ зохицсон байх: Төрийн бодлого, үйлчилгээ нь нийгмийн өөрчлөлт, хөдөлгөөнд таарч зохицсон байна. Эмзэг бүлгийн хувьд тэдний хэрэгцээнд нийцсэн байхаас гадна тухайн үйлчилгээгээр дамжин бусад эрхүүдийг дэмжсэн байвал зохино.

Төр хүний эрхийг хязгаарлаж болох уу?

Болно. Үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалтыг тодорхой хугацаанд зайлшгүй нөхцөлд тогтоож болно. Гэхдээ энэ хязгаарлалт нь хэмжээ хязгаартай, тодорхой үйлчлэх хүрээ, газар нутаг, цаг хугацаатай байна. Үгүй бол зөрчилд тооцох бүрэн боломжтой.

Төр үүргээ биелүүлж чадахгүй бол яах вэ?

Иргэд төрийн холбогдох байгууллага, удирдлагатай хариуцлага тооцохыг шаардах, зөрчигдсөн эрхээ сэргээх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр төрөөс шаардах эрхийг баталгаажуулсан. Холбогдох байгууллага гэдэгт тухайн албан хаагч, эсвэл байгууллагын дээд шатны удирдах эрх бүхий этгээдэд, мөн энгийн болон захиргааны хэргийн шүүхэд, Хүний эрхийн Үндэсний Комисст, Үндсэн хуулийн цэцэд хандаж, өөрийн эрхээ шаардаж болно.

Эрх агуулагч, үүрэг хүлээгч гэж хэн бэ?

Ямар нөхцөлд, хэн байх, юу хийхээс үл хамааран хүүхэд өтгөс байхаас үл хамааран хувь хүн бүр эрх агуулагч юм. Үүрэг хүлээгч гэдэгт эн тэргүүнд төр, түүний байгууллагууд, төрийн албан хаагчид, бусдын өмнө үүрэг хүлээсэн хувь хүмүүс багтана.





ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССТ ГОМДОЛ ГАРГАХ НЬ

Гомдол гэж юу вэ?

"Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль"-д тодорхойлсноор "гомдол" гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь иргэдийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд энэхүү зөрчлийг арилгуулахаар зохих байгууллагад хандаж гаргасан хүсэлт юм.

ХЭҮК-т ямар гомдол харьяалах вэ?

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд зааснаар Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн тухай гомдлыг Комисс хүлээн авна. Харин дараах гомдол Комиссын харьяалалд хамаарахгүй.

- Хэрэг бүртгэл, шүүхийн шатанд болон шүүхээр шийдвэрлэсэн эрүү, иргэний хэрэг маргаантай холбоотой гомдол;
- Хувь хүмүүсийн хоорондын зан харилцааны асуудлаарх гомдол;
- Харьяалах албан тушаалтан шууд шийдвэрлэх боломжтой асуудлаар гаргасан гомдол.

ХЭҮК-т хэн гомдол гаргаж болох вэ?

- Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч;
- Хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй

бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

- Иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй, зарим буюу хэсэгчилсэн чадамжтай хүнийг түүний хууль ёсны төлөөлөгч, эцэг эх, асран хамгаалагч нь төлөөлж;
- Сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүнийг хуульд заасан төлөөлөгч нь төлөөлж;
- Төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллага төлөөлөгчөөрөө дамжуулж тус тус гомдол гаргана.

ХЭҮК-т хэрхэн гомдол гаргах вэ?

Гомдол гаргагч эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн өдрөөс, эсхүл тийнхүү зөрчигдсөн гэдгийг мэдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор гомдол гаргана.

Гомдлыг монгол хэл дээр бичгээр болон амаар гаргана. Монгол хэл мэдэхгүй этгээд эх хэлээрээ гомдол гаргаж болох бөгөөд гомдлоо Монгол хэлнээ орчуулж, зохих журмаар баталгаажуулсан байна.

Комиссын www.mn-nhrc.org цахим хаяг дахь "Гомдол гаргах" хэсэгт хандаж цахим хэлбэрээр гомдол гаргах боломжтой. Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн тухай асуудлыг утсаар хүлээн авч болно. Хүний эрхийн Үндэсний Комисст гаргах гомдол дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Гомдолд дурдагдсан асуудлыг шийдвэрлэх эрх бүхий захиргааны байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлсэн байх;
- Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжид заасан ямар эрх зөрчигдсөн болохыг тодорхой заах;

